




НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ



# АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙН ЯЛЫН БОДЛОГЫН ҮР НӨЛӨӨ



ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 22.1, 22.4 ДҮГЭЭР ЗҮЙЛ





НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ



МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН  
ХОЛБОО

## АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙН ЯЛЫН БОДЛОГЫН ҮР НӨЛӨӨ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

(Эрүүгийн хуулийн 22.1, 22.4 дүгээр зүйл)

2025 он

ННА 67  
ДАА 340  
Г-21

## **“АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙН ЯЛЫН БОДЛОГЫН ҮР НӨЛӨӨ” СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

### **Судалгааны багийн гишүүд:**

- Ш.Жолбарс, Монголын Хуульчдын холбооны гишүүн, Судалгааны багийн ахлагч
- Г.Ганбаатар, Монголын Хуульчдын холбооны гишүүн
- Д.Нямбат, Монголын Хуульчдын холбооны гишүүн
- Ж.Батмөнх, Монголын Хуульчдын холбооны гишүүн
- Г.Бямбасүрэн, Судалгааны багийн туслах ажилтан

Зохиогчийн эрх @2025: Монголын Хуульчдын Холбоо, Нээлттэй Нийгэм Форум

Энэхүү судалгааны дүгнэлт, байр суурь нь судалгааны багийн гишүүдэд хамаарах бөгөөд Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

@Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан. Энэхүү судалгаа нь зохиогчийн эрхээр хамгаалагдсан бөгөөд сургалтын зорилгоор ашиглах бол албан ёсны зөвшөөрөл авч, эх сурвалжийг дурдсаны үндсэн дээр ашиглаж болно. Үүнээс өөр зорилгоор олшруулах, олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд түгээхийг хориглоно.

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот 14240,  
Сүхбаатар дүүрэг, Л.Түдэвийн гудамж-5/3  
Утас: 976-76113207  
Факс: 976-11-324857  
Веб: <http://www.forum.mn>  
И-мэйл: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)

ISBN 978-9919-529-08-6

## **АГУУЛГА**

<b>ӨМНӨХ ҮГ</b> .....	<b>4</b>
-----------------------	----------

<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРТГАЛ</b> .....	<b>5</b>
--	----------

1.1. Судалгааны хэрэгцээ, шаардлага .....	5
---	---

<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ. АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙН ЯЛ ШИЙТГЭЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ</b> .....	<b>9</b>
---	----------

2.1. Авлигын гэмт хэргийн ерөнхий ойлголт .....	9
---	---

2.2. Чингис Хааны Их засаг, зарлигт хамаарах түүхэн эх сурвалжийн зарим зохицуулалт, онцлог .....	14
---	----

2.3. Эрүүгийн хуулийн анхдагч эх сурвалж болох “Шүүх цаазын бичиг”-үүд	19
--	----

2.4. Социалист дэглэмийн үеийн Эрүүгийн хууль (1942, 1961, 1986 он) .....	24
---	----

2.5. Ардчилсан нийгмийн үеийн Эрүүгийн хууль (1993 он, 2002, 2015 он) .....	27
---	----

<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ. АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙН ХАВТАСТ ХЭРГИЙН СУДАЛГАА</b> .....	<b>35</b>
---	-----------

3.1. Эрх, мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах.....	35
---	----

3.2. Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйл. Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах .....	51
--	----

3.3. Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйл. Нийтийн албан тушаалтан хахууль авах .....	54
--	----

3.4. Давхар зүйлчлэл (Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйл. Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах болон 22.4 дүгээр зүйл. Нийтийн албан тушаалтан хахууль авах) .....	59
Дэд хэсгийн дүгнэлт .....	62

<b>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ГАДААД ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ</b> .....	<b>65</b>
--	-----------

4.1. Бүгд Найрамдах Солонгос Улсын Эрүүгийн хууль.....	65
--	----

4.2. Оросын Холбооны Улсын Эрүүгийн хууль .....	69
---	----

4.3. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Эрүүгийн хууль.....	75
---	----

4.4. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эрүүгийн хууль.....	78
---	----

4.5. Ял оногдуулах жишиг аргачлалын талаарх зарим улсын туршлага.....	80
Дэд хэсгийн дүгнэлт .....	85

<b>СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮГНЭЛТ, САНАЛ</b> .....	<b>89</b>
--	-----------

<b>АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ</b> .....	<b>99</b>
-----------------------------------	-----------

<b>ХАВСРАЛТ</b> .....	<b>101</b>
-----------------------	------------

## ӨМНӨХ ҮГ

Эрх мэдлийн сүүдэр болсон авлига Монголын нийгэмд гүн гүнзгий шарх үүсгэж, хөгжлийн чөдөр тушаа болж, төрийн үндэс суурь болсон хуульт ёсыг ноцтой сулруулж ирлээ. Монгол Улсад төрийн өмч, нийтийн хөрөнгийг хувийн ашиг сонирхолдоо ашигласан этгээдүүдэд үйлдэлд нь тохирсон шийтгэл оноогдож байна уу хэмээх асуулт зүй ёсоор тавигдаж, иргэдийн шударга ёсны итгэл үнэмшлийг ганхуулж байна.

Монголын Хуульчдын Холбооны санаачилга, Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгтэй боловсруулсан энэхүү судалгааны тайлан нь дээрх асуултад хариулахыг зорьжээ. Хуульчдын холбооны гишүүн шүүгч, прокурор, өмгөөлөгчдөөс бүрдсэн судалгааны баг Улсын Ерөнхий прокурорын газрын архивын мэдээлэлд үндэслэн Эрүүгийн хуулийн 22.1, 22.4 дүгээр зүйлийг шүүх хэрхэн хэрэглэж байгааг нарийвчлан шинжилсэн бөгөөд авлигын хэрэг тодорхой түвшинд шүүхээр шийдвэрлэгдэж байгаа ч оноогдож буй ял шийтгэл нь гэмт хэргийн хариуцлагын зорилгыг бүрэн хангаж чадахгүй байна гэж дүгнэжээ.

Судлаачид БНСУ, ОХУ, БНХАУ болон ХБНГУ-ын туршлага, эрх зүйн практикийг тодорхой түвшинд харьцуулан авч үзэж цаашдын чиг хандлагыг тодорхойлж, санал зөвлөмж боловсруулжээ. Зөвлөмжид ялын бодлогыг тогтворжуулж, олон нийтэд ойлгомжтой стандарт, хэм хэмжээний дагуу авлигын хэрэгт ял оногдуулах нь зүйтэй гэж үзсэн байна. Энэ нь шударга ёсонд итгэл олон нийтийн итгэлийг бэхжүүлэхэд чухал нөлөөтэй.

Нээлттэй Нийгэм Форум цаашид авлигын гэмт хэрэг, түүнд оногдуулах ялыг тогтвортой байлгах, хөөн хэлэлцэх хугацааг уртасгах, хариуцлагаас өршөөл болон аливаа хэлбэрээр зайлсхийх орон зайг хумих зэрэг бодлогыг тууштай дэмжиж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйлсийг бэхжүүлэхэд өөрийн хувь нэмрийг оруулах ажиллах болно.

Судалгааны багийн гишүүн шүүгч, өмгөөлөгч, прокурор нартаа олон талын туршлага, мэдлэгээ хуваалцаж ажилласанд талархал илэрхийлье.

*П.Эрдэнэжаргал*

*Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх Захирал*

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРТГАЛ

### 1.1. Судалгааны хэрэгцээ, шаардлага

Авлига нь түүхийн аль ч үед дэлхийн улс орон бүрийн хөгжилд саад болж, ардчилал, шинэчлэлийн үйл явцыг сааруулах улмаар улс орны эдийн засаг, аюулгүй байдалд ноцтой аюул учруулахуйц хүчин зүйлсэд зүй ёсоор тооцогдсоор ирсэн ба цаг ямагт оновчтой бодлого, зохицуулалт шаардаж, бүрэн шийдвэрлэгдэхгүй өнөөг хүрчээ.

Дэлхийн улс орнууд 1990-ээд оны дунд үеэс эхлэн авлигын эсрэг тэмцэх талаарх хүчин чармайлтаа эрс нэмэгдүүлж, үр дүнд нь Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58/4 тоот тогтоолоор Авлигын эсрэг Конвенцыг баталсан билээ. Монгол Улс тус конвенцыг 2005 оны 10 дугаар сарын 27-ны өдөр соёрхон баталж, авлигын гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн бодлого, зохицуулалтыг шинэчилж, авлигын гэмт хэрэг, түүнд хүлээлгэх ял шийтгэлийн талаар Эрүүгийн хуульд зохих нэмэлт өөрчлөлт оруулсан юм.

Гэхдээ авлигын эсрэг гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, гэм буруутанд хариуцлага тооцох олон улсын туршлагын дагуу дээрх конвенцод нэгдэн орж соёрхон батлахаас өмнө буюу 1996 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Авлигын эсрэг хуулийг анхлан баталж байлаа. Улмаар 2007 онд Авлигатай тэмцэх газрыг байгуулсан түүхтэй.

Монгол Улс олон улсын жишиг хандлага болон конвенцод заасан үүргийнхээ дагуу Эрүүгийн хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого, зохицуулалт хэрэгжүүлсээр ирлээ.

Улсын Дээд шүүхийн Шүүхийн практик сургалтын хэлтсээс хийсэн 2018-2020 онд шүүхээр хянан шийдвэрлэсэн хэрэг маргааны судалгаанаас үзэхэд<sup>1</sup>:

---

<sup>1</sup> Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт багтсан авлига, албан тушаалын гэмт хэргийн талаарх судалгаа 2018-2020. Улсын дээд шүүхийн “шүүхийн практик судлалын хэлтэс”. УБ., 2021

Улсын хэмжээнд анхан шатны шүүхээр 2018-2020 оны байдлаар хянан шийдвэрлэсэн 39.443 хэргийн 0.5 хувийг авлига, албан тушаалын гэмт хэрэг эзэлж, анхан шатны шүүхүүд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22 дугаар бүлэгт заасан авлига, албан тушаалын нийт 940 хүн, 1 хуулийн этгээдэд холбогдох 359 хэрэг хүлээн авснаас 458 хүнд холбогдох 199 хэргийг хянан шийдвэрлэж, 155 хүнд холбогдох 67 хэргийг прокурорт буцааж, 27 хүнд холбогдох 11 хэргийг харьяаллын дагуу шилжүүлжээ. Шүүхээр хянан шийдвэрлэсэн 458 хүнд холбогдох 199 хэргээс 18 хүнд холбогдох 5 хэргийг хэрэгсэхгүй болгож, 42 хүнд холбогдох 12 хэргийг цагаатгасан ба 398 хүнийг гэм буруутайд тооцож, эрүүгийн хариуцлага оногдуулж шийдвэрлэсэн гэсэн статистик мэдээлэл танилцуулжээ.

Ийнхүү шийдвэрлэхдээ 60 хүнд хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж, 6 хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, 332 хүнд ял оногдуулж, үүнээс 77 хүнд хорих ял оногдуулсан байх боловч 23.4 хувь буюу 18 хүнд оногдуулсан хорих ялыг тэнсэж, хянан харгалзсан, 75.3 буюу 58 хүнд оногдуулсан хорих ялыг биечлэн эдлүүлж, 1 хүнд хорих ял оногдуулсан тогтоол биелүүлэхийг хойшлуулж шийдвэрлэсэн байна. Нарийвчилбал, 2018-2020 онд Эрүүгийн 22.1 дүгээр зүйлд заасан “эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулах” нийт 161 хүнд холбогдох 90 хэргийг хянан шийдвэрлэснээс 7 хэргийн 25 хүнийг цагаатгаж, 6 хүнд холбогдох 1 хэргийг хэрэгсэхгүй болгож, 19 хүнд хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж, 111 хүн ял шийтгүүлснээс 68.5 хувь буюу 76 хүнд торгох ял, 31.5 хувь буюу 34 хүнд хорих ял оногдуулж, 1 хүнд оногдуулсан хорих ялыг тэнссэн үзүүлэлттэй байхаас гадна тус гэмт хэрэг сүүлийн 3 жилд тогтмол өссөн үзүүлэлттэй буюу 2020 онд 3 дахин их буюу 43 хэргээр өссөн байна.

Дээрх тоо баримтаас үзэхэд сүүлийн жилүүдэд авлигын гэмт хэргийн тоо нэмэгдэж байгаа нь авлигатай тэмцэх бодлого, зорилтын илрэл мөн боловч авлигын гэмт хэрэгт оногдуулсан эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээний асуудал нь нийгэмд шүүмжлэл дагуулсаар байна.

Өөрөөр хэлбэл, авлигын гэмт хэрэг үйлдсэн албан тушаалтан, улс төрийн нөлөө бүхий хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ үйлдсэн гэмт хэргийнх нь нийгмийн аюул, учруулсан хохирол, хор уршгийнх шинж чанар, хэр хэмжээг бүрэн харгалзахгүйгээр ял оногдуулахгүйгээр тэнсэх, эсхүл торгох ял оногдуулж, харин хорих ял оногдуулах нь маш бага буюу оногдуулахгүй байх нь ял шийтгэлийн зорилго, үр нөлөөг бууруулж буй талаар төрийн өндөр дээд албан тушаалтнаас авхуулаад олон нийт цөм дургүйлхэн санаа бодол, байр сууриа удаа дараа илэрхийлж байна.

Дээр дурдсан судалгааны дүн, бусад мэдээ, статистик, шүүхийн шийдвэрийн цахим санд ([www.shuukh.mn](http://www.shuukh.mn)) нийтлэгдсэн холбогдох шүүхийн шийдвэр зэргийг харьцуулан үзэхэд олон нийтийн зүгээс илэрхийлж буй дээрх шүүмжлэл, байр суурийг үгүйсгэхэд хэцүү, бодитой гэж үзэхэд хүргэж байна.

Түүнчлэн, Монгол Улсын Их Хурлын 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга)-тай холбогдуулан эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээний дотор ял оногдуулах жишиг аргачлалыг баталж хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Улсын Дээд шүүхэд зөвлөсөн байдаг ба энэ хүрээнд авлигын гэмт хэрэгт ял оногдуулах жишиг аргачлалын талаар судалгаа хийх нь бодит хэрэгцээ шаардлага бий болсон гэж үзлээ.

Тийм учраас “Авлигын зарим гэмт хэргийн ял шийтгэлийн бодлогын үр нөлөө” судалгааг авлигын гэмт хэргийн төрлүүд, тэдгээрт оногдуулахаар заасан ял шийтгэлийн төрөл, хэмжээний талаарх Эрүүгийн хуулийн зохицуулалт буюу ял шийтгэлийн бодлогын уламжлал, шинэчлэлийг түүхчилсэн байдлаар товч харьцуулж үзэхээс гадна 2017-2023 оны хооронд шүүхээр хянан шийдвэрлэгдсэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлд заасан Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах болон 22.4 дүгээр зүйлд заасан Нийтийн албан тушаалтан хахууль авах гэмт хэрэгт хамаарах зарим шүүхийн шийдвэр, эрүүгийн хавтаст хэрэгт дүн шинжилгээ хийх, авлигын гэмт хэргийн ял шийтгэлийн бодлогод хамаарах гадаад зарим орны сайн туршлага зэргийг судлах, улмаар нэгтгэн дүгнэж тодорхой санал боловсруулан гүйцэтгэлээ.

Авлигын гэмт хэргийн ялын бодлогын үр нөлөөг буюу Эрүүгийн хуулийн 22.1, 22.4 дүгээр зүйлийн жишээн дээр өмнө нь дагнан хийсэн гэх судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл, мэдээ, баримт байхгүй болно. Харин Азийн сангийн төслийн хүрээнд 2014 онд хийгдсэн “Бодлогын түвшний авлига: Ойлголт, хандлага” гарын авлага, Азийн сангийн судалгааны багийн гишүүдийн 2021 онд хийсэн “Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээний тайлан”, Шүүхийн сургалт, судалгааны хүрээлэнгээс 2023 онд хэрэгжүүлсэн “Шүүгч-судлаач: судалгааны ажлын эмхэтгэл, Шүүхийн сургалт, судалгааны хүрээлэнгийн судлаач-шүүгч, судлаач нарын хамтын бүтээл “Хорих ялын хугацааг сонгон хэрэглэх арга зүйн талаарх судалгаа” зэргийг дотоодын судалгааны эх сурвалжаар сонгон судаллаа.

Энэхүү судалгааны зорилго нь авлигын гэмт хэрэгт оногдуулж буй ялын бодлогын үр нөлөө, түүний үндэслэл, шалтгааныг тодорхойлж, дүгнэлт, санал зөвлөмж дэвшүүлэх явдал юм.

Авлигын гэмт хэрэгт оногдуулж буй ял шийтгэл нь эрүүгийн хариуцлагын зорилгодоо нийцсэн эсэх, эрүүгийн хариуцлагын үр нөлөөг ямар арга замаар хэрхэн яаж дээшлүүлэх нь анхаарч дүгнэвэл зохих чухал асуудал юм. Тиймээс шүүхээс энэ төрлийн гэмт хэрэгт ялын бодлого баримтлахад ялын оногдуулах жишиг аргачлал шаардлагатай бөгөөд энэ нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах улмаар авлигын гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой гэж үзсэн.

Судлаачид судалгааны ажлыг кейс судлал, баримт бичигт дүн шинжилгээ хийх, харьцуулалтын зэрэг судалгааны аргуудыг ашиглан хийж гүйцэтгэлээ.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙН ЯЛ ШИЙТГЭЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ

### 2.1. Авлигын гэмт хэргийн ерөнхий ойлголт

Авлига бол дэлхийн хаа сайгүй, бүх нийгэмд оршиж байгаа хэдий ч хөгжиж буй болон буурай хөгжилтэй орнууд илүү их өртөж, өндөр хөгжилтэй оронтой харьцуулбал авлигын үр дагаварт илүү ихээр хохирч байна.

Улс орнууд авлигатай дангаараа тэмцсэнээр үр дүнд хүрэхгүй, харин олон улсын түвшинд хамтран тэмцэхээс өөр аргагүй байдлыг харгалзан 2003 онд НҮБ-аас Авлигын эсрэг конвенцыг баталжээ. Авлигын эсрэг конвенцын удиртгал хэсэгт энэхүү гэмт явдал нь аль нэг улс, үндэсний хүрээнээс хальж, бүх улс, эдийн засагт нөлөөлөхүйц үндэстэн дамнасан олон улсын үзэгдэл болж, улмаас нийгмийн тогтвортой байдлыг бий болгож, ардчилсан тогтолцоо, үнэт зүйлс, түүнчлэн ёс зүйн үнэт зүйлс, шударга ёсыг сулруулж, тогтвортой хөгжил, хууль дээдлэх ёсонд хохирол, бэрхшээл, аюул занал учруулж байгааг дурдсан байдаг.

Авлига нь “corruption” хэмээх латин гаралтай олон улсын нэр томъёо бөгөөд гажуудал, эвдрэл, завхрал, сэтгэл санааны ялзрал, хууль бус ашиг олох, хээл хахууль өгөх, авахад бэлэн байх зэрэг утгыг илэрхийлдэг. Мөн ашиг хонжоо олж авахын тулд хууль бусаар болон эрх мэдлээ хэтрүүлэх маягаар гуйвуулан ашигласан үйлдлийг хамааруулж ойлгох нь нийтлэг байдаг.

Corrupt<sup>2</sup> (коррапт)-эвдэрсэн, ялзарсан, завхарсан, худалдагдсан, гуйвуулсан, уруу татсан, хахуульдсан, зан чанараа алдсан, ёс суртахуунгүй гэсэн утгууд илэрнэ. Түүнчлэн үйл үгээр ямарваа хүн зан чанар, ёс суртахуунаа болон зарчмаа сайнаас муу руу өөрчилж, нэр хүндээ алдахыг илэрхийлэн заана.

<sup>2</sup> Black’s law dictionary. Sixth ed. 1990. P-345

Авлигын эсрэг олон улсын хэмжээнд батлагдсан мөрдөгдөж буй гол баримт бичгүүдэд дараах байдлаар авлигын нийгэмд учруулах хор уршгийг тодорхойлжээ.

Ази-Номхон Далайн орнуудын авлигатай тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөө <sup>3</sup>	Авлига нь засаглалыг хямруулдаг, хуулийг гажуудуулдаг, эдийн засгийн өсөлтөд саад болдог, эдийн засгийн өсөлтийг хангах, ядуурлыг бууруулахад саад учруулж, бизнесийн үйл ажиллагаанд өрсөлдөх чадварыг алдагдуулдаг мөн улс төр, ёс суртахууны ноцтой сөрөг үр дагавар бий болгодог.
Авлигын эсрэг Лимийн тунхаглал <sup>4</sup>	Авлига хэмээх нийгмийн энэ нэн хортой, аюултай үзэгдэл нь: <ul style="list-style-type: none"> <li>- Нийгмийн ёс суртахууныг бохирдуулдаг буюу нийгэмд шударга ёс оршин тогтнох аргагүй болгодог,</li> <li>- Нийгмийн ядуу, эмзэг хэсгийн нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын эрх эрх чөлөөг хөсөр хаяж,</li> <li>- Ардчиллыг уламдаа гишгэж, соёлт нийгэм бүрийн үндэс суурь болсон хууль тогтоомжийг үл ойшоон зөрчдөг буюу хууль эрх зүйг үгүйсгэдэг,</li> <li>- Улс нийгмийн хөгжлийг удаашруулж, нийгэм ялангуяа ядуу доройчуудыг гадуурхаж, чөлөөт эрх тэгш өрсөлдөөнийг үгүйсгэж байна.</li> </ul>
Олон улсын бизнесийн байгууллагын үйл ажиллагаанд гадаадын албан тушаалтныг хахуульдах явдалтай тэмцэх тухай конвенц	Авлигын гол хэлбэр хээл хахууль нь олон улсын байгууллага, түүний дотор худалдаа, хөрөнгө оруулалтын уйл ажиллагаанд өргөн тархсан үзэгдэл бөгөөд ёс суртахууны болон улс төрийн ноцтой завхрал үүсгэж, шударга засаглал болон эдийн засгийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлж, олон улсын өрсөлдөөнт нөхцөлийг гажуудуулдаг.

Авлигын хор холбогдлын талаар эрдэмтэн, судлаачид олон янз байдлаар судалж, тодорхойлдог бөгөөд тэдний үзэж байгаагаар, улс төр, эдийн засгийн хөгжилд засаглал, тогтвортой байдлыг тэргүүндээ тавьсан улс ихээхэн ахицтай байдаг гэжээ. Харин буурай хөгжил, эдийн засагтай улс орнуудад авлига нь нийгмийн бодит байдал болон хувирч, хамгийн их сэтгэл түгшээсэн ноцтой асуудалд тооцогддог аж. Тухайлбал Коста Рика Улсын Ерөнхийлөгч асан, Нобелийн Энх тайвны шагналт Оскар Ариас Санчес<sup>5</sup> “Авлигын хамгийн гунигтай илрэлийн нэг нь ядуу оронд ажиглагдаж байгаа бөгөөд тэнд ядуурал, хямрал, нийгэм, эдийн засгийн тэгш бус байдал оршин тогтнохын зэрэгцээ төрийн албанд авлига цэцэглэн хөгжиж байдаг” гэсэн нь олонтоо эшлэгддэг.

<sup>3</sup> Японы Токио хотод Азийн хөгжлийн банк.Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага.Япон улсын Засгийн газраас зохион байгуулсан Ази-номхон далайн 17 орны Засгийн газар хамтран хуралдаж 2001 оны 11 сард дээрх төлөвлөгөөг баталсан байна.

<sup>4</sup> 1997 онд Перу улсын нийслэл Лима хотноо авлигын эсрэг ОУ-ын 7-р бага хурал хуралдсан байх ба 94 орны 1000 гаруй төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгчид оролцон улсуудын Засгийн газар,Олон улс,бүс нутаг,дэлхийн нийт иргэдэд хандан дээрх тунхаглалыг батлан гаргажээ. Economic perspective электрон сэтгүүл. 1998.11 сар. 58-р тал

<sup>5</sup> Системы общегосударственной этики поведения. Ред. Дж.Поупа. стр I

Өөрөөр хэлбэл, хөгжлийн түвшин бүх хэлбэрээрээ сул дорой байх нь авлига эдийн засгийн системд хохирол учруулж, нийгмийн болон улс орны эрх ашигт харшлахын зэрэгцээ төрийн аппаратын гол салбаруудад авлига нь систем болон хувирсныг илэрхийлдэг байна.

Дээрх олон янзын тодорхойлолтоос үзэхэд авлига нь улс үндэстнийг доройтуулж, төрийн хүч чадлыг сулруулдагт буюу тухайн улсын эдийн засагт ноцтой хохирол учруулахуйц үр дагаврыг агуулж, төр ба нийгмийн итгэлийг хөсөрдүүлж, эд баялгийг хууль бусаар олж авахад чиглэгддэг төдийгүй хүний эрх, ардчилал, шударга ёсны үнэт зүйлсийг эвдэж, бусниулдаг, иргэдийн төрд итгэх итгэл алдарч, хууль хэрэгжихгүй байдлаар нийгмийн аюул нь илэрдэг.

Академич С.Нарангэрэл<sup>6</sup> авлига нь манай орны амьдрал ялангуяа үнэнч шударга хүн бүрд туйлын сөрөг нөлөөлөл үзүүлэх болов. Энэ нь шилжилтийг саатуулж, нийгмийн хамгаалалд зарцуулагдах ёстой их хэмжээний хөрөнгийг үрэн таран болгож байна. Төрийн дээд албан тушаалтан улс төрийн зүтгэлтнүүдийн нэр хүндийг унагаж, ардчилсан шинэчлэлтийн үзэл баримтлалд хохирол учруулж байна. Хууль ёс, эрх зүйн нэр хүнд суларлаа. Зохион байгуулалттай гэмт явдал өргөжиж, нийгэмд хэрэгжих хандлага улам бүр лавширч байна. Олон улсын харилцаанд төрийн нэр хүндийг сулруулж, үндэсний эрх ашгийг дээдлэхийн оронд олон улсын хамтын ажиллагаанаас хувийн ашиг хонжоо олохыг сонирхож хичээх болов. Энэ бүхэн нь авлига Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд ноцтой хохирол учруулж байгаа гэж үзэх үндэслэл болж байна гэж үзэхийн зэрэгцээ авлигын хор холбогдлыг үндсэн гурван түвшинд илэрч байна хэмээн үзсэн байдаг.

Харин Авлига гэх гэмт үйлдэл нь чухам ямар төрлийн гэмт хэрэг юм бэ гэдэг дээр эрдэмтэн судлаачид нэг мөр ойлголтод хүрээгүй бөгөөд дараах байр суурийг судалгаанууд дээрээс харж болно. Үүнд:

- Авлига нь илрүүлэхэд нарийн төвөгтэй, нууцлаг байдалд явагддаг төрийн шинжтэй гэмт хэрэг.<sup>7</sup>
- Авлига бол улс орны эдийн засаг, улс төр, зан суртахуун, эрх зүйн журамд сөрөг нөлөө үзүүлдэг, үндэстэн хоорондын шинжтэй нэн аюултай гэмт хэрэг<sup>8</sup>.

<sup>6</sup> С.Нарангэрэл. Монгол Улс дахь олон улсын шинжтэй гэмт хэрэг, түүний цаашдын хандлага. Шинэ төрлийн зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх асуудал сэдэвт хуралд хэлэлцсэн илтгэлүүдийн эмхтгэл.УБ.,2000.10-р тал

<sup>7</sup> Н.Жанцан. Криминологи.УБ.,2000.125-р тал

<sup>8</sup> С.Нарангэрэл. Монгол Улс дахь Олон улсын шинжтэй гэмт хэрэг түүний цаашдын чиг хандлага. Шинэ төрлийн зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх асуудал сэдэвт онол практикийн бага хурлын илтгэлүүдийн эмхтгэл.УБ.,2000. 9-р тал

- Авлигад албан тушаалаа урвуулан ашиглах тохиолдлууд, хээл хахууль авах, дарамт шахалт үзүүлэх, залилан гэх мэт төрлүүд багтана.<sup>9</sup>
- Авлигын үйлдэл нь төр бүх бүтцээрээ урт удаан хугацаанд тэмцэл явуулахаас аргагүй гэмт хэрэг.<sup>10</sup>
- Төрийн албан үүрэг, эд баялгийг хувийн эрх ашиг, зорилгод урвуулан ашиглах явдал.<sup>11</sup>
- Авлига нь их нарийн төвөгтэй гэмт хэрэг бөгөөд удаан хугацааны туршид нууц байдалд хадгалагдан бугладаг.<sup>12</sup>
- Авлигал гэдэг нь албан тушаалтан өөрт нь итгэж олгосон эрх хэмжээ, засаглалын эрх мэдлийг хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглахад чиглэсэн улс төр, төрийн удирдлагын хүрээн дэх гэмт үйл ажиллагаа мөн бөгөөд авлига бол Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн бие даасан бүрэлдэхүүн биш, албан тушаалын хэд хэдэн гэмт хэргийг өөртөө багтаасан (хээл хахууль, албан тушаалынхаа байдлыг хортойгоор урвуулах г.м) нэгдмэл ойлголт <sup>13</sup> зэргээр гэмт хэргийн ангиллын хувьд маргаантай хэвээр байна.

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1979 онд батлан гаргасан Хууль сахиулагчдын ёс зүйн дүрэмд: Үндэсний хууль тогтоомжид авлигын тодорхойлолтыг тусгах нь тухайн улсын бүрэн эрхийн асуудал боловч авлига гэдэг нь аливаа этгээд үүрэгт ажлаа гүйцэтгэх явцад эсвэл түүнтэй холбоотойгоор, бэлэг, амлалт, урамшуулал шаардан авах, эсхүл хүлээн зөвшөөрсний хариуд үйлдлийг хийх, эс үйлдэх, мөн тухайн үйлдлийг хийсний дараа ийм төрлийн буруутай төлбөр, ашиг авах явдлыг хамарч ойлгогдох ёстой. Дээр дурдсан “авлигын үйлдэл” нь авлига өгөх, авах оролдлогыг ч мөн хамруулах ба ямар ч авлигын үйлдэл нь, эрх мэдлээ урвуулан ашиглах бусад аливаа хэлбэрийн нэгэн адил, хууль сахиулах алба хаагчдын мэргэжлийн үйл ажиллагаатай үл нийцнэ. Авлигын ямар ч үйлдэл гаргасан хууль сахиулах алба хаагч нарт хууль бүрэн дүүрэн үйлчлэх ёстой. Учир нь Засгийн газар өөрийн байгууллага болон албан хаагчдаа хуулийг мөрдүүлж чаддаггүй, эсвэл хүсдэггүй байж иргэдээс хууль биелүүлэхийг шаардах боломжгүй.<sup>14</sup>

<sup>9</sup> НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн бодлогын баримт бичиг. 5,15-р тал

<sup>10</sup> Х.Хади, Барато. Коррупцийн гэмт үйлдлийг нууцаар мөрдөж мөшгих албаны үүрэг. Коррупцитай тэмцэх ОУ-ын VII бага хурлын илтгэлүүд.52-р тал

<sup>11</sup> Майкл Жонстон. Авлигын синдром. 2021, УБ., 14-р тал

<sup>12</sup> Ван Чонг-и. Коррупцийн хэргийг нууцаар мөрдөн шалгах ба илрүүлэх ажиллагаа, нотолгоо болох үр дүн. Коррупцитай тэмцэх ОУ-ын VII бага хурлын илтгэлүүд.36-р тал

<sup>13</sup> Энциклопедический юридический словарь.М.1999.стр 153

<sup>14</sup> Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх.УБ.,1996.89-р тал

Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй дэлхий нийтээрээ тэмцэх хэрэгцээ шаардлага үүссэн болохыг тодорхойлж, олон улсын хамтын нийгэмлэгээс батлан гаргасан олон чухал баримт бичгүүд байдаг бөгөөд “Авлигын эсрэг НҮБ-ын конвенц”-ын 19 дүгээр зүйлд “нийтийн албан тушаалтан албаны чиг үүргээ урвуулан ашиглах” гэмт хэргийн шинжийг, “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тухай” НҮБ-ын конвенцын 8 дугаар зүйлд “авлигын эсрэг гэмт хэрэгт тооцох” үйлдлийн шинжийг тус тус ялгаа заагтай тодорхойлон заасан байдаг.

Эрүүгийн эрх зүйн хариуцлага зайлшгүй байх хариуцлагын үүднээс авлига бол гэмт хэрэг юм. Учир нь эрүүгийн эрх зүй нь иргэдийн амгалан тайван амьдрал, эд хөрөнгийг хамгаалахын тулд эрүүгийн хариуцлагаар сүрдүүлэх замаар хангадаг.<sup>15</sup> Гэхдээ чухам ямар гэмт үйлдлүүдийг авлигын гэмт хэрэгт хамааруулах болон тохирсон ял шийтгэлийн талаар нийтлэг байдлаар тогтсон ойлголт, тодорхойлолт байхгүй байна.

Авлигын ихэнх гэмт хэрэг бодитой илэрч, шалгагдахгүй буюу илрэхгүй байх онцлогтой, нуугдмал шинжтэй учраас түүнтэй байнгын оновчтой тэмцэл явуулж, улс нийгэмд учруулах хор аюулыг нь нээн илрүүлж байж л авлигын гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг эргэн тодотгох, шинэчлэн боловсронгуй болгох бодит нөхцөл бүрдэнэ. Тухайн улсын хувьд авлигатай хэрхэн тэмцэж байгаа бодлого, авлигын хор уршиг, үр дагаврыг бодитойгоор нийтэд ил тод болгож чадаж байгаа эсэх, энэ талаарх түүхэн уламжлалт хандлага, бодлого, зохицуулалт зэргээс хамааран авлигын ямар төрөл, хэлбэрийг эрүүгийн эрх зүйн зохицуулалтад хамааруулах хийгээд тэдгээрт ямар төрлийн ял шийтгэл оногдуулах нь харилцан адилгүй байна.

Манай улсын хувьд түүхэн эх сурвалж, судалгааны бүтээлээс үзэхэд авлигын эсрэг болон авлигын гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого, зохицуулалтын түүхэн уламжлалтай бөгөөд эдүгээ хүртэл тус сөрөг үзэгдэл, гэмт хэргийн талаарх бодлого, зохицуулалт үргэлжлэн хэрэгжсээр байгаа нь авлигын нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ бол дэлхийн нийтэд түгээмэл үйлдэгддэг болохыг илтгэн харуулахын зэрэгцээ нийгэм, эдийн засгийн түүхэн хөгжлийн үе шат, түүний хувирлыг даган аливаа гэмт хэргийн мөн чанарын талаарх ойлголт хувьсан өөрчлөгдөж ирсний нэг адил авлигын гэмт явдал, түүнд хандах хандлага, бодлого, зохицуулалт өөр өөр байдлаар тодорхойлогдож, хэрэгжиж байсан нь эргэлзээгүй билээ.

<sup>15</sup> Герхард Даннекер. ХБНГУ дахь эрүүгийн ба ЭБШЭЭ-н сургалт-эрүүгийн эрх зүй. Эргэцүүлэл.1998/8-р сар.№ 2.16-р тал

## 2.2. Чингис Хааны Их засаг, зарлигт хамаарах түүхэн эх сурвалжийн зарим зохицуулалт, онцлог

Монголчуудын төрт ёс, хууль цаазын баялаг түүхэн уламжлал дэлхийн улсуудын төрт ёс, хууль цаазын түүхэнд онцгой байр суурь эзэлдэг. Монголын эртний улсууд төрийн хүчирхэг аппарат, хууль цаазыг тогтоож, зарга, зальхайг шийдвэрлэх заргач буюу шүүгчтэй байсан, тэрхүү төрт ёсны үзэл, уламжлал нь хожмын Монгол төрийн залгамж чанар болсон төдийгүй дэлхийн зарим улсад ч үлгэрлэх загвар болж байсныг түүх бичиглэлд тэмдэглэсэн нь бий.

Чингис хаан: “Хамаг улсын хулгайг гэсгээн шийтгэж, худлыг мохоон дуусгаж, үхүүлэх ёстой гэмтнийг цаазлан үхүүл. Алдаж шийтгүүлэх ёстой гэмтнийг яллан шийтгэ” хэмээн бүх улсын заргачаар Шихихутугийг түшин томилон. Бүх улсын иргэний хэрэг зарга үүсгэн заргалдсаныг Хөх дэвтэрт бичиг бичиж дэвтэрлэн ургийн ураг хүртэл Шихихутугийн надтай зөвшилцөж ёслон, хөх бичгээр цагаан цаасанд дэвтэрлэснийг бүү өөрчилтүгэй. Өөрчлөн зөрчсөн хүмүүс гэмтэн ялтан болтугай хэмээн зарлиг болруун”<sup>16</sup> гэснийг Монголын нууц товчоонд тэмдэглэжээ.

Чингис хааны тунхагласан засаг, зарлигуудыг багтааж байсны хувьд Их засаг хууль нь Монголын нэгдсэн улсын эрх зүйн гол эх сурвалж болон үйлчилж байв. Түүхэн зарим сурвалж бичиг, “Их засаг” хуулийн талаарх зарим судлаач нарын бүтээл зэргийг харьцуулан үзэхэд тодорхой төрлийн үйлдлүүдийг гэмт хэрэг гэж хуульчлан тодорхойлж, ял шийтгэл хүлээлгэхээр тогтоосон байх ба Их засаг дахь гэмт хэрэг болон ял шийтгэлийг төрөлжүүлэн ангилсан байдаг.<sup>17</sup> Тухайлбал, Ж.Вернадский: а) шашин суртахуун, тогтсон заншлын эсрэг гэмт хэрэг, б) Хаан болон төрийн эсрэг гэмт хэрэг, в) Хувь хүний амьдрал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг гэж тус тус ангилж, тэдгээрт ямар гэмт хэргүүд хамаарах хийгээд оногдуулах ял шийтгэлийг хууль зүйн үүднээс судалж, дүгнэн тайлбарлажээ.

Төрийн засаг хэрэгжиж буйн гол шинж, шалгуурын үүднээс төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны журам зөрчсөн үйлдлийг гэмт хэрэгт тооцож, ял шийтгэл оногдуулах нь эргэлзээгүй ойлголт байх бөгөөд Хаант улсын хууль цаазад холбогдох зохицуулалтын хувьд: “Өөрийн арваныг үл захирах ноёныг алж гэмт болгох”, “Хөрөнгө мөнгө эрхэлдэг түшмэдэд тэрхүү албан мөнгө хөрөнгөөс авч хэрэглэвэл алах”, “Хэрэг зөвлөх чуулган чуулахаас их ван, сайд, түшмэд саатан хоцорвол мөнгөөр яллах”, “Хөдөөгийн захирагч

<sup>16</sup> Монголын нууц товчоо (Дэлгэрэнгүй тайлбартай). УБ., 2024. 482-483-р тал, Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 1997. 63-64-р тал. С.Бадарчи. Их Монгол улсын шүүхийн уламжлал. Төр, эрх зүй №7, 3-5-р тал

<sup>17</sup> И.Дашням. Монгол Улсын төр, эрх зүйн түүх. УБ., 2005. 335-363-р тал

нар дур зоргоор ард иргэдээс алба авах, ажилд зарах, албан сан эд агуурсыг түшмэд дур авч хэрэглэвэл ял хэлэлцэх”, “Өөрийн албан тушаалыг бусдад дураар шилжүүлэх аваас гэмт хэрэгтэн болгох” зэрэг заалтууд орж байсан ажээ.

Монголын нэгдсэн улсын эрүүгийн хууль, түүнийг зөрчиж ял шийтгэл оногдуулж байсан баримт сэлтийг дүгнэн үзэхэд ял шийтгэлийн хувьд: а) Цаазаар аваачих, б) Эрхтэнг хагаслах, в) Гяндлах, г) Цөлөх, д) Бэрээдэх, е) Торгох, ё) Тушаал эвдэх хэмээн 8 төрөлтэй байжээ.

*Чингис хаан зарлиг болруун<sup>18</sup>:  
Мөнх тэнгэрийн хүчин дор бүтсэн  
Хөх Монголын Их Иаса (засаг) цаазыг  
Хаан ор залгах алтан ургийнхан  
Хүндлэн дээдэлж мөнхөд сахигтун  
Анх удаа зөрчвөл гэмийг гэмшүүл,  
Ахин зөрчвөл хатуу донгодогтун  
Гутгаар удаад алс хол цөлөгтүн  
Дахин зөрчвөл дөнгөлөн хоригтун  
Засахуйн дээдийг олонтоо зөрчвөл  
Цаазын дээдийг хэлэлцэн хэрэглэгтүн  
Засах засаглахуйн оройн дээдийг  
Хэн ч бүү зөрч, хэн ч бүү өөрчлөгтүн.*

“Их засаг”-ийг ургийн урагт хүртэл хэн ч бүү өөрчилтүгэй гэж Чингис хаан зарлиг буулгаснаас үзвэл энэхүү хууль Чингис хааны үед төдийгүй өөрийгөө залгамжлагчдын үед ч сахин мөрдөгдөх хүчин чадалтай байхаар тогтоосон нь тодорхой байна.

“Монголын нууц товчоо”, Рашид-ад-Диний “Судрын чуулган” болон монголын түүхэн зарим эх сурвалжийн судалгаанаас үзэхэд Өгөдэй хаан өөрийнхөө хаанчлах хугацаанд наад зах нь 10 гаруй хууль батлан гаргажээ. Өгөдэй хааны хуулиуд Монгол Улсын нийгмийн амьдралын өргөн хүрээг хамарч, хуулийг хүндлэх, ёсчлон биелүүлэх нь Их хаан, төрийн сайд, түшмэд, цэргийн жанжин, ихэс дээдэс, ноёд язгууртан, жирийн иргэн хүн бүрийн хуулиар тогтоосон үүрэг байжээ.

Өгөдэй хааны үеийн хууль, зарлигууд, ял шийтгэл оногдуулж байсан үйл ажиллагааг судлан үзэхүл дараах үйлдлүүдийг гэмт хэрэг гэж үзэн ял оногдуулж байсан байна. Үүнд: хааны амь нас, бие махбод, нэр төрд халдсан гэмт хэрэг, улсын тусгаар тогтнол, төрийн бүрэн эрхт байдлын эсрэг гэмт хэрэг, цэргийн гэмт

<sup>18</sup> Ц.Нацагдорж. Чингис хааны зарлигийн товчоон. УБ., 2006. 119-р тал

хэрэг, засаг захиргааны эсрэг гэмт хэрэг, аж ахуйн гэмт хэрэг, эд хөрөнгө, мал сүргийн гэмт хэрэг, байгаль хамгаалал, зан заншлын эсрэг гэмт хэрэг, хулгайн гэмт хэрэг, алба татварын гэмт хэрэг, өртөөний журам зөрчсөн гэмт хэрэг зэрэг гэмт хэргийн төрлүүд байжээ. Тухайлбал, “хэвтүүлийг их хаанаас ангид дайнд явуулах”, “хишигтэн үүргээ эс биелүүлэх”, “тогтоосон хүнс, шүүсний хэмжээг хэтрүүлэн хэрэглэх”, “хууль зөрчсөн буюу хахууль авсан зэрэг үйлдлүүдийг гэмт хэрэг хэмээн тогтоож, тэдгээрийг үйлдэгсдэд ял шийтгэл ногдуулахаар заасан байдаг. Мөн гаалийн хууль зөрчсөн буюу хахууль авсан хүнийг 2 жил хүртэл гянданд хорих ял оногдуулж байжээ.

Өгөдэйн хаанчлалын үед Их Монгол Улсад дараах ялыг хэрэглэж байсан нь сурвалж бичиг, зохиол бүтээлүүдэд дурдагдан тэмдэглэгдсэн байна. Үүнд: 1. Бэрээдэх, 2. Нударгалах, 3. Торгох, 4. Жанчих, 5. Хол газар, нүдний далд цөлөх, 6. Гянданд хорих, 7. Алах (цаазлах) гэсэн ялууд байжээ.

Гүюг хаан мөн Чингис, Өгөдэй хаадын баталсан хууль, зарлигуудыг хэвээр нь дагаж мөрдөхийг зарлигласан байна. Гүюг хаан өөрийгөө хаанд өргөмжлөх үеэр “Эцгийнхээ гаргасан бүх хуулийг хүчин төгөлдөр гэдгийг батлан хэлээд хааны улаан тамгатай зарлиг бүхнийг түүнд илтгэлгүйгээр шууд үсгээ зурж бай” (49.135) гэж тушаажээ. Гүюг хаан Монгол Улсад хууль зөрчигдөж, дур зоргоороо авирлах, хахууль шан өгөх, шударга ёсыг огоорон амин хувиа хичээх, алба тушаалын төлөө ил, далд тэмцэлдэх явдал дэлгэрч буйг анхааралдаа авч шийдвэртэй арга хэмжээ авч таслан зогсоож байжээ. Тухайлбал, хууль бусаар төрийн өндөр алба тушаалыг эзэлж, төрийн ажлыг хуурмагшуулсан сайд түшмэд, тэдний хань хамсаатныг цээрлүүлэн шийтгэх тухай зарлигууд гаргаж, хэрэгжүүлсэн нь төрийн албаны нэр хүндийг дээшлүүлж, хууль ёсыг хангасан хэрэг байв.

Гүюг хааны засаглалын үед ялын дараах хэлбэрүүдийг хэрэглэж байв. Энэ нь цаазаар авах, туйвандах, эрх тушаалыг нь эвдэх, ташуурдах, жанчих, боол, шивэгчин болгох, сануулан анхааруулах, эд хөрөнгө, газар нутгийг нь хураах, торгох ялууд болно.

Плано Карпинийн “Монголчуудын түүх”-д дурдсанаар ял оногдуулбал зохих 40 шахам гэмт үйлдлийн ихэнх нь цаазаар авахаар ял оногдуулж байсан аж.

Их засаг хуулийг “намайг залгамжлагчдын үед ч нарийн чанад сахин биелүүлж байхыг” зарлигласан эзэн Чингисийн зарлиг Мөнх хааны үед ч хатуу мөрдөгдөж байжээ. “Их бага үйлийн алинд ч Чингис хааны ёс, Засаг хуулийг чандлагтун” хэмээсэн Мөнх хаан зарлиг болгожээ. Мөнх хааны төрийн ял шийтгэлийн бодлого эл үеийн гэмт хэрэг, түүнийг илрүүлж шалгах, гэмт этгээдэд ял шийтгэл оногдуулах, түүнээ эдлүүлэх ажиллагаанд илрэлээ олж, эрх зүйн

хэм хэмжээгээр тодорхой заагдсан байжээ. Тухайлбал, үймээн самуун гаргах, хааны зарлиг тушаалд үл захирагдах, хууль бусаар алба татвар хураах, тал тохой татах, хээл хахууль авах зэрэг олон үйлдлийг гэмт хэрэг мөн гэж тогтоож, төрийн хатуу ял шийтгэлийг хэрэглэж байжээ. Эх сурвалжид тэмдэглэснээр: цаазлах (алах), гянданд хорих, шийдэмдэх (зодох), тусгай газар нутаг суулгах, хөрөнгийг нь хураах, албан тушаалаас нь огцруулах ялуудыг хэрэглэж байж.

Хамгийн чухал нь Хасан хааны зарлигийн дагуу нэрт эрдэмтэн, судлаач, шүүгч нар хамтран зөвхөн торгууль агуулсан хуулийн бүх заалт, оногдуулж болох интервалийн хүрээнд торгуулийн олон хувилбар бүхий баримтын (шийдвэрийн) загварууд, түүнд хамаарах зохист номлолыг туурвиж, улмаар эмхэтгэн шүүгч нарт гарын авлага болгож байсан нь анхаарал татаж байгаа юм. Энэ талаарх нийтлэлээс эш татвал:

Мөнх хаан “Хуралдай”<sup>19</sup> хуралдуулан Хубилай, Хүлэгү хоёрыг өөрийн баруун, зүүн гар болон суухыг зарлиг болгон Хүлэгүг Иран, Сири, Мисир, Анатоли, Армени зэрэг улс тийш илгээж<sup>20</sup>, Их бага үйлийн алинд ч Чингис хааны ёс, Засаг хуулийг чандлагтун, эрхт тэнгэрийн хүчээр самуун дайсныг дарж, түгэх алдраа нар мэт мандуулагтун хэмээжихүй.<sup>21</sup>

Хүлэгү бээр Мөнх хааны зарлигийн дагуу монголчуудын уламжилж ирсэн түүхэн тактикийг хэрэгжүүлсэн аж.<sup>22</sup> Тус байлдан дагууллаас хойш Чингисийн угсааны Хүлэгү, Авага, Тэгүдэр, Аргун, Гайхату, Хасан, Өлзийт хэмээх хан хөвгүүд хаанчилсан “Ил хаант” улс оршсон түүхтэй билээ. Хүлэгү, түүний залгамжлагч хаад Ил хаант улсыг засаглан тохинуулахдаа Чингис хааны ба түүний залгамжлагч хаадын зарлиг-Засаг хууль,<sup>23</sup> Ил хаадын зарлиг-Засаг хуулийг эх сурвалж, чиглэл болгож буюу монголын эзэнт гүрний алтан аргамжийн бодлогыг ямагт сахиж, тухайн засаглаж буй улсын ёс, хууль зүйтэй уялдуулан зохицолдуулах бодлого, зарчим баримталж байсан нь түүхэн эх сурвалжид тэмдэглэгджээ.

Их, Ил хаадын Засаг хууль хийгээд тухайн улсын ёсыг баримтлан гаргасан Хасан хааны зарлиг бол тухайн улс дахь дээд хүчин чадалтай “Засаг хууль” бөгөөд дарангуйлал, хэрцгийлэл, луйвар, бусармаг хэрэг, хүний эрхэд халдсан ёсон бус элдэв явдлыг хориглон, төрийн хэргийг төвшитгөхийн төлөөх хэрэгжүүлсэн цогц бодлого, зохицуулалт нь “Хасан хааны шинэчлэл” хэмээн түүхэнд нэрлэгдэн үлджээ.

<sup>19</sup> Эртний Монголын эзэн хаанаа сонгох хуралдай нь тогтмол бус хуралддаг, эзэн хааны эрх мэдлийг хүлээн зөвшөөрдөг цуглаан байсан. П.Амаржаргал. Парламентын бүрэн эрх: төлөвшил, хөгжлийн чиг хандлага., УБ., 2016. 185 дахь тал

<sup>20</sup> Шашдирын чуулган (гутгаар дэвтэр).., орчуулсан Г.Аким., Улаанбаатар., 2020. 671 дэх тал

<sup>21</sup> Шашдирын чуулган (гутгаар дэвтэр).., орчуулсан Г.Аким., Улаанбаатар., 2020. 673 дахь тал

<sup>22</sup> Томас Т.Алсен. Монгол империализм.., орчуулсан Г.Батсүх., Улаанбаатар., 2020. 101 дэх тал

<sup>23</sup> Монголын эзэнт гүрний Их хаадын болон Ил хаант улсын хааны зарлиг зарлиг бол “Засаг хууль” байсан гэсэн утгаар авч үзсэн болно.

Хасан хааны зарлиг<sup>24</sup>: Манай агуу их өвөг Чингис хаан бээр эрхт тэнгэрийн хүчин дор их суу залийн ивээлд цолгорсон бөлгөө. Тэрээр Их засаг хуулиа үсний төдий ч гажуудалгүй мөрдөж, нэгэнт зарлиг буулгаваас нүүр бууруулан, нуруугаа харуулах, үнэний мөрөөс гажин алхах зүрх зориг хоёр хөлт хохимой толгойтон хэнд боловч байсангүй билээ. Бидний сайн эцэг, өвөг эцэг нар ч үр хойчис бидэндээ энэ улсыг засан тохинуулж, захиран жолоодтугай хэмээн итгэн даалгасан болой. “Их засаг” хууль хийгээд энэ улсын ёсыг зохих ёсоор баримтлан мөрдөж, дэлхийг авч явах гэж махран зүтгэсээр чингэж чадсан хөвгүүд бүрийнх нь сайн нэр эргэх цагийн хуудаснаа үлдсэн ажгуу. Засаг хуулийг баримталбаас их хэрэг аяндаа урагш ахих бөлгөө.

Гучин жил өнгөрсөн бол хэрэг заргыг авч хэлэлцэхгүй, хэрэгсэхгүй болгох буюу хэрэг заргын хөөн хэлэлцэх хугацааг 30 жилээр тогтоон мөрдүүлсэн нь ач холбогдлоо одоо ч алдаагүй оновчтой, уламжлалт бөгөөд шинэлэг бодлого, зохицуулалт байжээ.

Хасан хаан<sup>25</sup>: Өдийгөөс урьдын хаадын үед бүх зарлиг бошигт 30 жилээс хэтэрсэн зарга заалхайг огт авч хэлэлцэхгүй, хэрэгсэхгүй байхыг заасан байтал энэ явдлын учрыг ёроол уудлан тодруулахгүй байсаар өнөөг хүрч ирсэн баймуй. Манай зон олны дотор удтал урхагшсан эээрхэг ёс, шударга бус явдал, элдэв луйвар, худал хуурмаг, хууль бус үйлдлийн гай тоггор халдварлан тархах болжухуй. Одоо бид эдгээрийг авч үзэж, бидэнд илтгэхийг шүүгч нарт зарлиг болж баймуй. Шударга бус явдал, луйвар, хавчлага гадуурхал, хууран мэхлэх, нэр зээлдэх, худал заргын үндсийг таслах, хаах зорилгоор “Гучин жил болж хуучирсан заргыг хэрэгсэхгүй болгох тухай” зарлиг ил болгон нийт албат, иргэн дор хүргэтүгэй, мэдтүгэй.

Албан тушаалтны сахилга, хариуцлагыг хууль цаазын хүрээнд чангатгаж, ерөнхий зарчмын хүрээнд бүх хэргийг нарийвчлан ангилж, “том хэрэг” буюу албан тушаалын хэрэг хийсэн бол хэд дахин илүү ял оноох бодлогыг тусгайлан боловсруулж хэрэгжүүлсэн байна.

Их засаг хууль болон эрүүгийн шүүх үйлчлэхгүй байж, ихээхэн зөрчилтэй болсон аваас байдлыг засахын тулд бага асуудлаас эхлэх ёстой, чингэхдээ дэлхийн хүн зонд юуг мэдрүүлэх гэвэл “том хэрэг” хийсэн хүнд хэд дахин илүү ял оноох ёст болой. Ерөнхий зарчмыг баримтлах аваас бүх хэргийг нарийвчлан ангилбал зохилтой. Албан тушаалтан байна гэдэг нь ёсон бус авирлах, бусармаг хэрэг үйлдэх, мөнгө зоосны боол байх бус гагцхүү хууль цаазад захирагдах,

<sup>24</sup> Шашдирын чуулган (гутгаар дэвтэр)..., орчуулсан Г.Аким., Улаанбаатар., 2020. 1111, 1153 дахь тал

<sup>25</sup> Шашдирын чуулган (гутгаар дэвтэр)..., орчуулсан Г.Аким., Улаанбаатар., 2020. 1036-1037 дахь тал

иргэдэд тэгш, шударга үйлчлэх хийгээд хамгийн дээд хариуцлага хүлээх ёст болохыг хатуу сануулан чанд мөрдүүлж, хэрэгжилтэд нь онцгойлон хяналт тавьж байжээ.

Хуулийн хамгийн зөв заалтыг баримтлан баримт<sup>26</sup>-ыг нэг загвараар бичих, бүх хэргийг бүгдэд ил болгох хэрэгтэй. Шүүгч баримтыг нэг загвараар бичихэд хуулийн бүх заалт, торгуулийг агуулсан загварууд бүхий эрдэмтдийн зохист номлолын эмхэтгэл<sup>27</sup>-ийг харгалзана.<sup>28</sup> Шүүгч түүнийг анхлан нягтлаад, энэ нь түүний хүссэнтэй таарч, хуульд нийцэж байвал мөн нэрээ нэмж, түшмэдийг ямар ч учраар загварыг гажуудуулахгүй байх болгосугай, чингэхдээ хуулгыг үг үсэгчлэн хэрэгт хийх ёстой. Хэрэв шүүгч шинэ бичиг шийтгэх болбол бидний гаргасан тусгай зарлигийн дагуу хуучныг үнэний шүүхийн шүүлтүүрээр оруулан сайтар шүүтүгэй.

### 2.3. Эрүүгийн хуулийн анхдагч эх сурвалж болох “Шүүх цаазын бичиг”-үүд

Монгол Улсын анхдугаар Их хурал 1924 онд анхны Үндсэн хуулийг баталж, мөн хуулийн 4 дүгээр зүйлд “Улсын шүүн таслах газрууд хэргийг явуулах үүргийн хэмжээ, мөн иргэний ба эрүүгийн хууль зүйг тогтооно” гэж зааснаар Үндсэн хуульд нийцүүлэн эрүүгийн бие даасан буюу төрөлжүүлсэн хууль бий болох эрх зүйн үндэс бүрдсэн байна.

1926 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Ардын Засгийн газрын хурлаар Шүүх цаазын бичгийн ерөнхий ангийг баталж, улмаар мөн оны 11 дүгээр сард Улсын III их хурлаар тусгай ангитай нь хамтатган Шүүх цаазын бичгийг батлан гаргаснаар анхны Эрүүгийн төрөлжсөн хуультай болсноос гадна эрүүгийн эрх зүйн онол хөгжих суурь тавигдсан чухал үйл явдал байв. Авлигын эсрэг гэмт хэрэгт хамааруулж болох зарим гэмт хэргийн шинж, хүлээлгэх ял шийтгэлийг тодотгон авч үзвэл:

<sup>26</sup> Шашдирын чуулган (гутгаар дэвтэр).., орчуулсан Г.Аким., Улаанбаатар., 2020. 1032 дахь тал

<sup>27</sup> Шашдирын чуулган (гутгаар дэвтэр).., орчуулсан Г.Аким., Улаанбаатар., 2020. 1047 дахь тал  
Шударга ёсны гажуудлын харгайгаар худлыг сайшаан, зөвийг буруушааж таардаг. Тус гажуудлыг арилгахын үүднээс бид ордод хичнээн төрлийн баримт бичиг үйлдсэнийг гүйлгээ ухаанаараа тогтоохыг зарим шүүгч, түшмэл, эрдэмтэй хүмүүст зарлиг болж, тэд боломжийн бүх заалт, торгуулийг агуулсан загварыг төрөл бүрт, эдгээрийг эсэргүүцэхээргүй, шүүмжлэхээргүй тохируулан зохиож, олон ашигтай санаа оноог багтаасан зохист номлолыг нэмэн үйлдтүгэй. Тэд загваруудыг нэгэн ботид хурааж, гаргуун эрдэмтэн мэргэд нэрээ тавин цохож, зөв болохыг нь баталгаажуулсугай.

<sup>28</sup> Тухайн загварыг үндэслэх албагүй буюу хуульд нийцэхгүй гэж үзвэл шинээр шийдвэр гаргахаар байх тул харгалзаж байжээ.

147 дугаар зүйл: Аливаа албаны хүн эрх тушаалдаа эрдэж албан яамны зэрэг газрын хэрэг явдалд саатал, боогдол болгох ба ард олны амгалан тайван байдлыг сахих хууль дүрмийг зөрчих ба бусдын эрх чөлөө ба эд хөрөнгөнд халдах, ашгийг хичээж цааз хуулийг зөрчих, айлган сүрдүүлж дарлах аваас 1 сараас 2 жил хүртэл гянданд хорих буюу 50-1200 төгрөг хүртэл торговол зохино.

150 дугаар зүйл: Албан тушаалтан аливаа хэргийг тушаалын эрх хэмжээний ёсоор үл гүйцэтгэвээс 6 сар хүртэл гянданд хорих буюу 25-300 хүртэл төгрөгөөр торгоно. Хэрвээ онц хүндэтгэх учир буй аваас 1-3 жил хүртэл гянданд хоривоос зохино.

158 дугаар зүйл: Аливаа албан газар...ард түмнээр байгуулагдсан газруудад албан хаагчид элдэв арга хэрэглэж бусдаас эд хахууль авцгаах тухай санал гаргаж завсраа зөвлөлдөх ба хахуульд эд буюу мөнгө зоос ба бусад үлэмж үнэ бүхий юмыг авбал 1-5 жил хүртэл гянданд хорихоос гадна хэргийн учрыг үзэж түүний хувийн хөрөнгө хогшлын заримыг албадан хурааж болно.

159 дүгээр зүйл: Аливаа албан хаагчид энэхүү цаазын бичгийн 158 дугаар зүйлд заасан ял бүхий хэргийг үйлдэхэд:

1. Улсын санхүүд хохиролтой болгосон ба эцэстээ хохиролтой болгох
2. Урьд одоо эд хахууль авч шийтгэгдсэн
3. Олон удаа эд хахууль авсан боловч эс илрэгдсэн
4. Эд хахуулийг айлган хяхах зэргээр авсан зүйл байвал 3-10 жил хүртэл гянданд хорихоос гадна түүний хөрөнгө хогшлыг бүрэн буюу заримыг албадан хураамой.

160 дугаар зүйл: Эд хахууль авсан албаны хүмүүс дээд тушаалын буюу төв газруудаас томилсон түшмэд ба шүүх таслах газрын түшмэд ба байцаагч, ардын төлөөлөгчид, дотоодыг хамгаалах газрын эрх баригчид ба байцаагч, төлөөний хүмүүс, цагдан сэргийлэх газрын түшмэд, цагдаа нар ба гяндангийн газрын албан хаагчид, манах сахих цэрэг, хуягууд болох аваас 5-10 жил хүртэл гянданд хорихоос гадна түүний хөрөнгө хогшлыг бүрнээ албадан хурааваас зохино.

161 дүгээр зүйл: Эд хахууль өгөгсөд ба зуучлагчдын зэрэг холбогдол бүхий хүмүүсийг 2 жил хүртэл гянданд хоривол зохино.

162 дугаар зүйл: Энэхүү цаазын бичгийн 161 дүгээр зүйлд дурдсан хүмүүсийн дотор мөнхүү хэргийг олон удаа үйлдсэн ба үүрдийн ажил болгосон аваас 1-3 жил хүртэл гянданд хорино. Хэрвээ уг хэрэг нь энэхүү цаазын бичгийн 159 дүгээр зүйлд заасан явдалд холбогдол бүхий бол 3-7 жил гянданд хорихоос гадна түүний хөрөнгө хогшлын заримыг буюу бүрнээ албадан хураавал зохино.

163 дугаар зүйл: Албан яамны газрын албан тушаалтан хэрвээ бусдыг цэст гэрчлэн унагаах саналаар элдэв муу арга хэрэглэн явж, эд хахууль өгөхөд хүргүүлбэл 1-6 жил хүртэл гянданд хорино.

164 дүгээр зүйл: Аливаа албан тушаалтан энгийн бэлэг ба шагнал хэмээх зэргээр нэрийдэж аливаа зүйлийн эд хахууль авсан бол 1-5 жил гянданд хорино.

165 дугаар зүйл: Улсын ба ард олны хөрөнгө хогшлоор байгуулагдсан газруудын тэргүүлэгчид ба тэдний орлогчид жич: мөнхөө газруудын төлөөний хүмүүс аливаа аж үйлдвэрийг муугаар явуулах ба ноогдсон албан тушаалыг үл хайхрах зэргээр гэм гарч уг газруудад хохирол болговол 3 сараас 3 жил хүртэл гянданд хорихоос гадна хувийн хөрөнгө хогшлоос тэрхүү хохирлыг нөхөн төлүүлнэ.

166 дугаар зүйл: Хэрэв дээрх зүйлд дурдсан хүмүүс гагцхүү өөрсдийн ашгийг хичээж явсаар буюу бусад лугаа зөвлөлдөж тэр мэт гэмт явдлыг үйлдсэн бол 3-8 жил хүртэл гянданд хорихоос гадна тэдний хувийн хөрөнгө хогшлоос уг хохирол сүйтгэлийг нөхөн төлүүлж, үлдэх хөрөнгийг заримыг буюу цөмийг албадан хураавал зохино.

Дээрхээс үзэхэд Шүүхийн цаазын бичгийн тусгай ангид<sup>29</sup> хэдийгээр “төрлийн объект”-ын хувьд өөр зарим гэмт хэргийг нэг бүлэгт хамааруулсан шинжтэй боловч авлига, албан тушаалын зарим гэмт хэргүүд, хүлээлгэх ялын төрөл, хэмжээг хуульчлан тогтоосон нь хамгийн чухал алхам болсон байна. Тухайлбал, “аливаа албаны хүмүүс гэмт явдлаар явах нь” 21 дүгээр бүлгийн 147-157 дугаар зүйл, “эд хахууль авах ба өгөх нь” 22 дугаар бүлгийн 158-164 дүгээр зүйл, “улсын ба ард олны хөрөнгийг сүйтгэх нь” 23 дугаар бүлгийн 165-168 дугаар зүйлд тус тус тодорхой төрлийн гэмт хэргийн шинжийг заасан байгаа нь онцлог байна.

**1929 оны Шүүх цаазын бичиг<sup>30</sup>:** Тус хууль нь 1926 оны Шүүх цаазын бичгийг шинэчлэн найруулсан, бүтэц агуулгын хувьд өмнөх хуулиас ялгагдах үндсэн өөрчлөлтгүй боловч гэмт хэрэг, ялын асуудлыг эрүүгийн эрх зүйн онолын зохих түвшинд боловсронгуй болгосон буюу шинэчлэлтийг нарийвчлан тусгасан байна.

Харин тусгай ангийн “Аливаа албаны хүн гэмт явдлаар явах нь” бүлэгт хамаарах “албан тушаалтан аливаа хэргийг тушаалын эрх хэмжээний ёсоор үл гүйцэтгэвээс гэмт хэрэгт оногдуулах ялыг 1 жил хүртэл хорих болгон өөрчилж,

<sup>29</sup> Б.Баярсайхан нар. Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. УБ., 2011. 281-310-р тал

<sup>30</sup> Б.Баярсайхан нар. Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. УБ., 2011. 310-343-р тал

мөн “Аливаа албан тушаалтан албаны буюу ард олноор байгуулсан газраас тусгай тушаасан ёсоор аливаа хэрэг явдлыг гүйцэтгэж буй этгээд өөрийн эрхлэн хадгалваас зохих мөнгө, зоосны зэрэг аливаа үнэ бүхий зүйлүүд буюу хөрөнгө хогшлыг хувьд ашиглах зэргээр сүйтгэвээс 6 сараас 3 жил хүртэл хорих болон дээрх гэмт хэргийг үйлдсэн албан тушаалтны зэрэг хүмүүс **онц эрх бүхий этгээд болох** буюу улсын онц үнэ бүхий чухал зүйлийг тийнхүү ашиглах зэргээр сүйтгэвээс 2 жилээс доош бус хорьж хөрөнгийг албан хураана.

Тайлбарлах нь: “Онц хүндэтгэх учир шалтгаан буй аваас буудан ална.” гэсэн гэмт хэргийн шинж, түүнд оногдуулах ял шийтгэлийг шинээр хуульчлан тогтоожээ.

**1934 оны Шүүх цаазын бичиг<sup>31</sup>:** Шүүх цаазын бичгийн зорилтыг анх удаа тодорхойлж, улмаар тухайн цаг үеийнхээ шаардлагад нийцүүлж зарчмын шинжтэй бөгөөд дэвшилтэт олон өөрчлөлт, шинэчлэлтийг хийхэд чиглэгдсэн, тухайлбал, түүний системийг нийгмийн харилцааны тодорхой төрлөөр ялган ангилах асуудлыг боловсронгуй болгож өгсний зэрэгцээ тодорхой төрлийн гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжид зохих өөрчлөлт оруулсан зэрэг нь шинэчлэлийн онцлогийг илэрхийлж байна.

1934 оны Шүүх цаазын бичигт өмнөх хуулийн “аливаа албаны хүмүүс гэмт явдлаар явах нь” 21 дүгээр бүлэг, “эд хахууль авах ба өгөх нь” 22 дугаар бүлэг, “улсын ба ард олны хөрөнгийг сүйтгэх нь” 23 дугаар бүлэгт заасан зарим тодорхой төрлийн хэргүүдийг нэгтгэн төрөлжүүлж, мөн зарим төрлийн гэмт хэргийг шинэчлэн тогтоож улмаар “Албан тушаалын гэмт хэргүүд” гэсэн 3 дугаар бүлгийг бий болгон нийт 94-105 зүйлд гэмт хэргийн шинжийг хуульчилжээ. Тухайлбал, Гуравдугаар бүлэг: Албан тушаалын гэмт хэргүүд:

Зүйл 94. Албан тушаалтнаас гагцхүү өөрийнхөө албан тушаалын байдлыг ашиглан далимдуулж хууль бус явдлуудыг үйлдэх, хэрэв түүний улмаас албан ба үйлдвэрийн газрын зүй зохистой бөгөөд журамтай ажлыг зөрчих буюу эд хөрөнгийн хохирол сүйтгэлийг учруулах эсхүл олон нийтийн журам байдал, хэн нэгэн ард иргэний эрх ашгийг зөрчих эсвээс хэрэв ашгийг хичээж үйлдсэн ба албан тушаалын эрх, албан тушаалын байдлыг хортойгоор урвуулан хэрэглэсэн бол 6 сараас эхлэн 5 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэвэл зохино.

Зүйл 95. Албан тушаалтнаас уул тушаалын эрх ба тусгайлан олгосон эрхээ эрх хэмжээнээсээ илтэд хэтрүүлсэн...бол 6 сараас 5 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэвэл зохино.

<sup>31</sup> Б.Баярсайхан нар. Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. УБ., 2011. 344-354-р тал  
Д.Адъяабазар. Монгол Улсын 1921 оноос хойшхи эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. УБ., 1998. 69-101-р тал

Хэрэв тийнхүү тушаалын буюу тусгайлан олгосон эрхийг хэр хэмжээнээсээ хэтрүүлэн хэрэглэхдээ бусдыг хүчирхэн дарлах буюу уул хохирогч этгээдийн биеийг зовоох ба нэр алдрыг нь доромжлох явдлыг гаргасан бол 2 жилээс доошгүй хугацаагаар хорих ял шийтгэвэл зохино.

Зүйл 96. Албан тушаалтнаас өөрийнхөө албан үүргийг ёсоор гүйцэтгэвэл зохих явдлуудыг үл гүйцэтгэсэн...бол 3 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэвэл зохино.

Зүйл 100. Албан тушаалтны буюу улсын болон олон нийтийн газраас даалгаснаар алив нэг үүргийг гүйцэтгэж яваа хүмүүсээс албан тушаалын байдалдаа эсхүл гүйцэтгэх үүрэгт эрдэж түүний биед эрхлүүлж буй мөнгө ба үнэ бүхий зүйлүүд хийгээд бусад хөрөнгө хогшил зэргийг хувьдаа ашигласан бол 5 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэвэл зохино.

Мөнхүү явдлуудыг үйлдсэн албан тушаалтан нь түүнд олгосон **“онц хариуцлага бүхий хүн”** байх ба түүнчлэн улсын онц чухал үнэ бүхий зүйлүүдийг хувьд ашигласан болох буюу эсвэл ашигласан үрэгдсэн нь онц их хэмжээтэй бол 2 жилээс доошгүй хугацаагаар хорьж хөрөнгийг нь хураах ял шийтгэвэл зохих ба хэрэв улсын эдийн засагт хортой санаагаар тийнхүү ашигласан, үрэгдүүлсэн зэрэг хүндэтгэн үзэх шалтгаан байвал буудан алж хөрөнгийг хурааж шийтгэвэл зохино.

Зүйл 101. Албан тушаалтнаас өөрийн албан тушаалын байдлыг гүйцэтгэсэн буюу эс гүйцэтгэвэл зохих байсан явуулгыг эд хахууль өгсөн этгээдийн ямар нэгэн ашиг тусыг бүтээж гүйцэтгэхээр буюу эсвэл гүйцэтгэвэл зохих зүйлүүдийг мөн түүнчлэн ашиг тусыг бодож үл гүйцэтгүүлэхээр ямар ч янзын эд хахуулийг өөрийн болон бусдаар уламжлуулан авсан бол 5 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэвэл зохино. Энэхүү явдлууд нь:

1. Эд хахуулийг авсан этгээд нь хариуцлагатай албан тушаалтан
2. Эд хахууль авсны учир урьд ял шийтгэгдсэн буюу эд хахуулийг хэд хэдэн удаа авсан этгээд
3. Эд хахууль авахдаа оролдон занаж гаргуулж авсан бол 3 доошгүй хугацаагаар хорьж хөрөнгийг бүрэн буюу заримыг хурааж ял шийтгэвэл зохино.

## 2.4. Социалист дэглэмийн үеийн Эрүүгийн хууль (1942, 1961, 1986 он)

1942 оны Эрүүгийн хуулиар нийгэм, төр, байгууллага, иргэдийн өргөн агуулгатай эрх ашиг, сонирхлыг хамгаалалтад авсан ялангуяа хувийн өмчийн эрхийг хамгаалах болсон нь дэвшилттэй байжээ.

Тус хуулийн 4 дүгээр бүлэгт<sup>32</sup> “Албан тушаалын гэмт хэргүүд”-ийг заасан байх ба гэмт хэргийн шинжийн хувьд онцлох өөрчлөлтгүй, харин зарим гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийг чангаруулсан байна. Тухайлбал;

123. Албан тушаалтнаас гагцхүү өөрийн албан тушаалын байдлыг ашиглан далимдуулж хууль бус явдлыг үйлдсэний улмаас албан ба үйлдвэрийн газрын хэвийн ажиллагааг зөрчих буюу тэрхүү албан ба үйлдвэрийн газарт эд хөрөнгийн талаар хохирол сүйтгэл учруулах, эсвэл олон нийтийн журам байдлыг зөрчих буюу хэн нэгэн ард иргэний хуулиар хамгаалуулан байгаа эрх ашгийг эвдэх үүнд эл явдлыг албан тушаалтан хүнээс үргэлжид буюу хувийн ашгийг хичээн засгийн эрх буюу албан тушаалын байдлыг хортойгоор урвуулан хэрэглэсэн байвал **10 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэвэл зохино.**

124. Албан тушаалтнаас засгийн эрх буюу албан тушаалын эрхээ хэр хэмжээнээс илт хэтрүүлсэн нь энэхүү хуулийн 123 дугаар зүйлд заасан шинж байдал бүхий байвал 10 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэвэл зохино.

Хэрэв тийнхүү засгийн буюу албан тушаалын эрхийг хэр хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэхдээ бусдыг хүчирхэн дарлах, зэвсгийг хэрэглэх буюу уул хохирсон хүний биеийг зовоох ба хувийн нэр хүндийг доромжлох явдлыг гаргавал 3 жилээс доошгүй хугацаагаар хорьж шийтгэх ба хэрэв хүндэтгэх шалтгаан байвал буудан алж хөрөнгийг хураавал зохино.

128. Албан тушаалтан буюу улсын ба олон нийтийн байгууллагаас даалгасан ёсоор аливаа нэгэн үүрэг гүйцэтгэж байгууллагаас даалгасан ёсоор аливаа нэгэн үүрэг гүйцэтгэж яваа хүнээс албан тушаалын байдалд буюу гүйцэтгэх үүрэгтээ эрдэж түүний биед эрхлүүлэн өгсөн мөнгө ба үнэ бүхий зүйлүүд хийгээд бусад хөрөнгө хогшил зэргийг хувьдаа ашиглах буюу үрэгдүүлбэл таван жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэвэл зохино. Хэрэв хүндэтгэх шалтгаан байвал буудан алж хөрөнгийн хураавал зохино.

130. Албан тушаалаас өөрийн албаны тушаалын байдлыг гүйцэтгэн биелүүлэх буюу гүйцэтгэвэл зохих зүйлүүдийг эд хахууль өгсөн этгээдийн ямар нэгэн ашиг тусыг бүтээж гүйцэтгэхээр буюу эсвэл түүний ашиг тусыг бодож үл

<sup>32</sup> Б.Баярсайхан нар. Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. УБ., 2011. 359-412-р тал

гүйцэтгүүлэхээр ямар ч янзын эд хахуулийг өөрөө буюу бусдаар уламжлуулан авсан байвал таван жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэвэл зохино. Эд хахууль авахдаа:

1. Энэхүү хахууль авсан хүн нь хариуцлагатай албан тушаалтан болох.
2. Эд хахууль авсны учир урьд ял шийтгэгдсэн буюу эд хахуулийг хэдэн удаа авсан.
3. Эд хахууль авахдаа оролдон гаргуулах, айлган сүрдүүлж авах зэрэг хүндэтгэх шалтгаан байвал гурван жилээс доошгүй хугацаагаар хорьж хөрөнгийг хураана.

**1961** оны Эрүүгийн хууль нь гэмт хэргийг төрлийн объектоор нь системчлэх асуудлыг зохих түвшинд нарийвчлан тогтоосон байх ба “Албан тушаалын гэмт хэргүүд” 7 дугаар бүлэгт 5 зүйлд гэмт хэргийн шинж, ял шийтгэлийг тогтоосон. Тус хуульд хэд хэдэн удаа өөрчлөлт оруулсан байна. Тухайлбал, авлига, албан тушаалын гэмт хэрэг, ял шийтгэлээс дурдвал:

### **136-р зүйл. Албан тушаалынхаа байдлыг урвуулан ашиглах**

Энгийн бүрэлдэхүүн: тодорхой албан тушаал эрхлэхийг хориглох буюу хориглохгүйгээр 5 жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх;

Хүндрүүлэх бүрэлдэхүүн: 3-10 жил хүртэл хугацаагаар хорьж, тодорхой албан тушаал эрхлэхийг хоёроос таван жил хүртэл хугацаагаар хориглох.

### **137-р зүйл. Албан үүргээ биелүүлэхгүй байх буюу хариуцлагагүй хандах**

Энгийн бүрэлдэхүүн: гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх;

Хүндрүүлэх бүрэлдэхүүн: тодорхой албан тушаал эрхлэхийг хориглох буюу хориглохгүйгээр хоёроос долоон жил хүртэл хугацаагаар хорих.

### **138-р зүйл. Хээл хахууль авах**

Энгийн бүрэлдэхүүн: таван жил хүртэл хугацаагаар хорих;

Хүндрүүлэх бүрэлдэхүүн: Энэ гэмт хэргийг давтан үйлдсэн буюу хариуцлагатай албан тушаал гүйцэтгэж байгаа этгээд үйлдсэн, эсхүл далайлган сүрдүүлж хээл хахууль гаргуулсан бол хөрөнгийн заримыг буюу бүгдийг хураах буюу хураахгүйгээр 3-10 жил хүртэл хугацаагаар хорих.

### **1986 оны Эрүүгийн хууль<sup>33</sup> нь өмнөх хуулийг сайжруулж, гэмт хэрэгт**

<sup>33</sup> Б.Баярсайхан нар. Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. УБ., 2011. 505-600-р тал

тооцох эсхүл эс тооцохгүйгээр зохих нэмэлт өөрчлөлт оруулсан, мөн анх удаагаа гэмт хэргийн ангилалт хийсэн ба “Албан тушаалын гэмт хэрэг” 8 дугаар бүлэгт 8 зүйлд гэмт хэргийн шинж, ял шийтгэлийг тогтоосон. Тухайлбал,

### **192 дугаар зүйл. Эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах**

Ял шийтгэлийн хувьд:

Энгийн бүрэлдэхүүн: тодорхой албан тушаал эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх;

Хүндрүүлэх бүрэлдэхүүн: Тодорхой албан тушаал эрхлэх эрхийг хасаж найман жил хүртэл хугацаагаар хорих.

### **193 дугаар зүйл. Эрх мэдэл буюу албаны бүрэн эрхээ хэтрүүлэх**

Энгийн бүрэлдэхүүн: тодорхой албан тушаал эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх;

Хүндрүүлэх бүрэлдэхүүн: тодорхой албан тушаал эрхлэх эрхийг хасаж арван жил хүртэл хугацаагаар хорих.

### **194 дүгээр зүйл. Хайнга хандах**

Энгийн бүрэлдэхүүн: гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл нэг мянга таван зуу хүртэл төгрөгөөр торгох;

Хүндрүүлэх бүрэлдэхүүн: тодорхой албан тушаал эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар хорих.

### **195 дугаар зүйл. Хээл хахууль авах**

Энгийн бүрэлдэхүүн: эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр, тодорхой албан тушаал эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр зургаан жил хүртэл хугацаагаар хорих;

Хүндрүүлэх бүрэлдэхүүн: эд хөрөнгийг хурааж, тодорхой албан тушаал эрхлэх эрхийг хасаж дөрвөөс арван таван жил хүртэл хугацаагаар хорих.

### **196 дугаар зүйл. Хээл хахууль өгөх**

Энгийн бүрэлдэхүүн: дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх;

Хүндрүүлэх бүрэлдэхүүн: эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр, нутаг заах буюу заахгүйгээр гурваас арван таван жил хүртэл хугацаагаар хорих.

Дээрхээс үзэхэд социалист дэглэмийн үеийн 1942 оны Эрүүгийн хуульд “Албан тушаалын гэмт хэргүүд”-ийг тусгаж боловч өмнөх хуулиас гэмт хэргийн шинжийн хувьд онцлох өөрчлөлт хийгдээгүй. Харин тухайн гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийг чангаруулсан байна. 1961 оны Эрүүгийн хуульд өмнө хуульчилсан байсан зүйл ангийг нэгээр нэмэгдүүлж 5 зүйл ангиар авлига, албан тушаалын гэмт хэргийг тодорхойлсон бол 1986 оны Эрүүгийн хуульд 8 зүйлд гэмт хэргийн шинж, ял шийтгэлийг тогтоосон.

Мөн 1942 оны Эрүүгийн хуульд хорих болон буудан алах ялаар шийтгэхээр хуульчилсан байсан бол 1961, 1986 оны Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлагыг сулруулсан байхаас гадна торгох, хөрөнгө хураах, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, нутаг заах, тодорхой албан тушаал эрхлэх эрхийг хасах зэргээр ялын төрлийг нэмэгдүүлсэн байна.

## 2.5. Ардчилсан нийгмийн үеийн Эрүүгийн хууль (1993 он, 2002, 2015 он)

Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлал, агуулгад нийцүүлж бусад хуулиудыг бүхэлд нь шинэчлэх үндэслэл, шаардлагын дагуу 1990, 1992-1994, 1996, 1998-2000 онд Эрүүгийн хуульд зарчмын шинжтэй нэмэлт, өөрчлөлтүүд оруулсан байна.

1993 оны өөрчлөлтөөр 196 дугаар зүйлийн 2. “Энэ үйлдлийг удаа дараа буюу хээл хахуулийн хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд хийсэн, эсхүл их хэмжээтэй хээл хахууль өгсөн бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр, нутаг заах буюу заахгүйгээр 3-10 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж өөрчилжээ.

**2002 оны Эрүүгийн хууль<sup>34</sup> нь** өмнөх хуулийг бүхэлд нь шинэтгэх үзэл санаа, үндэслэлийн дагуу батлагдсан байх бөгөөд гэмт хэргүүдийг төрлийн болон шууд объектоор нь нарийвчлан ангилсан. “Албан тушаалын гэмт хэрэг” 28 дугаар бүлэгт 12 зүйлд гэмт хэргийн шинж, ял шийтгэлийг тогтоосон. Тухайлбал, (784-788)

### **263 дугаар зүйл. Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах**

Ял шийтгэлийн хувьд:

Энгийн бүрэлдэхүүн: тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн

<sup>34</sup> Б.Баярсайхан нар. Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. УБ., 2011. 690-797-р тал

хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах;

Хүндрүүлэх бүрэлдэхүүн: Энэ хэргийг давтан үйлдсэн, уг хэргийн улмаас их хэмжээний хохирол, хүнд хор уршиг учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасаж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих.

#### **264 дүгээр зүйл. Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх**

Энгийн бүрэлдэхүүн: тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах;

Хүндрүүлэх бүрэлдэхүүн: тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасаж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих.

#### **265 дугаар зүйл. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах**

Энгийн бүрэлдэхүүн: хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах;

Хүндрүүлэх бүрэлдэхүүн: Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих.

#### **266 дугаар зүйл. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх**

Энгийн бүрэлдэхүүн: хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах;

Хүндрүүлэх бүрэлдэхүүн: тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасаж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих.

**267 дугаар зүйл. Албан тушаалтын нэр барих**

Энгийн бүрэлдэхүүн: хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун нэгээс гурван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах.

**268 дугаар зүйл. Хээл хахууль авах**

Энгийн бүрэлдэхүүн: тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасаж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих;

Хүндрүүлэх бүрэлдэхүүн: Энэ хэргийг хясан боогдуулах замаар, эсхүл давтан буюу урьд хээл хахуулийн хэрэгт шийтгүүлсэн этгээд , түүнчлэн зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл их буюу онц их хэмжээний хээл хахууль авсан бол эд хөрөнгийг хурааж, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих.

**269 дүгээр зүйл. Хээл хахууль өгөх**

Энгийн бүрэлдэхүүн: хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих;

Хүндрүүлэх бүрэлдэхүүн: Энэ хэргийг давтан, эсхүл хээл хахуулийн хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд, түүнчлэн зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих.

**270 дугаар зүйл. Хээл хахууль зуучлах**

Энгийн бүрэлдэхүүн: Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах;

Хүндрүүлэх бүрэлдэхүүн: тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих.

**270<sup>1</sup> дүгээр зүйл. Хууль бусаар хөрөнгөжих**

Энгийн бүрэлдэхүүн: тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хасаж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих;

Хүндрүүлэх бүрэлдэхүүн: тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хасаж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих.

### **271 дүгээр зүйл. Албан тушаалтан хуурамч баримт бичиг үйлдэх**

Энгийн бүрэлдэхүүн: хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах.

### **272 дугаар зүйл. Албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандах**

Энгийн бүрэлдэхүүн: хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах;

Хүндрүүлэх бүрэлдэхүүн: бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр гурван жил хүртэл хугацаагаар хорих.

### **273 дугаар зүйл. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах**

Энгийн бүрэлдэхүүн: хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах;

Хүндрүүлэх бүрэлдэхүүн: тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих.

## **2015 оны Эрүүгийн хууль<sup>35</sup>**

2015 оны Эрүүгийн хуулийн шинэчлэлийн гол үзэл санаа нь зарим төрлийн гэмт хэргийн шинж, тэдгээрт оногдуулах ял шийтгэлийн бодлогод эрс өөрчлөлт хийхэд чиглэгдсэн байна. “Авлигын гэмт хэрэг”-үүд, түүнд хүлээлгэх ял шийтгэлийг Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт дараах байдлаар хуульчилсан.

### **22.1 дүгээр зүйл. Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах**

Ял шийтгэлийн хувьд:

<sup>35</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11634>

Энгийн бүрэлдэхүүн: Нийтийн албан тушаалтан албан тушаалын байдлаа урвуулан ашигласан...бол нийтийн албан ажиллах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж, нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих;

Хүндрүүлэх бүрэлдэхүүн: Тус гэмт хэргийн их хэмжээний хохирол учруулсан бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих;

Онц хүндрүүлэх бүрэлдэхүүн: Тус гэмт хэргийг улс төрд нөлөө бүхий этгээд, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани, улсын үйлдвэрийн газрын удирдах, эрх бүхий албан тушаалтан үйлдсэн бол нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар хасаж таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих.

### **22.3 дугаар зүйл. Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах**

Ял шийтгэл: Таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих

### **22.4 дүгээр зүйл. Нийтийн албан тушаалтан хахууль авах**

Энгийн бүрэлдэхүүн: Нийтийн албан тушаалтан...шууд, эсхүл бусдаар дамжуулан хахууль өгөхийг шаардсан, авсан бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих;

Хүндрүүлэх бүрэлдэхүүн: Тус гэмт хэргийг хясан боогдуулах аргаар үйлдсэн, эсхүл их хэмжээний хахууль авсан бол нийтийн албанд ажиллах эрхийг таван жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих;

Онц хүндрүүлэх бүрэлдэхүүн: Энэ гэмт хэргийг улс төрд нөлөө бүхий этгээд, эсхүл зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар хасаж арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар хорих.

Тайлбар: -Энэ бүлэгт заасан “их хэмжээний хахууль” гэдэгт нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгоно.

### **22.5 дугаар зүйл. Хахууль өгөх**

Энгийн бүрэлдэхүүн: Нийтийн албанд ажиллах, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих;

Хүндрүүлэх бүрэлдэхүүн: Энэ гэмт хэргийг нийтийн албан тушаалтан, эсхүл зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол нийтийн албанд ажиллах, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих;

Хүндрүүлэх бүрэлдэхүүн: Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

### **22.6 дугаар зүйл. Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах**

Энгийн бүрэлдэхүүн: Таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих;

Хүндрүүлэх бүрэлдэхүүн: Нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих.

### **22.7 дугаар зүйл. Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх**

Энгийн бүрэлдэхүүн: Нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих;

Хүндрүүлэх бүрэлдэхүүн: Энэ гэмт хэргийн улмаас их хэмжээний хохирол учруулсан бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих.

### **22.8 дугаар зүйл. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах**

Энгийн бүрэлдэхүүн: Нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулах;

Хүндрүүлэх бүрэлдэхүүн: Энэ гэмт хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих.

### **22.9 дүгээр зүйл. Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах**

Энгийн бүрэлдэхүүн: нийтийн албанд ажиллах, эсхүл ажиллах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих;

Хүндрүүлэх бүрэлдэхүүн: нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих.

### **22.10 дугаар зүйл. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих**

Энгийн бүрэлдэхүүн: Нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих;

Хүндрүүлэх бүрэлдэхүүн: Энэ гэмт хэргийг улс төрд нөлөө бүхий этгээд үйлдсэн бол үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих.

### **22.11 дүгээр зүйл. Дураар аашлах**

Энгийн бүрэлдэхүүн: Нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих;

Хүндрүүлэх бүрэлдэхүүн: Энэ гэмт хэргийн улмаас их хэмжээний хохирол учруулсан бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих.

**22.12 дугаар зүйл. Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах**

Энгийн бүрэлдэхүүн: Хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих.

**22.13 дугаар зүйл. Хахууль авах**

Энгийн бүрэлдэхүүн: Нийтийн албан тушаалтнаас бусад этгээд...шууд, бусдаар дамжуулан хахууль өгөхийг шаардсан, авсан бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих.

Дээрхээс үзэхэд эдгээр хуулиуд нь өмнөх социалист дэглэмийн үеийн хуульд заасан гэмт хэргийн шинжийн тодорхойлолт, ял шийтгэлийн төрөл, хэмжээний хувьд эрс өөрчлөгдөж, дэлхийн чиг хандлагыг дагасан, олон улсын конвенцод заасан үүргээ биелүүлэхийг эрмэлзсэн, 1992 оны ардчилсан Үндсэн хуульд нийцүүлсэн зэрэг олон шинэчлэлүүд авчирсан хэдий ч засаж сайжруулах, өөрчлөх шаардлага байгаа болох нь судалгаагаар тогтоогдсон билээ.


Тухайлбал, 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн хувьд авлигын зарим гэмт хэрэг оногдуулах ял шийтгэл, төрөл, хэмжээ зэрэгт ял шийтгэлийн бодлого сул байсныг авлига, албан тушаалын гэмт хэргийн аюул, гаралтын түвшин, тухайн төрлийн гэмт хэрэгт оногдуулсан ял шийтгэлийн талаарх олон нийт, судлаачдын шүүмжлэл, бусад орны туршлага зэргийг харгалзан хамгийн сүүлд 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлт оруулсан билээ.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙН ХАВТАСТ ХЭРГИЙН СУДАЛГАА

### 3.1. Эрх, мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах

Улсын Ерөнхий прокурорын газрын Эрүүгийн хэргийн төв архивд шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн хэргүүд хадгалагдах журамтай бөгөөд Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, хэрэгжиж эхэлсэн 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд нийт 244 авлига, албан тушаалын гэмт хэрэг шүүхээр хянан шийдвэрлэгдсэн байна. Гэхдээ энэ тоо нийт гэмт хэргийн тоо биш бөгөөд шийтгэх болон цагаатгах тогтоол хүчин төгөлдөр болсон хэргүүд юм. Эдгээр 244 хавтаст хэргийг нэг бүрчлэн уншиж танилцан, тодорхой асуумжийн дагуу судалсан болно<sup>36</sup>.


График 1: Шүүхийн харьяалал (Нийслэлийн хэмжээнд)



<sup>36</sup> Улсын ерөнхий прокурорын газрын Эрүүгийн хэргийн төв архив архивлагдсан хавтаст хэргүүд (2024 он)


Нийт хэргийн 23 хувь буюу 56 хэрэг Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт үйлдэгдэж шүүхээр хянан шийдвэрлэгдсэн нь бусад дүүргүүдээс их байх бөгөөд Баянзүрх, Чингэлтэй дүүргийн шүүх тус бүр 20 хувьтай байна. Өөрөөр хэлбэл, нийт хэргийн 63 хувь буюу 2/3 -ыг Сүхбаатар, Баянзүрх, Чингэлтэй дүүрэг эзэлж байгаа буюу эдгээр дүүрэгт авлигын гэмт хэрэг ихээр үйлдэгджээ.

График 2: Хэргийн зүйлчлэл (хэд хэдэн сонголттой)




Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлд заасан Нийтийн албан тушаалтан хахууль авах гэмт хэрэг 136 буюу хамгийн их үйлдэгдсэн бол 22.1 дүгээр зүйл болох Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг 103 байна. Тодруулбал нийтийн албан тушаалтан дээрх хоёр гэмт хэргийн үйлдэж давхар зүйлчлэгдсэн тохиолдол нь 133 байгаа бол аль нэг гэмт хэрэгт нь дангаар нь үйлдсэн тохиолдол нь 33 байна. Өөрөөр хэлбэл, нийтийн албан тушаалтан хахууль авах, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийг ихэнх тохиолдолд давхар үйлддэг болох нь харагдаж байна.

График 3: Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байгууллага



Нийт хэргийн 98.8 хувь буюу 241 хэрэгт Авлигатай тэмцэх газар мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байна. Энэ нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан харьяаллын дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаатай холбоотой. Харин хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа тун цөөхөн явагдсан нь нийтийн албан тушаалтан авлига авах, албан тушаалын байдлаа урвуулан ашиглахдаа Эрүүгийн хуульд заасан бусад төрлийн гэмт хэргийг тэр болгон үйлддэггүй болохыг илэрхийлж байна. Жишээ нь: дээрх үйлдлүүд нь мөнгө угаах гэмт хэрэгтэй хамгийн их холбогдох эрсдэлтэй боловч цагдаагийн байгууллагаас дангаараа нэг, хамтарсан хоёр хэрэгт л мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас үзэхэд хэрвээ мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдсэн бол цагдаагийн байгууллагаас хэргийг тусгаарлаж, дангаараа шалгадаг, эсвэл мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэх ажиллагаа хангалтгүй, ажлын хэсэг томилогдох шаардлага гардаггүй, нэг бол үйлдэгддэггүй ч байж болох юм. Нөгөө талаасаа нэг байгууллага бүхий л хэргийг шалгаж байгаа нь Авлигатай тэмцэх газрын хүний нөөц, чадавх, төсөв санхүү зэрэг биеэ дааж ажиллах боломж нь хангалттай бүрдсэн болохыг илэрхийлсэн үзүүлэлт юм.


График 4: Гэмт хэрэг үйлдэгдсэн хугацаа



Нийт гэмт хэрэг үйлдэгдсэн оныг харахад 2017-2020 оны хооронд их байна. Дээрх хугацаанд гэмт хэрэг их хэмжээгээр үйлдэгдсэн нь Эрүүгийн хуулийн шинэчлэгдсэн, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, мөрдөх байгууллагын идэвхтэй ажиллагаа гээд олон хүчин зүйлийн нөлөөллөөр гэмт


хэргийн илрүүлэлт амжилттай хэрэгжсэний үр дүн байж болно. Харин нийт хэргийн 13.1 хувь буюу 32 хэргийг 5 дугаар сард үйлдсэн байгаа нь бусад саруудаас өндөр байна. Гэхдээ саруудын хооронд онцгойлох ялгаа байхгүй, жигд байгаа нь дээрх төрлийн гэмт хэргүүд нь улирлын шинжтэй гэмт хэрэг биш бөгөөд байнга л үйлдэгдэж байдгийг гэрчилж байгаа юм.

График 5: Хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулсан хугацаа, жилээр




Энэ нь гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл, өргөдөл бүртгэгдсэн өдрөөс анхан шатны шүүхийн шийдвэр гарах хүртэлх хугацаа юм. Нийт хэргийн 22.9 хувь буюу 56 хэргийг нэг жилийн, 29 хувь буюу 71 хэргийг 1-2 жилийн, 14.3 хувь буюу 35 хэргийг 2-3 жилийн, 13.1 хувь буюу 32 хэргийг 3-4 жилийн дотор тус тус хянан шийдвэрлэсэн нь бусад хугацаанаас илүү байна. Нийт хугацааны дунджийг авч үзвэл анхан шатны шүүхээр хэргийг шийдвэрлэх хүртэл 2 жил 4 сарын хугацаа зарцуулж байна. Авлига, албан тушаалын гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаа нь ийнхүү удаашралтай байгаа нь тухайн үйлдлүүдийг нотлоход цаг хугацаа их шаарддаг, ээдрээ төвөгтэй байдагтай холбоотой хэдий ч мөрдөх болон прокурорын байгууллагын хүний нөөцийн хангалтгүй байдал, ур чадвартай зайлшгүй холбоотой юм.

График 6: Шүүгдэгчийн иргэний харьяалал




Нийт гэмт хэргийн 98 хувь буюу 240 хэргийг Монгол Улсын иргэн үйлдсэн байх бөгөөд 2 хувь буюу 4 хэргийг гадаад улсын иргэн тэр дундаа бүгд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэд үйлдсэн байна. Энэ нь дотооддоо буюу нийтийн албан тушаалтан руу чиглэсэн урьдчилсан сэргийлэх сургалт, сэрэмжлүүлэг, видео контентыг явуулж байх шаардлагатайг харуулж байна.

График 7: Шүүгдэгчийн нас




Шүүгдэгч нарын насны хувьд 32 хувь буюу 80 хэргийн шүүгдэгч нь 36-40 болон 41-45 насныхан байгаа нь бусад насны шүүгдэгч нараас олон байна. Насны байдлын дунджилж үзвэл 27-28 нас байх боловч 30 нас хүртлээ болон 50 нас гарсан шүүгдэгч нар гэмт хэрэгт шийтгүүлсэн тохиолдол цөөн байгаа юм. Гурван шүүгдэгч тутмын 2 нь дээрх насных буюу дунд үеийнхэн эзэлж байна. Өөрөөр хэлбэл, 62 хувь буюу төрийн албаны туршлагатай гэж хэлж болох 31-50 насныхан тухайн гэмт хэргийг түлхүү үйлдэж байгаа нь анхаарал татаж байна.

График 8: Шүүгдэгчийн боловсрол



Нийт хэргийн 99 хувь буюу 242 хэргийн шүүгдэгч нар дээд боловсролтой байна. Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь заалтад төрийн жинхэнэ албан тушаалд тавигдах нийтлэг шаардлагын нэг нь дээд боловсролтой байхаар заасан. Тийм учраас бүх шүүгдэгч нар дээд боловсролтой байна. Нөгөө талаараа авлига, албан тушаалын гэмт хэрэг нь хүний эрүүл мэнд эсвэл өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс ялгаатай тул дээд боловсролтой хүмүүс л тухайн гэмт хэрэгт холбогдох боломжтой юм.

График 9: Шүүгдэгчийн албан тушаал



Нийт хэргийн 91 хувь буюу 222 хэргийг төрийн албан хаагч үйлдсэн байна. Үүнийг бүгд гэж ойлгож болох бөгөөд 9 хувь буюу 22 хэргийг Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлд заасан хахууль өгөх гэмт үйлдсэн шүүгдэгч нар эзэлж байна. Учир нь хахууль өгөх гэмт хэрэг үйлдсэн хүмүүс төрийн албан хаагч байх шаардлагагүй бөгөөд хувиараа хөдөлмөр эрхлэгч нар байсан.

График 10: Шүүгдэгчийн албан тушаалын ангилал



Нийт хэргийн 84.8 хувь буюу 207 хэргийг нийтийн албан тушаалтан үйлдсэн байна. Харин 2.8 хувь буюу 7 хэргийг улс төрд нөлөө бүхий этгээд, 0.8 хувь буюу 2 хэргийг төрийн болон орон нутгийн өмчит компани, үйлдвэрийн газрын удирдах, эрх бүхий албан тушаалтан үйлдсэн байна. Энэхүү үзүүлэлт нь Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт орсон 2 удаагийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой юм. Тодруулбал, 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдөр төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани, улсын үйлдвэрийн газрын удирдах, эрх бүхий албан тушаалтан гэж нэмэлт оруулсан тул үүнээс өмнө тус албан тушаалтнууд нийтийн албан тушаалтан гэж тодорхойлогдож байсан. Нийт хэргийн 11.4 хувь буюу 28 хэргийн нийтийн албан тушаалтан биш этгээд үйлдсэн байгаа нь хахууль өгөх гэмт хэргийн шүүгдэгч нар юм.

График 11: Гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн талаар




Нийт хэргийн 70.1 хувь буюу 171 хэргийг шүүгдэгч дангаар буюу бусадтай бүлэглэж үйлдээгүй байна. Энэ нь авлига, албан тушаалын гэмт хэргийг гэмт этгээд ганцаараа үйлдэх магадлал өндөр буюу гэмт хэрэг үйлдэх талаар шийдвэрийг гаргахад түүний эрхэлж байгаа албан тушаал, ажил үүргийн хувьд хэн нэгнээс хараат бус, бие даан шийдвэрлэж байгаатай холбоотой юм. Өөрөөр хэлбэл, албан тушаалтны гаргаж байгаа шийдвэрт хөндлөнгийн хяналт тавих боломжтой, ил тод байх зохицуулалтыг бий болгох шаардлагатайг харуулж байна.

График 12: Гэмт хэргийн үргэлжилсэн байдал




Нийт хэргийн 46 хувь буюу 113 хэргийг 1 удаагийн үйлдлээр үйлдсэн байна. Харин 25 хувь буюу 62 хэргийг 4 болон түүнээс дээш удаагийн үйлдлээр үйлдсэн нь 2, 3 удаагийн үйлдэлтэй хэргээс олон байна. Өөрөөр хэлбэл, шүүгдэгч нар 1 эсвэл 4 удаагийн үргэлжилсэн үйлдлээр ихэвчлэн үйлдсэн байна.

График 13: Таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан байдал



Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт хувийн баталгаа гаргах, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх, хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг дангаар болон давхардуулан авч болохоор заасны дагуу таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан байдлыг судлан үзэхэд нийт хэргийн 76.6 хувь буюу 187 хэргийн шүүгдэгч нарт хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээ авсан нь ихэнх тохиолдлыг эзэлж байна. Харин шүүгчийн захирамжаар авдаг таслан сэргийлэх арга хэмжээнүүд болох хязгаарлалт тогтоох арга хэмжээг 27.5 хувь буюу 67 хэргийн шүүгдэгч нарт, цагдан хорих арга хэмжээг 15.6 хувь буюу 38 хэргийн шүүгдэгч нарт тус тус авсан байна.

График 14: Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ



Нийт 244 хэрэгт 119,414,427,344 (нэг зуун арван есөн тэрбум дөрвөн зуун арван дөрвөн сая дөрвөн зуун хорин долоон мянга гурван зуун гучин дөрөв) төгрөгийн хохирол учирсан байна. Үүнээс 60.9 хувь буюу 72,791,195,973 төгрөгийг Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт учруулсан байна.

Нийт хэргийн 37 хувь буюу 91 хэрэгт шүүгдэгчийн учруулсан хохирлын хэмжээ 300,000 (гурван зуун мянга) төгрөгөөс 10,000,000 (арван сая) төгрөгийн хооронд байна. Харин 23 хувь буюу 56 хэрэгт учруулсан хохирлын хэмжээ 50,000,000 (тавин сая) төгрөгөөс дээш буюу их хэмжээний хохирол байна. Үүнээс үзэхэд 4 хэрэг тутмын 1-д нь их хэмжээний хохирол учирсан байна.

Нэмж өгүүлэхэд хохирол учирсан нийт хэрэгт хор уршгийг тогтоосон тохиолдол гараагүй. Үүнээс үзэхэд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зөвхөн хохирлын хэмжээг тогтоодог, хор уршгийг тооцдоггүй болох нь харагдаж байна. Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Энэ хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдэж хохирол учруулсны улмаас үүссэн үр дагаврыг гэмт хэргийн хор уршигт тооцно” гэж, 3 дахь хэсэгт “Энэ хуульд “ноцтой хохирол, хор уршиг” гэж хохирогчийн амьдралын эх үүсвэр


болсон эд хөрөнгийн эрхэд, эсхүл улс орон, хүн амын аюулгүй байдалд ач холбогдол бүхий эрхэд хохирол, хор уршиг учирсныг ойлгоно” гэж тус тус заасан. Өөрөөр хэлбэл хуульд хор уршиг гэж юу болох, хэрхэн авч үзэх талаар тодорхой заасан тул түүнийг тодорхойлж, тооцоолж шийдвэрлэх боломж байсан байхыг үгүйсгэхгүй.

График 15: Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн байдал



Нийт хэргийн 44.2 хувь буюу 108 хэрэгт шүүгдэгчид хохирлоо нөхөн төлсөн байна. Харин 27 хувь буюу 66 хэрэгт хохирлоо нөхөн төлөөгүй. Мөн 22.1 хувь буюу 54 хэрэгт хохирлыг нөхөн төлөх шаардлагагүй гэсэн байна. Учир нь Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн шүүгдэгч нарт мөнгөөр хэмжигдэх хохирол учруулаагүй гэж үзсэн тул нөхөн төлөх шаардлагагүй гэж шүүхээс дүгнэсэн байна.

График 16: Эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдал




Нийт хэргийн 72.5 хувь буюу 177 хэрэгт эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдлыг дурдаагүй байна. Үүнээс үзэхэд шүүх шүүгдэгч нарт ихэвчлэн эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх болон хөнгөрүүлэх нөхцөл байдал тогтоогдохгүй байна гэж үзсэн байж болох хэдий ч шийдвэртээ заавал ч үгүй яагаад тогтоогдоогүй талаар хууль зүйн дүгнэлт хийх ёстой байжээ. Харин 25.8 хувь буюу 63 хэрэгт хөнгөрүүлэх нөхцөл байдал, 1.2 хувь буюу 3 хэрэгт хүндрүүлэх нөхцөл байдал тогтоогдсон талаар тус тус дурдсан.

Хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдлуудаас дурдсан хуулийн зүйл хэсгийг харуулбал:

№	Хөнгөрүүлэх нөхцөл байдал		Хүндрүүлэх нөхцөл байдал	
1	6.5 дугаар зүйлийн 1.1	41	6.6 дугаар зүйлийн 1.2	4
2	6.5 дугаар зүйлийн 1.2	14		
3	6.5 дугаар зүйлийн 1.3	1		
4	6.5 дугаар зүйлийн 1.5	2		
5	анх удаа гэмт хэрэг үйлдсэн	14		
6	ар гэрийн нөхцөл байдал	1		
7	ажилласан байдал	1		
8	хахууль нэхэж шаардаагүй	1		
9	үйлдсэн гэмт хэрэгтээ гэмшсэн	1		
	Нийт	76		4

Нийт 76 удаа эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдал тогтоогдож байна гэж үзсэн тохиолдол гарсан бөгөөд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөнгөрүүлэх нөхцөл байдлаас хуульд заагаагүй нөхцөл байдлыг шийдвэрийнхээ үндэслэл болгосон байв. Энэ нь тус хуулийн 6.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар шүүх онцгой нөхцөл байдлыг харгалзан эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлж болно гэсэн заалттай холбоотой юм. Харин 4 тохиолдолд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад заасан “гэмт хэргийг бүлэглэж үйлдсэн” гэх үндэслэлээр эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэн авч үзсэн байна.

График 17: Эрүүгийн хэргийг шийдвэрлэсэн байдал



Нийт хэргийн 67.6 хувь буюу 165 хэргийг ердийн журмаар, 32.4 хувь буюу 79 хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн байна. Үүнээс үзэхэд 3 хэрэг тутмын 1-ийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэхээр шүүгдэгч хүсэлт гаргасан байна. Дээр дурдсан график 5 буюу хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулсан хугацаанаас үзэхэд авлига, албан тушаалын гэмт хэргийн дунджаар 2 жил 4 сарын хугацаа зарцуулж байгаатай холбоотойгоор хялбаршуулсан журмаар шийдвэрлэх боломжгүйд хүрч байна гэсэн үг юм.

График 18: Улсын яллагчийн санал



Улсын яллагч нийт 240 хэрэгт эрүүгийн хариуцлагын талаар санал гаргасан байна. Үүнээс 62.9 хувь буюу 151 хэрэгт улсын яллагчийн зүгээс торгох ялыг шүүгдэгчид оногдуулахаар санал бол 33.7 хувь буюу 81 хэрэгт хорих ял

оногдуулахаар санал гаргасан байна. Үүнээс үзэхэд дийлэнх хэрэгт улсын яллагч торгох ялыг санал болгосон байх бөгөөд 3 хэрэг тутмын 1-д хорих ялыг санал болгосон байна. Харин 93.7 хувь буюу 225 хэрэгт эрх хасах ял оногдуулахаар санал гаргасан байна. Энэ нь Эрүүгийн хуулийн 5.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих ялыг үндсэн, эрх хасах ялыг нэмэгдэл ялаар хэрэглэнэ” гэж заасан зохицуулалттай хамааралтай бөгөөд үлдэх хувь нь эрх хасах ял байхгүй гэмт хэрэг болон хэрэгсэхгүй болсон хэргийн тоо юм. Олон нийтийн дунд шүүх авлига, албан тушаалын гэмт хэрэгт хөнгөн ял оногдуулдаг гэсэн ойлголт байгааг өөрчилж, улсын яллагчийн эрүүгийн хариуцлага оногдуулах байр суурь нь шүүхийн шийдвэрт чухал хүчин зүйл болохыг танин мэдүүлэх хэрэгцээ байгааг илэрхийлж байна.


График 19: Өмгөөлөгчийн санал



Шүүх хуралдаанд оролцсон өмгөөлөгч нийт 224 хэрэгт эрүүгийн хариуцлагын талаар санал гаргасан байна. Үүнээс 71.6 хувь буюу 162 хэрэгт өмгөөлөгчийн зүгээс торгох ялыг шүүгдэгчид оногдуулахаар санал гаргасан байна. Өөрөөр хэлбэл 4 хэрэг тутмын 1-д торгох ялын санал гаргасан байна. Харин 5.7 хувь буюу 13 хэрэгт хэрэгсэхгүй болгох буюу цагаатгах байр сууринаас оролцсон тул эрүүгийн хариуцлагын талаар санал гаргаагүй байна. Мөн нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулсан тохиолдол байхгүй байгаа нь авлигын гэмт хэрэгт энэхүү ялыг оногдуулахаар хуульчлаагүйтэй холбоотой юм.




График 22: Шат шатны шүүхээр шийдвэрлэсэн байдал



Нийт хэргийн 62 хувь нь буюу 152 хэрэг анхан шатны шүүхээр, 25 хувь буюу 60 хэрэг давж заалдах шатны шүүхээр, 13 хувь буюу 32 хэрэг хяналтын шатны шүүхээр тус тус эцэслэн шийдвэрлэгдсэн байна. Үүнээс үзэхэд 3 шүүгдэгч тутмын 2 нь анхан шатны шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч гомдол гаргаагүй. Харин 4 шүүгдэгч тутмын 1 нь давж заалдах шатны шүүхээр хэргээ шийдвэрлүүлсэн байна. Хяналтын шатны шүүх нийт хугацаанд 32 хэрэг шийдвэрлэсэн байгаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дүгээр зүйлд заасан хяналтын журмаар гомдол, эсэргүүцэл гаргах үндэслэл, 40.2 дугаар зүйлд заасан хяналтын журмаар гаргасан гомдол, эсэргүүцлийг хүлээн авах журамд орсон нэмэлт, өөрчлөлттэй зарим талаар холбоотой.

График 23: Эрүүгийн хэргийн зүйлчлэл



Нийт хэргийн 47.9 хувь буюу 117 хэргийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.4 дүгээр зүйлд зааснаар, 31.1 хувь буюу 76 хэргийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлд зааснаар тус тус зүйлчилж эцэслэн шийдвэрлэсэн байна. Харин 6.1 хувь буюу 15 хэргийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйл болон 22.4 дүгээр зүйлд зааснаар давхар зүйлчилсэн байна. Үүнээс үзэхэд 2 хэрэг тутмын 1 нь хахууль авах гэмт хэрэгт, 3 хэрэг тутмын 1 нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэгт тус тус ял шийтгэгдсэн байна.

Шүүхээс хэрэгсэхгүй болгосон, зүйлчлэл өөрчлөгдсөн, гэм буруутайд тооцсон боловч эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн үндэслэл дараах байдалтай байна. Үүнд:

	Хэрэгсэхгүй болгосон үндэслэл	Хэргийн зүйлчлэл	Тоо хэмжээ	Тайлбар
1	Гэмт хэргийн шинжгүй	22.1 дүгээр зүйл	6	Гэмт хэргийн шинжийг хангахгүй
		22.4 дүгээр зүйл	2	
		22.1/22.4 дүгээр зүйл	1	
		22.5 дугаар зүйл	2	
		22.10 дугаар зүйл	1	
Хөөн хэлэлцэх хугацаа дууссан	22.1 дүгээр зүйл	22.1 дүгээр зүйл	2	Хөөн хэлэлцэх хугацаа дууссан
		22.10 дугаар зүйл	1	
	Бусад	Хэргийн зүйлчлэл	Тоо хэмжээ	Тайлбар
2	Хэргийн зүйлчлэл өөрчлөгдсөн	22.1 дүгээр зүйл	2	17.3 дугаар зүйлийн 2.1, 23.5 дугаар зүйлийн 1
		22.4 дүгээр зүйл	1	
	Эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн	22.5 дугаар зүйл	1	6.7 дугаар зүйлийн 1.1


Дээрх хэргээс 12 хэргийг гэмт хэргийн шинжгүй, 3 хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр тус тус хэрэгсэхгүй болгосон байна. Мөн 3 хэргийн зүйлчлэл авлигын гэмт хэрэг бус өөр төрлийн гэмт хэрэг болж өөрчлөгдсөн байна. Харин 1 гэмт хэргийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1.1-д зааснаар эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн байна.

### 3.2. Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйл. Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах

Энэхүү зүйл ангийг 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдөр, 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр, 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдөр тус тус 3 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан. Сүүлийн буюу 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр торгох ялын төрлийг хассан.

2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлд зааснаар нийт 76 гэмт хэрэг шүүхээр хянан шийдвэрлэгдэж хүчин төгөлдөр болсон байна.<sup>37</sup>

График 24: Шүүхийн харьяалал



Нийт хэргийн 51 хувь буюу 39 хэрэг Чингэлтэй, Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт үйлдэгдэж шүүхээр хянан шийдвэрлэгдсэн байна. Үүнээс үзэхэд 2 хэрэг тутмын 1 нь эдгээр дүүрэгт үйлдэгдсэн байгаа бол Налайх-Баганхангай болон Сонгинохайрхан дүүргийн шүүхээр хамгийн цөөн хэрэг шийдвэрлэгдсэн байна.

Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн ял оногдуулахад улсын яллагчаас эрүүгийн хариуцлагын талаар гаргасан санал, хэмжээ, шүүхийн шийдвэрийг харьцуулан харуулбал:

Ялын нэр	Хэмжээ	Прокурор	Шүүх
Торгох ял (нэгжээр)	5.400-14.000	40	51
	14.000-27.000	14	6
	27.000-40.000	1	2
		55	59

<sup>37</sup> Улсын ерөнхий прокурорын газрын Эрүүгийн хэргийн төв архивт архивлагдсан эрүүгийн дугаар бүхий хавтаст хэргүүд (2024 он)

Ялын нэр	Хэмжээ	Прокурор	Шүүх
Зорчих эрх хязгаарлах ял (жилээр)	1-2	4	4
		4	4
Хорих ял (жилээр)	1-2	4	4
	2-3	7	2
	3-4	2	3
	4-5	3	
		16	9
Тэнсэх (жилээр)	1-2	1	4
		1	4
<b>Нийт</b>		<b>76</b>	<b>76</b>
Эрх хасах ял (жилээр)	2-3	62	62
	3-4	4	3
	4-5	8	9
	5-6	2	2
<b>Нийт</b>		<b>76</b>	<b>76</b>

**Торгох ял.** Нийт хэргийн 72.3 хувь буюу 55 хэрэгт прокуророос торгох ялын санал гаргаж, 77.6 хувь буюу 59 хэрэгт шүүхээс торгох ял оногдуулсан байна. Үүнээс үзэхэд торгох ялын төрлийг 4 хэрэг тутмын 3-д оногдуулах саналыг улсын яллагчаас гаргаж, шүүх тус ялыг оногдуулсан байна. Мөн нийт хэргийн 52.6 хувь буюу 40 хэрэгт прокуророос 5.400 – 14.000 нэгжийн хооронд торгох ялын санал гаргахад 72.8 хувь буюу 51 хэрэгт шүүх дээрх хэмжээний дотор торгох ял оногдуулсан байна.


**Зорчих эрхийг хязгаарлах ял.** Нийт хэргийн 5.2 хувь буюу 4 хэрэгт прокуророос зорчих эрхийг хязгаарлах ялын санал гаргахад шүүх саналыг хүлээн авч тус ялыг оногдуулсан байна. Ялын хэмжээний хувьд 1-2 жилийн хооронд оногдуулсан байна.

**Хорих ял.** Харин нийт хэргийн 21 хувь буюу 16 хэрэгт прокуророос хорих ялын санал гаргахад 11.8 хувь буюу 9 хэрэгт шүүхээс хорих ял оногдуулсан байна. Үүнээс үзэхэд прокуророос хорих ялын төрлийг сонгож санал гаргахад шүүх 2 дахин бууруулж хорих ялыг оногдуулсан байна. Ялын хэмжээний хувьд прокуророос 4-5 жилийн хооронд тус ялыг оногдуулахаар санал гаргахад шүүх хүлээн аваагүй байна.

**Тэнсэх.** Нийт хэргийн 1.3 хувь буюу 1 хэрэгт прокуророос хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх санал гаргахад 5.2 хувь буюу 4 хэрэгт шүүх хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх арга хэмжээг авсан байна.

**Эрх хасах ял.** Нийт хэргийн 81.5 хувь буюу 62 хэрэгт прокуророос 2-3 жилийн хооронд эрх хасах ялын хэмжээг санал гаргахад шүүх уг хэмжээгээр эрх хасах ялыг оногдуулсан байна. Үүнээс үзэхэд эрх хасах ялын хэмжээ прокурорын гаргасан саналын хүрээнд байна.

График 25: Шүүх хуралдаанд шүүгдэгчийн өмгөөлөгчөөс эрүүгийн хариуцлагын талаар гаргасан санал



Нийт хэргийн 80.2 хувь буюу 61 хэрэгт шүүгдэгч өмгөөлөгчтэй, бусад 15 хэрэгт шүүгдэгч өөрийгөө өмгөөлж оролцсон байна. Үүнээс үзэхэд 5 хэрэг тутмын 1-д шүүгдэгч өмгөөлөгчгүй шүүх хуралдаанд оролцсон. Нийт хэргийн 18.4 хувь буюу 14 хэрэгт өмгөөлөгч улсын яллагчтай оногдуулах ялын талаар санал нэг байсан нь 5 хэрэг тутмын 1-д оногдуулах ялын саналыг өмгөөлөгч хүлээн зөвшөөрсөн байна. Мөн нийт хэргийн 15.7 хувь буюу 12 хэрэгт өмгөөлөгч ялын хэмжээний талаар, 14.4 хувь буюу 11 хэрэгт торгох ял оногдуулах талаар тус тус санал гаргасан байна. Харин нийт хэргийн 15.7 хувь буюу 12 хэрэгт өмгөөлөгч тодорхой санал гаргаагүй байна. Ямар учраас ялын талаар санал гаргаагүй байгаа нь хавтаст хэрэгт тусгагдаагүй байна.

График 26: Давж заалдах, хяналтын шатны шүүх



**Давж заалдах шатны шүүх.** Нийт хэргийн 28.9 хувь буюу 22 хэрэгт давж заалдах гомдол гаргасан байна. Давж заалдах шатны шүүх нийт ирүүлсэн гомдлын 72.7 хувь буюу 16 хэрэгт анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, үлдсэн 6 хэрэгт шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан байна. Үүнээс үзэхэд 4 хэрэг тутмын 1-д давж заалдах гомдлыг хүлээн авсан байна.


**Хяналтын шатны шүүх.** Нийт хэргийн 19.7 хувь буюу 15 хэрэгт хяналтын журмаар гомдол гаргасан байна. Хяналтын шатны шүүх нийт ирүүлсэн гомдлын 93.3 хувь буюу 14 хэрэгт анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх, гомдлыг хэлэлцүүлэхээс татгалзсан байна. Үүнээс үзэхэд хяналтын шатны шүүх гомдол хүлээн авч, хэлэлцүүлэхгүй байгаа бөгөөд давж заалдах гомдлоор хэрэг эцэслэн шийдвэрлэгдэж байна.

### 3.3. Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйл. Нийтийн албан тушаалтан хахууль авах

Энэ зүйлд 2017 оны 05 дугаар сарын 11-ны өдөр, 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр, 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдөр тус тус 3 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан. Сүүлийн буюу 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр торгох, зорчих эрхийг хязгаарлах ялын төрлийг хасаж, зөвхөн хорих ялтай болсон.

2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ны өдрийг хүртэлх хугацаанд нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.4 дүгээр зүйлд зааснаар нийт 117 гэмт хэрэг шүүхээр хянан шийдвэрлэгдэж хүчин төгөлдөр болсон байна.

График 27: Шүүхийн харьяалал



Нийт хэргийн 24 хувь буюу 28 хэрэг Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт үйлдэгдэж шүүхээр хянан шийдвэрлэгдсэн байна. Үүнээс үзэхэд 4 хэрэг тутмын 1 нь энэ дүүрэгт үйлдэгдсэн байна. Мөн нийт хэргийн 19 хувь буюу 23 хэрэг Чингэлтэй, Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт тус тус үйлдэгдсэн байна. Үүнээс үзэхэд 5 хэрэгт тутмын 1 нь тус 2 дүүрэгт үйлдэгдсэн байна.

Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн ял оногдуулахад улсын яллагчаас эрүүгийн хариуцлагын талаар гаргасан санал, хэмжээ, шүүхийн шийдвэрийг харьцуулан харуулбал:

Ялын нэр	Хэмжээ	Прокурор	Шүүх
Торгох ял (нэгжээр)	2.700-5.400	8	16
	5.400-14.000	44	57
	14.000-27.000	16	13
	27.000-40.000	4	8
		72	94
Зорчих эрх хязгаарлах ял (жилээр)	1-2		5
			5
Хорих ял (жилээр)	1-2	17	5
	2-3	13	7
	3-4	6	3
	4-5	4	
	5-6	2	
	6-7	1	
	7-8	1	
		44	15

Ялын нэр	Хэмжээ	Прокурор	Шүүх
Тэнсэх (жилээр)	1-2		1
	2-3	1	2
		1	3
<b>Нийт</b>		117	117
Эрх хасах ял (жилээр)	1-2	22	32
	2-3	14	11
	3-4	7	5
	4-5	50	56
	5-6	17	11
	6-7	3	1
	7-8	4	1
<b>Нийт</b>		<b>117</b>	<b>117</b>

**Торгох ял.** Нийт хэргийн 61.5 хувь буюу 72 хэрэгт прокуророос торгох ялын санал гаргаж, 80.3 хувь буюу 94 хэрэгт шүүхээс торгох ял оногдуулсан байна. Үүнээс үзэхэд торгох ялын төрлийг 5 хэрэг тутмын 3-д оногдуулах саналыг прокуророос гаргахад шүүх 5 хэрэг тутмын 4-д тус ялыг оногдуулсан байна. Өөрөөр хэлбэл шүүх 5 хэрэг тутамд 1 хэрэг илүү торгох ял оногдуулсан байна. Мөн торгох ялын санал гаргасан нийт хэргийн 61.1 хувь буюу 44 хэрэгт прокуророос 5.400-14.000 нэгжийн хооронд торгох ялын санал гаргахад 60.6 хувь буюу 57 хэрэгт шүүх дээрх хэмжээний дотор торгох ял оногдуулсан байна.


**Зорчих эрхийг хязгаарлах ял.** Нийт хэрэгт прокуророос зорчих эрхийг хязгаарлах ялын санал огт гаргаагүй байхад шүүх 5 хэрэгт тус ялыг оногдуулсан байна. Ялын хэмжээний хувьд 1 – 2 жилийн хооронд оногдуулсан байна.

**Хорих ял.** Харин нийт хэргийн 37.6 хувь буюу 44 хэрэгт прокуророос хорих ялын санал гаргахад 12.8 хувь буюу 15 хэрэгт шүүхээс хорих ял оногдуулсан байна. Үүнээс үзэхэд прокуророос хорих ялын төрлийг сонгож санал гаргахад шүүх 3 дахин бууруулж хорих ялыг оногдуулсан байна. Ялын хэмжээний хувьд прокуророос 4 жилээс дээш хэмжээний хорих ялыг оногдуулахаар санал гаргахад шүүх хүлээн аваагүй байна.

**Тэнсэх.** Нийт хэргийн 0.8 хувь буюу 1 хэрэгт прокуророос хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх санал гаргахад 2.5 хувь буюу 3 хэрэгт шүүх хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх арга хэмжээг авсан байна.

**Эрх хасах ял.** Нийт хэргийн 42.7 хувь буюу 50 хэрэгт прокуророос 4 – 5 жилийн хооронд эрх хасах ялын хэмжээг санал гаргахад 47.8 хувь буюу 56 хэрэгт шүүх уг хэмжээгээр эрх хасах ялыг оногдуулсан байна. Үүнээс үзэхэд эрх хасах ялын хэмжээ прокурорын гаргасан саналын хүрээнд байна.

График 28: Шүүх хуралдаанд шүүгдэгчийн өмгөөлөгчөөс эрүүгийн хариуцлагын талаар гаргасан санал



Нийт хэргийн 91.4 хувь буюу 107 хэрэгт шүүгдэгч өмгөөлөгчтэй, бусад 10 хэрэгт шүүгдэгч өөрийгөө өмгөөлж оролцсон байна. Үүнээс үзэхэд 10 хэрэг тутмын 1-д шүүгдэгч өмгөөлөгчгүй шүүх хуралдаанд оролцсон байна. Нийт хэргийн 17 хувь буюу 20 хэрэгт өмгөөлөгч улсын яллагчтай оногдуулах ялын талаар санал нэг байсан байсан байна. Үүнээс үзэхэд 6 хэрэг тутмын 1-д оногдуулах ялыг өмгөөлөгч хүлээн зөвшөөрсөн байна. Мөн нийт хэргийн 34.1 хувь буюу 40 хэрэгт өмгөөлөгч ялын хэмжээний талаар, 22.2 хувь буюу 26 хэрэгт торгох ял оногдуулах талаар тус тус санал гаргасан байна. Харин нийт хэргийн 11.9 хувь буюу 14 хэрэгт өмгөөлөгч тодорхой санал гаргаагүй байна. Ямар учраас ялын талаар санал гаргаагүй байгаа нь хавтаст хэрэгт тусгагдаагүй байна.


График 29: Давах болон хяналтын шатны шүүх



**Давж заалдах шатны шүүх.** Нийт хэргийн 34.1 хувь буюу 40 хэрэгт давж заалдах гомдол гаргасан байна. Давж заалдах шатны шүүх нийт ирүүлсэн гомдлын 67.5 хувь буюу 27 хэрэгт анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, үлдсэн 13 хэрэгт шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан байна. Үүнээс үзэхэд 3 хэрэг тутмын 1-д давж заалдах гомдлыг хүлээн авсан байх бөгөөд хүлээн авсан 3 хэрэг тутмын 2-д гомдлыг хэрэгсэхгүй болгосон байна.

**Хяналтын шатны шүүх.** Нийт хэргийн 24.7 хувь буюу 29 хэрэгт хяналтын журмаар гомдол гаргасан байна. Хяналтын шатны шүүх нийт ирүүлсэн гомдлын 75.8 хувь буюу 22 хэрэгт анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх, гомдлыг хэлэлцүүлэхээс татгалзсан байна. Үүнээс үзэхэд хяналтын шатны шүүх 4 хэрэг тутмын 3-д гомдол хүлээн авч, хэлэлцүүлэхгүй байгаа бөгөөд давж заалдах гомдлоор хэрэг эцэслэн шийдвэрлэгдэж байна.

Харин 1 хэргийг 3 шатны шүүх ялгаатай шийдвэрлэсэн байна. Үүнд:




Ийнхүү шийдвэрлэсэн нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан зохицуулалтай холбоотой юм. Учир нь давж заалдах шатны шүүх ялыг “хүндрүүлж” болох эрх хэмжээтэй байсан бөгөөд Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 1 дүгээр дүгнэлтээр тус зохицуулалт нь шүүхийн шийдвэрийг давж заалдах, төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх, хөндөгдсөн

эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцах заалтыг зөрчсөн гэж үзсэн. Тиймээс тус заалтыг түдгэлзүүлсэн байсныг Монгол Улсын Их Хурал хүлээн зөвшөөрч, 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулж, тус заалтыг хассан.

### 3.4. Давхар зүйлчлэл (Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйл. Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах болон 22.4 дүгээр зүйл. Нийтийн албан тушаалтан хахууль авах)

2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ны өдрийг хүртэлх хугацаанд нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйл болон 22.4 дүгээр зүйлд зааснаар нийт 15 гэмт хэрэг шүүхээр хянан шийдвэрлэгдэж хүчин төгөлдөр болсон байна.<sup>38</sup>

График 30: Шүүхийн харьяалал



Нийт хэргийн 27 хувь буюу 4 хэрэг Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт үйлдэгдэж шүүхээр хянан шийдвэрлэгдсэн бол нийт хэргийн 20 хувь буюу 3 хэрэг Баянзүрх, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт тус тус үйлдэгдсэн байна.

Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн ял оногдуулахад улсын яллагчаас эрүүгийн хариуцлагын талаар гаргасан санал, хэмжээ, шүүхийн шийдвэрийг харьцуулан харуулбал:

<sup>38</sup> Улсын ерөнхий прокурорын газрын Эрүүгийн хэргийн төв архивт архивлагдсан эрүүгийн дугаар бүхий хавтаст хэргүүд (2024 он)

Ялын нэр	Хэмжээ	Прокурор	Шүүх
Торгох ял (нэгжээр)	5.400-14.000	3	3
	14.000-27.000	2	5
	27.000-40.000	1	4
		6	12
Зорчих эрх хязгаарлах ял (жилээр)	4-5		1
			1
Хорих ял (жилээр)	1-2	1	
	2-3	3	
	3-4	2	2
	4-5		
	5-6	1	
	6-7	1	
	7-8	1	
		9	2
<b>Нийт</b>		<b>15</b>	<b>15</b>
Эрх хасах ял (жилээр)	1-2	1	1
	2-3	1	1
	3-4	2	2
	4-5	1	2
	5-6	1	
	6-7	5	5
	7-8	4	4
<b>Нийт</b>		<b>15</b>	<b>15</b>

**Торгох ял.** Нийт хэргийн 40 хувь буюу 6 хэрэгт прокуророос торгох ялын санал гаргаж, 80 хувь буюу 12 хэрэгт шүүхээс торгох ял оногдуулсан байна. Үүнээс үзэхэд торгох ялын төрлийг 5 хэрэг тутмын 2-д оногдуулах саналыг прокуророос гаргахад шүүх 5 хэрэг тутмын 4-д тус ялыг оногдуулсан байна. Өөрөөр хэлбэл, шүүх прокурорын саналаас 2 дахин олон торгох ял оногдуулсан байна. Мөн торгох ялын санал гаргасан нийт хэргийн 20 хувь буюу 3 хэрэгт прокуророос 14.000-40.000 нэгжийн хооронд торгох ялын санал гаргахад шүүх 60 хувь буюу 9 хэрэгт дээрх хэмжээний дотор торгох ял оногдуулсан бол бусад тохиолдолд тухайн саналаас 3 дахин бага хэмжээгээр торгох ялыг оногдуулсан байна.


**Зорчих эрхийг хязгаарлах ял.** Нийт хэрэгт прокуророос зорчих эрхийг хязгаарлах ялын санал огт гаргаагүй байхад шүүх 1 хэрэгт тус ялыг оногдуулсан байна. Ялын хэмжээний хувьд 4-5 жилийн хооронд оногдуулсан байна.

**Хорих ял.** Харин нийт хэргийн 60 хувь буюу 9 хэрэгт прокуророос хорих ялын санал гаргахад 13.3 хувь буюу 2 хэрэгт шүүхээс хорих ял оногдуулсан байна. Үүнээс үзэхэд прокуророос хорих ялын төрлийг сонгож санал гаргахад шүүх 4.5 дахин бууруулж хорих ялыг оногдуулсан байна. Ялын хэмжээний хувьд прокуророос 4 жилээс дээш хэмжээний хорих ялыг оногдуулахаар санал гаргахад шүүх хүлээн аваагүй байна.

**Тэнсэх.** Нийт хэрэгт прокуророос тэнсэх арга хэмжээ авхуулах санал гаргаагүй байна. Мөн шүүх тэнсэх арга хэмжээ оногдуулаагүй байна.


**Эрх хасах ял.** Нийт хэргийн 33.3 хувь буюу 5 хэрэгт прокуророос 6-7 жилийн хооронд эрх хасах ялын хэмжээг санал гаргахад шүүх уг хэмжээгээр эрх хасах ялыг оногдуулсан байна. Үүнээс үзэхэд эрх хасах ялын хэмжээ прокурорын гаргасан саналын хүрээнд байна.

График 31: Шүүх хуралдаанд шүүгдэгчийн өмгөөлөгчөөс эрүүгийн хариуцлагын талаар гаргасан санал



Нийт хэргийн 93.3 хувь буюу 14 хэрэгт шүүгдэгч өмгөөлөгчтэй, 1 хэрэгт шүүгдэгч өөрийгөө өмгөөлж оролцсон байна. Үүнээс үзэхэд 10 хэрэг тутмын 1-д шүүгдэгч өмгөөлөгчгүй шүүх хуралдаанд оролцсон байна. Нийт хэргийн 26.6 хувь буюу 4 хэрэгт өмгөөлөгч улсын яллагчтай оногдуулах ялын талаар санал нэг байсан байна. Үүнээс үзэхэд 5 хэрэг тутмын 1-д оногдуулах ялыг өмгөөлөгч хүлээн зөвшөөрсөн байна. Мөн нийт хэргийн 20 хувь буюу 3 хэрэгт өмгөөлөгч ялын хэмжээний талаар, 26.6 хувь буюу 4 хэрэгт торгох ял оногдуулах талаар тус тус санал гаргасан байна. Харин нийт хэргийн 6.6 хувь буюу 1 хэрэгт өмгөөлөгч тодорхой санал гаргаагүй байна. Ямар учраас ялын талаар санал гаргаагүй байгаа нь хавтаст хэрэгт тусгагдаагүй байна.

График 33: Давах болон хяналтын шатны шүүх



**Давж заалдах шатны шүүх.** Нийт хэргийн 40 хувь буюу 6 хэрэгт давж заалдах гомдол гаргасан байна. Давж заалдах шатны шүүх нийт ирүүлсэн гомдлын 66.6 хувь буюу 4 хэрэгт анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, үлдсэн 2 хэрэгт шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан байна. Үүнээс үзэхэд 5 хэрэг тутмын 2-д давж заалдах гомдлыг хүлээн авсан байх бөгөөд хүлээн авсан 3 хэрэг тутмын 2-д гомдлыг хэрэгсэхгүй болгосон байна.

**Хяналтын шатны шүүх.** Нийт хэргийн 33.3 хувь буюу 5 хэрэгт хяналтын журмаар гомдол гаргасан байна. Хяналтын шатны шүүх нийт ирүүлсэн гомдлын 80 хувь буюу 4 хэрэгт гомдлыг хэлэлцүүлэхээс татгалзсан байна. Үүнээс үзэхэд хяналтын шатны шүүх 5 хэрэг тутмын 4-д гомдол хүлээн авч, хэлэлцүүлэхгүй байгаа бөгөөд давж заалдах гомдлоор хэрэг эцэслэн шийдвэрлэгдэж байна.

### Дэд хэсгийн дүгнэлт

Хавтаст хэргийн судалгааны үр дүнд дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

1. Нийт авлигын хэргийн 63 хувь буюу 2/3 хэсгийг Сүхбаатар, Чингэлтэй, Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шүүх хянан хэлэлцсэн байгаа нь "зүүн" хэсэгт байрлах шүүх энэ төрлийн гэмт хэргийг түлхүү шийдвэрлэсэн буюу нийслэл хотын төв, зүүн, хойд хэсэгт авлига, албан тушаалын гэмт хэрэг голчлон үйлдэгддэг.
2. Нийт шийдвэрлэсэн Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн гэмт хэргийн 80-ээс дээш хувийг 22.1 дүгээр зүйл болон 22.4 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг эзэлж байна.
3. Авлигын гэмт хэрэг үйлдсэн шүүгдэгчид 31-49 насныхан голчлон байх бөгөөд 30 хүртлээ болон 50 наснаас дээш насныхан үйлдсэн тохиолдол цөөн байна.

4. Нийт хэрэгт шүүгдэгч нар (хамтран оролцсон бол зохион байгуулагч) 119,414,427,344 (нэг зуун арван есөн тэрбум дөрвөн зуун арван дөрвөн сая дөрвөн зуун хорин долоон мянга гурван зуун гучин дөрөв) төгрөгийн хохирол учирсан гэж шүүх дүгнэсэн байна. Үүнээс 60 хувь буюу 72,791,195,973 төгрөгийг Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт учруулсан байна.
5. Нийт хэрэгт шүүгдэгч нар (хамтран оролцсон бол зохион байгуулагч)-ын 48 хувь буюу 117 хэрэгт хохирлоо нөхөн төлсөн, 30 хувь буюу 73 хэрэгт хохирлоо нөхөн төлөөгүй, үлдсэн 22 хувь буюу 54 хэрэгт нөхөн төлөх шаардлагагүй гэж шүүх дүгнэсэн байна. Нөхөн төлөх шаардлагагүй гэдэг нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг шүүгдэгч нар бус бусад этгээдүүд хариуцах ёстой гэж үзсэн байна.
6. Нийт хэрэгт учирсан хор уршгийг шүүх тодорхойлоогүй байна. Улсын яллагчийн зүгээс тодорхой тооны хэргүүдэд хор уршиг учирсан гэж шүүхэд санал гаргасан боловч шүүх хүлээн аваагүй байна.
7. Нийт хэргийн 72 хувьд шүүгдэгч нар (хамтран оролцсон бол зохион байгуулагч)-т эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх болон хөнгөрүүлэх нөхцөл байдлыг талаар дурдаагүй, хууль зүйн дүгнэлт хийгээгүй.
8. Нийт хэргийн 32 хувьд хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн байна. Энэ нь 3 хэрэг тутмын 1-д шүүгдэгч нар гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн байна гэж үзэж болох боловч хянан шийдвэрлэхдээ дунджаар 2 жил гарангын хугацаа зарцуулж байгаа нь хялбаршуулах үндэслэл, шаардлага, ач холбогдолгүй болсон байдагтай холбоотой.
9. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйл
  - Торгох ялын талаар прокурорын зүгээс гаргасан санал, шүүхийн шийдвэр 2 ойролцоо хэмжээнд байна.
  - Харин хорих ялын талаар прокурор зүгээс гаргасан саналаас шүүхийн шийдвэр 2 дахин бага хэмжээнд байна.
  - Өмгөөлөгчийн хувьд эрүүгийн хариуцлагын талаар 20 орчим хувьд улсын яллагчтай санал нэг буюу хүлээн зөвшөөрсөн байна. Харин 15 хувьд тодорхой санал гаргаагүй байна. Ямар учраас санал гаргаагүй нь тодорхой бус байна.
  - Нийт хэргийн 29 хувьд давж заалдах журмаар гомдол гаргасан байна. Ирүүлсэн гомдлын 73 хувьд анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн байна.
  - Нийт хэргийн 20 хувьд хяналтын журмаар гомдол гаргасан байна.

Ирүүлсэн гомдлын 93 хувьд анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн байна. Өөрөөр хэлбэл хэрэг давж заалдах шатны шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэж байна.

10. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.4 дүгээр зүйл

- Торгох ялын талаар прокурорын зүгээс гаргасан санал нь шүүхийн шийдвэрээс 20 орчим хувиар илүү байна.
- Харин хорих ялын талаар прокурор зүгээс гаргасан саналаас шүүхийн шийдвэр 3 дахин бага хэмжээнд байна.
- Өмгөөлөгчийн хувьд эрүүгийн хариуцлагын талаар 17 хувьд улсын яллагчтай санал нэг буюу хүлээн зөвшөөрсөн байна. Харин 12 хувьд тодорхой санал гаргаагүй байна. Ямар учраас санал гаргаагүй нь тодорхой бус байна.
- Нийт хэргийн 34 хувьд давж заалдах журмаар гомдол гаргасан байна. Ирүүлсэн гомдлын 67 хувьд анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн байна.
- Нийт хэргийн 25 хувьд хяналтын журмаар гомдол гаргасан байна. Ирүүлсэн гомдлын 76 хувьд анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн байна. Өөрөөр хэлбэл 4 хэрэг тутмын 3 нь давж заалдах шатны шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэж байна.

11. Эрүүгийн хуулийн 22.1 болон 22.4 дүгээр зүйлийг давхар зүйлчилсэн тохиолдолд:

- Торгох ялын талаар прокурорын зүгээс гаргасан санал нь шүүхийн шийдвэрээс 2 дахин бага байна.
- Харин хорих ялын талаар прокурор зүгээс гаргасан саналаас шүүхийн шийдвэр 4.5 дахин бага хэмжээнд байна.
- Өмгөөлөгчийн хувьд эрүүгийн хариуцлагын талаар 27 хувьд улсын яллагчтай санал нэг буюу хүлээн зөвшөөрсөн байна.
- Нийт хэргийн 40 хувьд давж заалдах журмаар гомдол гаргасан байна. Ирүүлсэн гомдлын 67 хувьд анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн байна.
- Нийт хэргийн 33 хувьд хяналтын журмаар гомдол гаргасан байна. Ирүүлсэн гомдлын 80 хувьд анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн байна. Өөрөөр хэлбэл 5 хэрэг тутмын 4 нь давж заалдах шатны шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэж байна.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ГАДААД ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Энэ бүлэгт Бүгд Найрамдах Солонгос Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эрүүгийн хуульд нийтийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах болон хахууль авах гэмт хэргийн шинж, хүлээлгэх эрүүгийн хариуцлага, хөөн хэлэлцэх хугацааны онцлогийг харьцуулан судаллаа.

### 4.1. Бүгд Найрамдах Солонгос Улсын Эрүүгийн хууль<sup>39</sup>

Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)-ын Эрүүгийн хууль нь 1953 онд батлагдсан бөгөөд ерөнхий ба тусгай ангиас бүрддэг. Нийт 43 зүйл 372 зүйл ангитай. Эрүүгийн хуулийн 7 дугаар бүлэгт албан тушаалын болон авлигын 13 төрлийн гэмт хэргийг тодорхойлж, хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хуульчилсан байдаг. Тухайлбал:

- 122 дугаар зүйл. Албаны үүргээ биелүүлэхгүй байх
- 123 дугаар зүйл. Эрх мэдлээ урвуулан ашиглах
- 129 дүгээр зүйл. Хээл хахууль авах болон авах талаар мэдэгдэх
- 130 дугаар зүйл. Гуравдагч хүнд хахууль өгөх
- 131-р зүйл. Хахууль авсны дараа амлалтаа зөрчих, нэмж авах
- 132 дугаар зүйл. Сайн албан тушаалтан<sup>40</sup> хахууль авах зэрэг гэмт хэргийг дурдаж болно.

<sup>39</sup> БНСУ-ын Эрүүгийн хууль (1998 он) цахим эх сурвалж: <https://www.refworld.org/legal/legislation/natlegbod/1953/en/37944>

<sup>40</sup> Good office-үгийн тайлбар: “Олон улсын эрх зүй, олон улсын харилцаанд НҮБ-ын дүрмийн дагуу “сайн албан тушаал” гэсэн нэр томъёо нь хоёр талын болон олон улсын мөргөлдөөнийг шийдвэрлэх, талуудыг хэлэлцээнд оролцуулах зорилготой гуравдагч орон эсвэл төвийг сахисан байгууллагын дипломат болон хүмүүнлэгийн ажил эрхлэгчийг хэлнэ” гэжээ. Цахим эх сурвалж: Швейцарь Гадаад харилцааны яамны цахим хуудас. <https://www.eda.admin.ch/eda/en/fdfa/foreign-policy/human-rights/peace/switzerland-s-good-offices.html#:~:text=In%20international%20law%20and%20international,parties%20to%20the%20negotiating%20table>

Дээрх гэмт хэргүүдээс Эрүүгийн хуулийн 122 дугаар зүйлд заасан албаны үүргээ биелүүлэхгүй байх гэмт хэргийг “Төрийн албан хаагч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр албаны үүргээ биелүүлэхгүй байх эсвэл биелүүлэхээс татгалзсан бол нэг жил хүртэлх хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэхгүйгээр болон хийлгэж хорих, эсвэл мэргэшлийг үйл ажиллагаа эрхлэх эрхийг гурван жилээс илүүгүй хугацаагаар хасна”.

Мөн хуулийн 123 дугаар зүйлд заасан эрх мэдлээ урвуулан ашиглах гэмт хэргийг “Төрийн албан хаагч нь албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглан бусдаар хийх ёсгүй үүргийг гүйцэтгүүлсэн, эсхүл эдлэх ёстой эрхээ хэрэгжүүлэхэд нь саад учруулсан бол таван жил хүртэлх хугацаагаар хорих, арван жил хүртэлх хугацаагаар мэргэшлийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах, эсвэл арван сая вон хүртэлх мөнгөн торгох ял шийтгэнэ” гэж 2 төрлийн гэмт хэргийг ялган заасан нь манай улсын Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлд заасан эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэгтэй төстэй агуулгатай байна.

Харин БНСУ-ын Эрүүгийн хуульд хүндрүүлэх шинжийг хуульчлаагүй нь манайхаас ялгаатай байгаа бөгөөд учир нь “Тодорхой төрлийн гэмт хэрэгт илүү хүнд ял шийтгэл оногдуулах тухай хууль<sup>41</sup>”-р албан тушаалтантай холбоотой гэмт хэрэгт Эрүүгийн хуульд зааснаас илүү хүнд ял шийтгэл оногдуулах боломжтой зохицуулалтыг ашигладагтай холбоотой юм.

БНСУ-ын Эрүүгийн хуулийн 122, 123 дугаар зүйлд засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, хорих, эрх хасах, торгох гэсэн 4 төрлийн ял шийтгэлийг хуульчилсан бол манай улсын Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлд эрх хасах, зорчих эрхийг хязгаарлах, хорих ял оногдуулах гэсэн 3 төрлийн ял оногдуулахаар хуульчилсан байдаг. Хорих ялын хувьд доод хязгаарыг зааж өгөөгүй нь ялгаатай байх боловч дээд хязгаарыг 5 жил гэсэн нь хоёр орны Эрүүгийн хуульд ижилхэн хэмжээ юм. Харин эрх хасах ялын хувьд манай улсын Эрүүгийн хуульд нэмэгдэл ял гэж үзсэн бол БНСУ-ын Эрүүгийн хуульд дангаар нь хэрэглэж манай улсынхаас 2 дахин урт хугацаатай байхаар зохицуулжээ.

Гэмт хэргийн шинжийн хувьд БНСУ-ын Эрүүгийн хуульд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр албаны үүргээ биелүүлэхгүй байх, биелүүлэхээс татгалзсан, эрх мэдлээ урвуулан ашиглан бусдаар хийх ёсгүй үүргийг гүйцэтгүүлсэн, эдлэх ёстой эрхээ хэрэгжүүлэхэд нь саад учруулсан гэх зэргээр хуульчилсан байгаа нь манай улсын Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, эсхүл зориуд

<sup>41</sup> “Тодорхой төрлийн гэмт хэрэгт илүү хүнд ял шийтгэл оногдуулах тухай хууль (1966 он) цахим эх сурвалж: [https://elaw.klri.re.kr/eng\\_mobile/viewer.do?hseq=45379&type=part&key=9](https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=45379&type=part&key=9)

хэрэгжүүлэхгүй байж өөртөө, эсхүл бусдад давуу байдал бий болгосон гэснээс ялгаатай буюу манайхаас илүү тодорхой хуульчилсан байна.

Жишээ нь: манай улсын Эрүүгийн хуульд нийтийн албан тушаалтан албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж өөртөө эсвэл бусдад давуу байдал бий болгосон гэснээс үзэхэд хэрвээ давуу байдал үүсгээгүй бол гэмт хэрэгт тооцогдохооргүй байна. Харин БНСУ-ын хувьд давуу байдал үүсгэсэн эсэхээс үл хамаарч зөвхөн албаны үүргээ биелүүлэхгүй байх тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой байна.

Хахууль авах гэмт хэргийн хувьд БНСУ-ын Эрүүгийн хуулийн 129 дүгээр зүйлд заасан хээл хахууль авах болон авах талаар мэдэгдэх гэмт хэргийг:

(1) Төрийн албан хаагч эсвэл арбитрч нь албаны үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан авлига авсан, шаардсан, авахаар амласан бол таван жил хүртэлх хугацаагаар хорих, эсхүл арван жил хүртэлх жилийн хугацаагаар мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасна.

(2) Төрийн албан хаагч, арбитрч болох гэж байгаа этгээд нь гүйцэтгэх үүрэгтэйгээ холбогдуулан авлига авсан, шаардсан, амлан гүйцэтгэсэн, түүнчлэн үүнийхээ хариуд жинхэнэ төрийн албан хаагч, арбитрч болсон бол гурван жил хүртэлх хугацаагаар хорих, эсвэл долоон жил хүртэлх хугацаагаар мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасна,

Мөн хуулийн 130 дугаар зүйлд заасан гуравдагч хүнд хахууль өгөх гэмт хэргийг “Төрийн албан хаагч, арбитрч албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан үндэслэлгүй хүсэлтийг хүлээн авсан нь гуравдагч этгээдэд хээл хахууль өгөх, шаардах, амлах үндэслэл болсон бол таван жил хүртэлх хугацаагаар хорих, арван жил хүртэлх жилийн хугацаагаар мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасна”,

Мөн хуулийн 131-р зүйлд заасан хахууль авсны дараа амлалтаа зөрчих, нэмж авах гэмт хэргийг:

(1) Төрийн албан тушаалтан эсвэл арбитрч өмнөх хоёр зүйлд заасан гэмт хэргийг үйлдсэний дараа амлалтаа зөрчсөн бол нэг жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ.

(2) Төрийн албан хаагч, арбитрч гуравдагч этгээдэд хахууль өгөхөөр хахуулийг хүлээн авсан, шаардсан, амласны дараа албаны үүргээ ашиглан амлалтаа зөрчсөн бол өмнөх хэсэгт зааснаар ял шийтгэнэ.

(3) Төрийн албан тушаалтан, арбитрч байсан этгээд албан тушаал эрхэлж байх хугацаандаа хахууль авсны дараа амлалтаа зөрчиж дахин хахууль авсан,

шаардсан, амласан бол 5 жил хүртэлх хугацаагаар хорих, эсвэл арван жил хүртэлх жилийн хугацаагаар мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасна.

(4) Өмнөх гурван хэсэгт заасан тохиолдолд дахин арван жил хүртэлх хугацаагаар мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасаж болно” гэж хуульчилсан нь манай улсын Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан нийтийн албан тушаалтан хахууль авах гэмт хэрэгтэй ижил агуулгатай юм.

БНСУ-ын хувьд дээрх гэмт хэргүүд нь хорих, эрх хасах гэсэн 2 төрлийн ялын төрөлтэй байгаа нь манай улсын Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлд заасан ялын 2 төрөлтэй ижилхэн байгаа боловч БНСУ-д уг 2 ялыг тус тусад нь оногдуулахаар хуульчилсан бол манай улсад эрх хасах ялыг нэмэгдэл ял болгож хэрэглэхээр зохицуулсан байдгаараа ялгаатай байна.

Харин БНСУ-д хорих ялын доод хэмжээг заагаагүй, дээд хэмжээг 5 жил, эрх хасах ялын дээд хэмжээ нь 10 жил байгаа бол манай улсын хувьд хүндрүүлэх шинжгүй бол 2-8 жилийн хугацаагаар эрх хасаж 2-8 жилийн хугацаагаар хорих ял шийтгэхээр хуульчилсан нь ялын бодлогын хувьд манай улс илүү хатуу байгаа нь харагдаж байна.

Хэргийн хөөн хэлэлцэх хугацааг харьцуулахад Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22.1 болон 22.4 дүгээр зүйл хүндрүүлэх шинжгүй тохиолдолд 5 жил байгаа бол БНСУ-ын хувьд хөөн хэлэлцэх хугацааг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулсан байдаг. Тус хуулийн 249 дүгээр зүйлд дараах хугацаа өнгөрсөн бол гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэж үздэг байна. Тухайлбал, мөн зүйлийн

1 дэх хэсэгт цаазаар авах ялтай гэмт хэрэгт 25 жил,

2 дахь хэсэгт бүх насаар нь хорих, эсвэл бүх насаар нь хорих ял оногдуулах гэмт хэрэг үйлдсэн бол 15 жил,

3 дахь хэсэгт 10 ба түүнээс дээш жил хорих эсвэл 10 ба түүнээс дээш жил хорих ял оногдуулах гэмт хэрэг үйлдсэн бол 10 жил,

4 дэх хэсэгт 10 жилээс доош хугацаагаар хорих ял эсвэл 10 жилээс доош хугацаагаар хорих ял оногдуулах гэмт хэрэг үйлдсэн бол 7 жил,

5 дахь хэсэгт 5 жилээс дээш хугацаагаар хорих эсвэл торгох ял оногдуулах, 10 ба түүнээс дээш жилээр албан тушаал эрхлэх эрх хасах гэмт хэрэг үйлдсэн бол 5 жил,

6 дахь хэсэгт 5 жилээс доош хугацаагаар хорих эсвэл 5 жилээс доош хугацаагаар хорих ял оногдуулах гэмт хэрэг үйлдсэн бол 3 жил,

7 дахь хэсэгт 5 жилээс доош хугацаагаар түдгэлзүүлэх, баривчлах, торгох, эд хөрөнгө хураах гэмт хэрэг үйлдсэн бол 1 жил гэж тус тус хуульчилсан байна.

Түүнчлэн, мөрдөн байцаалтын ажиллагаа дуусаж, прокуророос яллах дүгнэлт үйлдэж шүүхэд ирүүлснээс хойш 25 жилийн хугацаа өнгөрсөн бол хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэж үздэг ба гэмт хэрэг дуусгавар болсон үеэс эхлэн тоолж эхэлдэг зохицуулалттай.

Мөн хөөн хэлэлцэх хугацааг процессын хуульд, шүүхийн шийдвэр биелүүлэх хугацааг Эрүүгийн хуульд заасан нь манай улсын хуулиас ялгаатай бөгөөд зөвхөн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш тоолдог хугацааг хуульчилсан байна.

Жишээ нь: БНСУ-ын Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлд хөөн хэлэлцэх хугацааг “Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш дараах хугацаанд тогтоол биелэгдээгүй тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа дуусна: Цаазаар авах ял оногдуулсан бол гучин жил; эсхүл бүх насаар нь хорих ялаар шийтгүүлсэн бол хорин жил; эсхүл арваас доошгүй жил хорих ялаар шийтгүүлсэн бол арван таван жил; 3-аас доошгүй жил хорих, эсхүл хорих ангид ажил хийлгэхгүйгээр хорих ялаар шийтгэсэн, эсхүл мэргэшлийг нь арваас доошгүй жилээр хассан бол арван жил; 3 жилээс доош хугацаагаар хорих, эсхүл хорих ял эдлүүлэхгүйгээр хорих ял, эсхүл мэргэшлийг нь таваас доошгүй жилээр хассан бол таван жил; таван жилээс доош хугацаагаар мэргэшүүлэх эрхийг түдгэлзүүлсэн бол гурван жил, торгох, хураах, хураах; баривчлах, бага зэрэг торгох тохиолдолд нэг жил өнгөрсөн бол” гэж хуульчилсан байна.

Ийнхүү шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд хөөн хэлэлцэх хугацааг тоолдогтой холбоотойгоор яллагдагчийг цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан тохиолдолд уг хугацааг түүний хорих ялын хугацаанд оруулан тооцдоггүй.

## 4.2. Оросын Холбооны Улсын Эрүүгийн хууль<sup>42</sup>

Оросын Холбооны Улс (ОХУ)-д 1996 онд Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулсан бөгөөд уг хууль нь ерөнхий болон тусгай ангиас бүрдэх ба нийт 32 бүлэгтэй. Эрүүгийн хуулийн 30 дугаар бүлэг “Төрийн эрх мэдэл, ашиг сонирхол, төрийн албан болон орон нутгийн албаны эсрэг гэмт хэрэг”-тэй холбоотой 17 гэмт хэргийг хуульчилсан. Тухайлбал,

- 285 дугаар зүйл. Эрх мэдлээ урвуулан ашиглах
- 290 дүгээр зүйл. Хээл хахууль авах
- 291 дүгээр зүйл. Жижиг хээл хахууль авах зэрэг гэмт хэргийг дурдаж болно.

<sup>42</sup> Доктор Ж.Эрдэнэбулган, Т.Золбоо, М.Уянга, Б.Тамир, Б. Батбаяр нар (2021 он) “Монгол, Орос, Хятад, Германы Улсын Эрүүгийн хууль” орчуулгын бүтээлийн 236-241 тал

Эрүүгийн хуулийн 285 дугаар зүйлд заасан эрх мэдлээ урвуулан ашиглах гэмт хэргийг:

1. Албан тушаалтан албаны бүрэн эрхийг албан ажлын ашиг сонирхолд харш ашигласан нь шунахай буюу хувийн бусад ашиг сонирхлын үүднээс үйлдэгдсэн ба иргэн буюу байгууллагын эрх ба хууль ёсны ашиг сонирхол, эсхүл нийгэм буюу төрийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг ноцтой зөрчсөн бол 80.000 хүртэл рубль, эсхүл ялтны 6 сар хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл тодорхой албан тушаал эрхлэх, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг 5 жил хүртэл хугацаагаар хасах, эсхүл 4 жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөр хийлгэх, эсхүл 4-6 сарын хугацаагаар баривчлах, эсхүл 4 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2. Энэ хэргийг төрийн албан хаагч эсхүл субъектийн төрийн албан хаагч, эсхүл орон нутгийн засаг захиргааны байгууллагын тэргүүн үйлдсэн бол 100.000-300.000 рубль эсхүл ялтны хагас жилээс 2 жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох торгох, эсхүл тодорхой албан тушаал эрхлэх, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг 3 жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр 5 жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөр хийлгэх, эсхүл тодорхой албан тушаал эрхлэх, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг 3 жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр 7 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
3. Энэ зүйлийн 1 болон 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийн улмаас хүнд хор уршигт хүргэсэн бол тодорхой албан тушаал эрхлэх, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг 3 жил хүртэл хугацаагаар хасаж 10 жилийн хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж хуульчилсан.

Дээрх хуулиас үзэхэд эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх шинжгүй бол 80.000 хүртэл рубль, эсхүл 6 сар хүртэлх хугацааны цалин болон орлоготой тэнцэх хэмжээний рублиэр торгох, эсхүл тодорхой ажил, албан тушаал эрхлэх эрхийг 5 хүртэл жилээр хасах, эсхүл 4 жил хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл 4-6 сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл 4 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар заажээ.

Манай улсын Эрүүгийн хуулиас ялгаатай нь торгох ялыг оруулж өгсөн бөгөөд мөн тухайн ялтны ямар ажил хийж байгаа түүний цалингийн орлогоор торгох гэсэн 2 төрлийн хэлбэрээр торгох зохицуулалтаар ялгагдахаас гадна албадан ажил хийлгэх, баривчлах зэрэг ялын олон төрлүүдээс сонгох боломжтой байна. Мөн хорих ялын доод хязгаарыг заагаагүй бөгөөд манай улсын Эрүүгийн хуулиас 1 жилийн хугацаагаар богино хугацаа заасан нь ялын бодлогын хувьд бага зэрэг зөрүүтэй болох нь харагдаж байна.

Харин хахууль авах гэмт хэргийн хувьд ОХУ-ын Эрүүгийн хуулийн 290 дүгээр зүйлд хээл хахууль авах гэмт хэргийг:

1. Төрийн албан хаагч, гадаад улсын нийтийн албан тушаалтан, олон улсын байгууллагын нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхэд хамаарах, эсхүл ийм үйлдэл (эс үйлдэхүй)-ээр албан тушаалынхаа байдлаараа тус үзүүлж чадахуйц, түүнчлэн албаны талаар ерөнхий ивээлд авч буюу зөнд нь орхих үйлдлээр хахууль өгөгч буюу түүнийг төлөөлсөн этгээдэд ашигтай үйлдэл (эс үйлдэхүй) хийж, биечлэн буюу зуучлагчаар дамжуулан мөнгө, үнэт цаас, бусад эд хөрөнгө буюу эд хөрөнгийн шинжтэй үйлчилгээ бусад эд хөрөнгийн эрх, ашиг авсан бол нэг сая хүртэл рубль эсхүл ялтны хоёр жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсвэл тодорхой албан тушаал эрхлэх, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасаж хээл хахуулийн хэмжээг арваас арван тав дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр торгох, эсхүл тодорхой албан тушаал эрхлэх, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасаж хээл хахуулийн хэмжээг арваас арван тав дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр торгох, эсхүл тодорхой албан тушаал эрхлэх, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасаж таван жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөр хийлгэх, эсхүл авлигын хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэн хэмжээний мөнгөн дүнгээр торгох буюу торгохгүйгээр гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2. Төрийн албан хаагч, гадаадын олон нийтийн албан тушаалтан, засгийн газар хоорондын олон улсын байгууллагын албан тушаалтан их хэмжээгээр хээл хахууль авсан бол хоёр зуун мянгаас нэг сая хүртэл рубль эсхүл ялтны зургаан сараас хоёр жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл тодорхой албан тушаал эрхлэх, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасаж авилгын хэмжээг гучаас жар дахин нэмэгдүүлсэн хэмжээний мөнгөн дүнгээр торгох, эсхүл тодорхой албан тушаал эрхлэх, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
3. Засгийн газар хоорондын олон улсын байгууллагын албан тушаалтан, гадаад улсын олон нийтийн албаны албан тушаалтан, албан тушаалтны хууль бус үйлдэл (эс үйлдэхүй)-ийн төлөө хээл хахууль авсан бол таван зуу мянгаас хоёр сая хүртэл рубль эсхүл ялтны зургаан сараас хоёр жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл тодорхой албан тушаал, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл

хугацаагаар хасаж авлигын хэмжээг дөчөөс далан тав дахин нэмэгдүүлсэн хэмжээний мөнгөн дүнгээр торгох, эсхүл тодорхой албан тушаал, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг долоон жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр авлигын хэмжээг дөч дахин нэмэгдүүлсэн хэмжээний мөнгөн дүнгээр торгох буюу торгохгүйгээр гурваас найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4. Энэ зүйлийн нэгээс гурав дахь хэсэгт заасан хэргийг ОХУ-ын төрийн албан тушаалтан эсвэл ОХУ-ын субъектийн төрийн албан тушаалтан, орон нутгийн засаг захиргааны байгууллагын тэргүүн үйлдсэн бол нэгээс гурван сая хүртэл рубль эсхүл ялтны нэгээс гурван жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл тодорхой албан тушаал, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг долоон жил хүртэл хугацаагаар хасаж авлигын хэмжээг жараас наяд дахин нэмэгдүүлсэн хэмжээний мөнгөн дүнгээр торгох, эсхүл тодорхой албан тушаал, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг долоон жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр авлигын хэмжээг тавь дахин нэмэгдүүлсэн хэмжээний мөнгөн дүнгээр торгож таваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
5. Энэ зүйлийн нэг, гурав, дөрөв дэх хэсэгт заасан хэргийг:
  - а) урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, эсвэл зохион байгуулалттай бүлэг;
  - б) хясан боогдуулах, далайлган сүрдүүлэх аргаар;
  - в) их хэмжээгээр үйлдсэн бол хоёроос дөрвөн сая хүртэл рубль эсхүл ялтны хоёроос дөрвөн жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл тодорхой албан тушаал, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг арван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр авлигын хэмжээг далаас ер дахин нэмэгдүүлсэн хэмжээний мөнгөн дүнгээр торгох, эсхүл тодорхой албан тушаал, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг арван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр авлигын хэмжээг жар дахин нэмэгдүүлсэн хэмжээний мөнгөн дүнгээр торгох буюу торгохгүйгээр долоогоос арван хоёр хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
6. Энэ зүйлийн тав, гуравдахь хэсгийн дөрөв дэх хэсэгт заасан хэргийг их хэмжээгээр үйлдсэн бол гурван саяас таван сая хүртэл рубль эсхүл ялтны гурваас таван жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл тодорхой албан тушаал, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг арван таван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр наймаас арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Дээрх хуулиас үзэхэд эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх шинжгүй бол 1 сая хүртэл рубль, эсхүл 2 жил хүртэлх хугацааны цалин болон орлоготой тэнцэх хэмжээний рублиэр торгох, эсхүл тодорхой ажил, албан тушаал эрхлэх эрхийг 3 хүртэл жилээр хасаж хээл хахуулийн хэмжээг 10-15 дахин нэмэгдүүлж торгох, эсхүл тодорхой ажил, албан тушаал эрхлэх эрхийг 3 хүртэл жилээр хасаж 1-2 жилийн хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл тодорхой ажил, албан тушаал эрхлэх эрхийг 3 хүртэл жилээр хасаж 5 хүртэлх жилээр албадан ажил хийлгэх, эсхүл авлигын хэмжээг 10-20 дахин нэмэгдүүлж торгох буюу торгохгүйгээр 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заажээ.

Манай улсын Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлд заасан хахууль авах гэмт хэргээс ялгаатай нь торгох ял болон тухайн ялтны ямар ажил хийж байгаа түүний цалингийн орлогоор торгох гэсэн 2 төрлийн хэлбэрээр торгох зохицуулалт, мөн албадан ажил хийлгэх, баривчлах зэрэг ялын олон төрлүүдээс сонгох боломжтой байна. Харин төсөөтэй зохицуулалт нь тодорхой ажил, албан тушаал эрхлэх эрхийг хасах шийтгэлийг нэмэгдлээр хорих ялтай хамтад нь оногдуулах явдал юм. Мөн хорих ялыг доод хязгаарыг тогтоогоогүй бөгөөд дээд хязгаар нь 3 жилийн хугацаагаар богинохон байгаа нь ялын бодлого мөн л зөрүүтэй болохыг илэрхийлж байна.

Түүнээс гадна ОХУ-ын Эрүүгийн хуулийн 291 дүгээр зүйлд жижиг хээл хахууль авах гэмт хэргийг:

1. Арван мянган рублиэс хэтрэхгүй хэмжээний хээл хахууль хувь хүн эсвэл зуучлагчаар дамжуулан авсан бол хоёр зуун мянга хүртэл рубль эсхүл ялтны гурван сар хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл нэг жилийн хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг нь хязгаарлах, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ хэргийг энэ хуулийн 290, 291, 291,1-д заасан болон энэ зүйлд заасан гэмт хэргүүдэд ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол нэг сая рубль эсхүл ялтны нэг жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл дөрвөн жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг нь хязгаарлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж хуульчилсан хахууль авах гэмт хэргийг материаллаг бүрэлдэхүүнтэй гэж үзсэн нь онцлог байна.

Өөрөөр хэлбэл, 10.000 рубль нь ойролцоогоор 380.000 орчим төгрөгтэй тэнцэх бөгөөд үүнээс бага хэмжээгээр хахууль авсан үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээхгүй байх боломжийг олгожээ. Мөн эрх чөлөөг нь хязгаарлах ял шийтгэл гэдэг нь манай улсын Эрүүгийн хуульд заасан эрх хязгаарлах

албадлагын арга хэмжээ болон зорчих эрхийг хязгаарлах ялтай агуулгын хувьд адилхан гэж ойлгож болох бөгөөд албадлагын арга хэмжээг ялын төрөл болгож ашиглаж байгаагаараа ялгаатай байна.

Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны хувьд манай улстай адилхан гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш тоолж эхэлж, хэрвээ өнгөрсөн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх зохицуулалттай. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлгийн 78 дугаар зүйлд хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсний улмаас эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх талаар дараах байдлаар хуульчилжээ. Үүнд:

- а/ хөнгөн гэмт хэрэг үйлдсэнээс хойш хоёр жил өнгөрсөн
- б/ хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэнээс хойш зургаан жил өнгөрсөн
- в/ хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван жил өнгөрсөн
- г/ онц ноцтой гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван таван жил өнгөрсөн

Өөрөөр хэлбэл, ОХУ-ын Эрүүгийн хуулийн 3 дугаар бүлгийн 15 дугаар зүйлийн

1 дэх хэсэгт “Энэ хуульд заасан нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэг гэж ангилна”,

2 дахь хэсэгт “Энэ хуульд 3 жилээс дээшгүй хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан санаатай болон болгоомжгүй гэмт хэргийг хөнгөн гэмт хэрэг гэнэ”

3 дахь хэсэгт “ Энэ хуульд таван жилээс дээшгүй хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан санаатай гэмт хэрэг, түүнчлэн арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулах болгоомжгүй гэмт хэргийг хүндэвтэр гэмт хэрэг гэнэ” гэж тус тус зааснаас үзэхэд Эрүүгийн хуулийн 285 дугаар зүйлд заасан эрх мэдлээ урвуулан ашиглах гэмт хэргийг хүндрүүлэх шинжгүй үйлдсэн бол хүндэвтэр гэмт хэргийн ангилалд хамаарах бөгөөд улмаар 6 жил өнгөрсөн, Эрүүгийн хуулийн 290 дүгээр зүйлд заасан хээл хахууль авах гэмт хэрэг хүндрүүлэх шинжгүй бол хувьд хөнгөн гэмт хэргийн ангилалд хамаарч 2 жил өнгөрсөн бол тус тус эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх боломжтой байна.

Ийнхүү Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан нийтийн албан тушаалтан хахууль авах гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа 3 жилийн хугацаагаар урт байгаа нь шударга ёс, эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмыг илүүтэй хангаж байгаа зохицуулалт гэж үзлээ.

### 4.3. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Эрүүгийн хууль<sup>43</sup>

Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)-ын Эрүүгийн хууль нь 1997 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн найруулан хэрэгжиж эхэлсэн бөгөөд ерөнхий дүрэм болон хуваарь дүрэм гэсэн 2 ангиас бүрдэнэ. Албан тушаалын болон хахууль авах гэмт хэргийг “Шамшиж хээл идэж хахууль түлхсэн ял” гэсэн 8 дугаар бүлэгт хуульчилсан байдаг. Тухайлбал,

- 382 дугаар зүйл
- 383 дугаар зүйл.
- 384 дугаар зүйл.
- 385 дугаар зүйл.
- 386 дугаар зүйл.
- 387 дугаар зүйл.
- 388 дугаар зүйл болон 388 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус бий.

Дээрх зүйл ангид гарчиг байхгүй бөгөөд Эрүүгийн хуулийн 382 дугаар зүйлд төрийн албан тушаалтны ямар үйлдлийг гэмт хэрэгт тооцох талаар, харин мөн хуулийн 383 дугаар зүйлд тухайн гэмт хэрэгт ямар ял шийтгэл оногдуулахыг заасан нь хууль зүйн техникийн хувьд бусад орны Эрүүгийн хуулиас онцлог байна.

Тухайлбал, Эрүүгийн хуулийн 382 дугаар зүйлд “Төрийн ажилтан үүрэг тушаалынхаа дөхмийг ашиглан олон нийтийн зоос мөнгө, эд бодисыг эзэмшин авсан, хулгайлан авсан, мэхлэн авсан буюу аргаар хууль бусаар эзлэн авсан байвал шамшсан ялд тооцно” гэсэн бол 383 дугаар зүйлд “Шамшсан ялыг хийсэн байвал үйл байдлынх нь хүнд хөнгөнөөс үндэслэж доор жагсаасан тогтоолуудын ёсоор тус тус шийтгэнэ:

(нэг) хувь хүний шамшсан тоо хэмжээ нь арван түмэн төгрөгөөс дээш байвал арван жилээс дээш хугацаатай хорих буюу хугацаагүй хорихоор шийтгэж, эд хөрөнгийг нь хурааж авахаар нийлүүлэн шийтгэж болно;

(хоёр) хувь хүний шамшсан тоо хэмжээ нь таван түмэн төгрөгөөс дээш арван түмэн төгрөгт хүрэхгүй байвал таван жилээс дээш хугацаатай хорихоор шийтгэж, эд хөрөнгийг нь хурааж авахаар нийлүүлэн шийтгэж болно; үйл байдал нь онцгой хүнд ноцтой байвал хугацаагүй хорихоор шийтгэж, эд хөрөнгийг нь хурааж авахаар нийлүүлэн шийтгэнэ.

(гурав) хувь хүний шамшсан тоо хэмжээ нь таван мянган төгрөгөөс дээш таван түмэн төгрөг хүрэхгүй байвал нэг жилээс дээш долоон жилээс доош хугацаатай хорихоор шийтгэнэ; үйл байдал нь хүнд ноцтой байвал долоон

<sup>43</sup> Доктор Ж.Эрдэнэбулган, Т.Золбоо, М.Уянга, Б.Тамир, Б. Батбаяр нар (2021 он) “Монгол, Орос, Хятад, Германы Улсын Эрүүгийн хууль” орчуулгын бүтээлийн 236-241 тал

жилээс дээш арван жилээс доош хугацаатай хорихоор шийтгэнэ; хувь хүний шамшсан тоо хэмжээ нь таван мянган төгрөгөөс дээш нэг түмэн төгрөгт хүрэхгүй, ял хийснийхээ дараа гэмшин засрах илрэлтэй бөгөөд бузар зоосоо идэвхтэй буцааж тушаасан байвал шийтгэлийг нь хөнгөрүүлэх буюу эрүүгийн шийтгэлээс хэлтрүүлж, түүний байгаа нэгж буюу дээд шатны эрхлэн хамаарах байгууллагаас нь засаг захиргааны шийтгэл өгч болно.

(дөрөв) хувь хүний шамшсан тоо хэмжээ нь таван мянган төгрөгт хүрэхгүй, үйл байдал нь хүнд шиг байвал хоёр жилээс доош хугацаатай хорих буюу хорьж хөдөлмөрлүүлэхээр шийтгэнэ; үйл байдал нь хөнгөн шиг байвал түүний байгаа нэгж буюу дээд шатны эрхлэн хамаарах байгууллагаас байдлыг нь үзэж байгаад засаг захиргааны шийтгэл өгнө.

Олон удаа шамшаад шийдвэрлээгүй байвал олон удаагийн шамшсан тоо хэмжээг нь нийлүүлэн бодож шийтгэнэ” гэжээ.

Дээрх хуулиас үзэхэд энэ нь албан тушаалын гэмт хэрэг байх бөгөөд хугацаатай болон хугацаагүйгээр хорих ял шийтгэж нэмэгдлээр эд хөрөнгийг нь хураах, хорих ангид хөдөлмөрлүүлэх, засаг захиргааны шийтгэл өгөх зэргээр ялын төрлүүдийг хуульчилжээ. Улмаар тухайн ял шийтгэлийг учруулсан хохирлын хэмжээтэй нь уялдуулсан байх бөгөөд жишээ нь монгол мөнгөөр 46 сая орчим төгрөгийн хохирол учруулсан бол 10 жилээс дээш хугацаагаар хорих эсвэл хугацаагүйгээр хорих ба эд хөрөнгийг нь хураан авч болно гэсэн нь бусад орнуудын Эрүүгийн хуулиас хатуу ялын бодлоготой байна гэж ойлгож болно.

Харин хахууль авах гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 385 дугаар зүйлд зааснаар “Төрийн ажилтан үүрэг тушаалынхаа дөхмийг ашиглан бусдын зоос мөнгө, эд бодисыг шулж авсан, эсхүл бусдын зоос мөнгө, эд бодисыг хууль бусаар хүлээн аваад, бусад хүнд ашиг олгосон байвал хээл идсэн ялд тооцно”,

Мөн хуулийн 388 дугаар зүйлд “Төрийн ажилтан өөрийн эрх тушаал буюу байр сууриас болсон дөхөм нөхцөлөө ашиглан төрийн бусад ажилтны үүрэг тушаалын ажиллагаагаар дамжуулж, найдан гуйгчид зүй ёсны бус ашиг тус олгохын тусад найдан гуйгчийн зоос мөнгө, эд бодисыг шулж авсан буюу хүлээж авсан байвал хээл идсэнд тооцож шийтгэнэ” хэмээн хуульчилж, эрүүгийн хариуцлага оногдуулахдаа хээл идсэн тоо хэмжээ, үйл байдалд нь үндэслэж, тус хуулийн 383 дугаар зүйлд заасан ял шийтгэлийг оногдуулахаар зохицуулжээ.

Тодруулбал, эрх мэдлээ урвуулан ашиглах болон хахууль авах гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэл нь ижилхэн байх манай улсын Эрүүгийн хуулиас ялгаатай зохицуулалт болжээ.

Харин БНХАУ-ын Эрүүгийн хуульд хөөн хэлэлцэх хугацааг Дөрөвдүгээр бүлэг. Хүчин бүхий хугацаа"-ны 89 дүгээр зүйлд "Нэхэмжлэн заалдах хугацааг ял хийсэн өдрөөс эхэлж бодно: ялт ажиллагаа нь залгалдсан буюу үргэлжилсэн байдалтай байвал ялт ажиллагааны дууссан өдрөөс эхэлж бодно. Нэхэмжлэн заалдах хугацааны дотор дахиж ял хийсэн байвал өмнөх ялыг нэхэмжлэн заалдах хугацааг хойнох ялыг хийсэн өдрөөс эхэлж бодно" гэсэн нь манай улсын Эрүүгийн хуулийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалттай агуулгын хувьд ижилхэн байна.

Мөн хуулийн 87 дугаар зүйл. Ял хийсэн явдал нь жагсаасан хугацаанаас хэтэрсэн байвал нэхэмжлэн заалдахгүй:

Нэг. Хуульд тогтоосон хамгийн хүнд эрүү шийтгэл нь таван жил хүрэхгүй хугацаатай хорих шийтгэл байхад нэгэнт таван жил өнгөрсөн;

Хоёр. Хуульд тогтоосон хамгийн хүнд эрүү шийтгэл нь таван жилээс дээш арван жил хүрэхгүй хугацаатай хорих шийтгэл байхад нэгэнт арван жил өнгөрсөн;

Гурав. Хуульд тогтоосон хамгийн хүнд эрүү шийтгэл нь арван жилээс дээш хугацаатай хорих шийтгэл байхад нэгэнт арван таван жил өнгөрсөн;

Дөрөв. Хуульд тогтоосон хамгийн хүнд эрүү шийтгэл нь хугацаагүй хорих шийтгэл, алах шийтгэл байхад нэгэнт хорин жил өнгөрсөн. Хэрэв хорин жилийн дараа нэхэмжлэх хэрэгтэй гэж үзвэл эрхбиш Ардын дээд байцаах хороонд мэдүүлж хянан зөвшөөрүүлэх хэрэгтэй гэжээ.

Эндээс үзэхэд эрх мэдлээ урвуулан ашиглах болон хахууль авах гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ нь хорих ялын хугацаанд нөлөөлж байгааг анхаарах нь зүйтэй юм. Жишээ нь БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 382 дугаар зүйлд заасан хохирлын хэмжээг монгол төгрөгөөр хөрвүүлэн үзвэл:

- 46 сая орчим төгрөгийн хохирол учруулсан бол 10 жилээс дээш хугацаатай хорих буюу хугацаагүй хорих ял оногдуулах бөгөөд хөөн хэлэлцэх хугацаа 20 жил байна.
- 23 сая гаран төгрөгийн хохирол учруулсан бол 5 жилээс дээш хугацаатай хорих буюу үйл байдал нь онцгой хүнд ноцтой байвал хугацаагүй хорихоор шийтгүүлэх ба хөөн хэлэлцэх хугацаа 20 жил байна.
- 2.3-23 сая орчим төгрөгийн хохирол учруулсан бол 2 жил хүртэл хугацаатай хорих ял оногдуулах ба хөөн хэлэлцэх хугацаа 5 жил байна.
- 2.3 сая орчим төгрөг хүртэл хохирол учруулсан бол 1-7 жилээс дээш хугацаатай хорих ял оногдуулах ба хөөн хэлэлцэх хугацаа 10 жил байна.

гэж үзвэл эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмыг хангасан, тухайн хүнийг дахин гэмт хэрэг үйлдэх болон бусад иргэдийг энэ төрлийн гэмт хэрэг үйлдэхээс татгалзуулж чадахуйц нөлөө үзүүлэх боломжтой хууль гэж үзлээ.

#### 4.4. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эрүүгийн хууль<sup>44</sup>

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)-ын Эрүүгийн хууль нь 1871 оны 05 дугаар сарын 15-ны өдөр анх батлагдсан бөгөөд хамгийн сүүлд 2021 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр нэмэлт өөрчлөлт орсон. Ерөнхий ба тусгай ангиас бүрдэх ба нийт 30 бүлэг 385 хэсэгтэй. Эрх мэдлээ урвуулан ашиглах бол хахууль авах гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 30 дугаар бүлэг. Албан тушаалын гэмт хэрэг-т хуульчилсан байдаг. Тухайлбал:

- § 331 Давуу байдал бий болгох
- § 332 Хахууль авах

Эрүүгийн хуулийн § 331 Давуу байдал бий болгох гэмт хэргийг:

(1) Төрийн албан хаагч, Европын холбооны албан хаагч эсвэл төрийн тусгай үүрэг бүхий албан хаагч өөрийн үүргийг гүйцэтгэснийхээ төлөө өөртөө болон гуравдагч этгээдэд давуу байдал үүсгэхийг шаардсан, амлалт өгүүлсэн эсвэл ийм амлалтыг хүлээн авсан бол гурван жил хүртэл хугацаагаар хорих эсвэл торгох ял шийтгэнэ.

(2) Шүүгч, Европын холбооны шүүхийн гишүүн эсвэл арбитрч өөртөө болон гуравдагч этгээдэд шүүхийн ажиллагаа явуулсны төлөө эсвэл цаашид ийнхүү явуулахын төлөө хариу төлбөр бүхий давуу байдал үүсгэхийг шаардсан, амлалт өгүүлсэн эсвэл ийм амлалт хүлээн авсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих эсвэл торгох ял шийтгэнэ. Уг гэмт хэргийн завдалтад ял оногдуулна.

(3) Гэмт хэрэгтэн давуу талыг шаардсан, амлалт өгүүлсэн эсвэл ийм амлалтыг хүлээн авсан ба өөрийн бүрэн эрхийн хүрээнд эрх бүхий байгууллагад уг амлалтыг хүлээн зөвшөөрөхөөсөө өмнө эсвэл хүлээн зөвшөөрсөн бол нэн даруй мэдэгдсэн бол түүнийг энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар ял шийтгэхгүй гэж зааснаас үзэхэд манай улсын Эрүүгийн хуулиас ялгаатай шинж нь эс үйлдэхгүйг хуульчлаагүй байдал анзаарагдаж байна.

Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан албан үүрэг, эрхээ зориуд хэрэгжүүлээгүй гэж эс үйлдэхгүй байсан

<sup>44</sup> Доктор Ж.Эрдэнэбулган, Т.Золбоо, М.Уянга, Б.Тамир, Б. Батбаяр нар (2021 он) “Монгол, Орос, Хятад, Германы Улсын Эрүүгийн хууль” орчуулгын бүтээлийн 236-241, 391-393 тал

ч гэмт хэрэгт тооцох боломжтой байдаг шинжийг орхигдуулсан гэж хэлж болно. Мөн эрүүгийн хариуцлагын хувьд хорих ялын доод хязгаарыг тогтоож өгөөгүй, хүндрүүлэх шинжгүй бол 2 жилээр бага хугацаатай байгаа нь ялын бодлогын зөрүүтэй байдлыг илэрхийлж байна. Харин гэмт хэргийн шинжийг амлалт өгүүлсэн, хүлээн авсан гэсэн нь манай улсын Эрүүгийн хуулиас давуу талтай болжээ. Учир нь манай улсын Эрүүгийн хуульд заасан шиг заавал давуу байдал бий болгохыг шаардахгүй амлалт өгүүлэх, амлалт хүлээн авснаар гэмт хэрэг төгсөж байгаа юм.

Харин хахууль авах гэмт хэргийн хувьд ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн § 332 дугаар зүйлд:

(1) Төрийн албан хаагч, Европын холбооны албан хаагч эсвэл төрийн тусгай үүрэг бүхий албан хаагч өөрийн үүргийг гүйцэтгэсний төлөө буюу ирээдүйд ийнхүү гүйцэтгэхийн төлөө өөртөө болон гуравдагч этгээдэд давуу байдал үүсгэхийг шаардсан, амлалт өгүүлсэн эсвэл ийм амлалтыг хүлээн авсны улмаас төрийн албан хаагчийн үүргээ зөрчсөн эсвэл зөрчихөөр байвал зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Хүндэвтэр тохиолдлын хувьд гурван жил хүртэл хугацаагаар хорих эсвэл торгох ял шийтгэнэ. Уг гэмт хэргийн завдалтад ял оногдуулна гэж хуульчилжээ.

Хуулийн дээрх заалт нь хахууль авах гэмт хэргийн шинжийг тодорхойлсон хэдий ч Эрүүгийн хуулийн 331 дүгээр зүйлд заасан давуу байдал бий болгох гэмт хэрэгтэй төстэй агуулгатай байна. Зөвхөн “өөрийн үүргийг ирээдүйд ийнхүү гүйцэтгэхийн төлөө, төрийн албан хаагчийн үүргээ зөрчсөн эсвэл зөрчихөөр байвал” гэсэн шинжүүдээр хоорондоо ялгагдаж байгаа юм. Эрүүгийн хариуцлагын хувьд доод хязгаарыг 6 сар, дээд хязгаарыг 5 жилээр тогтоосон нь манай улсын Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хорих ялын хэмжээнээс доод хязгаар нь 1 жил 6 сар, дээд хязгаар нь 3 жилийн хугацаагаар тус тус бага байна.

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн хөөн хэлэлцэх хугацаа нь мөрдөн шалгах ажиллагаанд, шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагаанд тус тусдаа тоологддог. Тухайлбал, мөрдөн шалгах ажиллагаанд хөөн хэлэлцэх хугацаа тоолох талаар Эрүүгийн хуулийн 5 дугаар бүлэгт “Хөөн хэлэлцэх хугацаа дууссанаар гэмт хэрэгт ял оногдуулахгүй, “Хүний амь насыг хөнөөсөн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй” гэхчлэн зааснаас гадна мөрдөн шалгах ажиллагаанд дараах хөөн хэлэлцэх хугацааг баримталж байна. Үүнд:

- Бүх насаар нь хорих ял оноох гэмт хэргийн хувьд гучин жил
- Арваас дээш жилийн хорих ял оноох гэмт хэргийн хувьд хорин таван жил

- Таваас доошгүй арав хүртэлх жилийн хорих ял оноох гэмт хэргийн хувьд арван жил
- Нэгээс доошгүй тав хүртэлх жилийн хорих ял оноох гэмт хэргийн хувьд таван жил
- Бусад гэмт хэргийн хувьд гурван жил

Дээрхээс зохицуулалтаас үзэхэд давуу байдал бий болгох гэмт хэргийн хувьд хүндрүүлэх шинжгүй бол 5 жил, хажууль авах гэмт хэргийн хувьд мөн 5 жилийн хугацаа өнгөрсөн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх боломжтой байна.

Түүнчлэн, Эрүүгийн хуулийн 786 дугаар зүйлд хөөн хэлэлцэх хугацаа зогсох талаар зохицуулсан байдаг бөгөөд 2 дахь хэсэгт Бундестагийн гишүүн эсвэл мужийн хууль тогтоох байгууллагын гишүүний үйлдсэн гэмт хэргийн талаар өргөдөл гаргасан, прокурор, эрх бүхий байгууллага эсвэл цагдаагийн ажилтан тухайн гэмт хэрэг болон гэмт хэрэгтний тухай мэдсэн, анхан шатны шүүхийн шийдвэр гарсан боловч мөрдөн шалгах боломжгүй байгаа тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг зогсооно гэсэн нь хууль ёсны, шударга ёсны, хууль шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмыг манай улсын Эрүүгийн хуулиас илүүтэй хангасан байна.

#### **4.5. Ял оногдуулах жишиг аргачлалын талаарх зарим улсын туршлага**

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэгт оногдуулах ял нь хэд хэдэн төрөлтэй байхаас гадна хугацаа нь ч гэсэн сонгох боломжтой байдлаар хуульчлагдсан байдаг. Жишээ нь: Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан эр мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэгт 2-5 жил хүртэл хугацаагаар нийтийн албанд ажиллах эрхийг хасаж, 1-5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1-5 жилийн хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж зааснаас үзэхэд 2 төрлийн ялын аль нэгийг 1-5 жилийн хугацаагаар оногдуулах боломжтой байна.

Шүүхээс ял шийтгэл оногдуулахдаа хорихоос өөр төрлийн ялыг хамгийн бага хугацаагаар оногдуулахад олон нийтийн шүүмжлэлийг дагуулах боловч хуулийн хүрээнд заасан ялын төрөл, хэмжээгээр оногдуулж байгаа тул ашиг сонирхлын зөрчилтэй гэж шууд дүгнэх боломжгүй юм.

Энэ байдлаас зайлсхийхийн тулд Прокурорын байгууллагаас 10 орчим төрлийн гэмт хэрэгт ял оногдуулах жишиг аргачлалыг боловсруулан улсын яллагч шүүх хуралдаанд ялын санал гаргахдаа ашиглаж байна. Жишээ нь: Нийслэлийн прокурорын газраас 2021 онд “Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.7 дугаар

зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээний талаар улсын яллагч санал хэлэхэд харгалзах үзүүлэлтийн загвар"-ыг боловсруулсан бөгөөд хар тамхийг бэлтгэсэн, хадгалсан, худалдсан эсэх болон ямар хэмжээтэй байсан эсэх, хэдэн удаагийн үйлдэлтэй эсэх, хар тамхины төрөл буюу сэтгэцэд хүчтэй нөлөөлөх бодис эсэх, урьд нь энэ төрлийн гэмт хэрэгт ял шийтгүүлсэн эсэх, гэмт хэргээ сайн дураараа илчилсэн эсэх зэрэг 10 шалгуур үзүүлэлтээр 8-67 хүртэл оноогоор дүгнэж ял оногдуулах санал гаргаж байна. Тухайлбал, шүүгдэгчийг 8-11 оноогоор дүгнэсэн бол 1-1.3 жил, 67 хүртэл оноогоор дүгнэсэн бол хорих ялын хамгийн дээд хязгаар болох 5 жилийн хугацаагаар хорих ял оногдуулах санал гаргана.

Монгол Улсын шүүх, прокурорын байгууллагад Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйл болон 22.4 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт ял оногдуулах жишиг аргачлал байхгүй одоогоор байхгүй. Харин гадаадын зарим орнуудад ийм аргачлалыг боловсруулан ашиглаж байгаа туршлага бий. Тухайлбал, АНУ, БНСУ, Англи зэрэг улсыг дурдаж болно.

**АНУ<sup>45</sup>.** Бүх төрлийн гэмт хэрэгт ашиглаж болох ял оногдуулах жишиг аргачлалыг 1987 онд Холбооны шүүхээс Холбооны Ялын удирдамжийг баталсан бөгөөд шүүгдэгчийн субъектив гэм буруу болон учруулсан хохирлын хэмжээ эергийг харгалзан үзэж ялыг ялгамжтай оногдуулахаар тусгасан. Жишээ нь:

	Хохирлын хэмжээ	Гэмт хэргийн түвшин нэмэх
(A)	\$5,000 болон түүнээс доош	Түвшин нэмэхгүй
(B)	\$5,000-аас дээш	1 Түвшин нэмэх
(C)	\$20,000-аас дээш	2 Түвшин нэмэх
(D)	\$95,000-аас дээш	3 Түвшин нэмэх
(E)	\$500,000-аас дээш	4 Түвшин нэмэх
(F)	\$1,500,000-аас дээш	5 Түвшин нэмэх
(G)	\$3,000,000-аас дээш	6 Түвшин нэмэх
(H)	\$5,000,000-аас дээш	7 Түвшин нэмэх
(I)	\$9,500,000-аас дээш	8 Түвшин нэмэх

Мөн гэмт хэргийн онцлог, бусад нөхцөл байдлаас хамаарч гэмт хэргийн үндсэн түвшнийг нэмэгдүүлэх болон бууруулах боломжтой. Тухайлбал, албан тушаалаа урвуулан ашигласан бол түвшнийг 2-оор нэмэгдүүлэх бол шүүгдэгч гэм буруугаа хүлээсэн бол гэмт хэрэгтний түвшнийг хоёроор бууруулна. Гэмт хэргийн төрөл тус бүрд үндсэн түвшнийг тогтоодог бөгөөд энэ нь тухайн

<sup>45</sup> АНУ-ын Ялын Комисс (2023 он) Хорих ял оногдуулах аргачлал. Цахим эх сурвалж: <https://www.uscc.gov/guidelines/2023-guidelines-manual/annotated-2023-chapter-5>

нийгмийн аюулын хэр хэмжээг тодорхойлох эхлэлийн цэг болно. Ийнхүү эхлэлийн цэгээ тодорхойлсны дараа дараах хүснэгтээр хорих ялын хугацааг тооцоолно. Үүнд:

**Ял оногдуулах хүснэгт: Урьд ял шийтгэл эдэлж байсан ангилал**

	Гэмт хэргийн түвшин	I (0 or 1) 0-6	II (2 or 3) 0-6	III (4,5,6) 0-6	IV (7,8,9) 0-6	V (10, 11, 12)	VI (15 or more)	
Бүс А	1	0-6	0-6	0-6	0-6	0-6	0-6	
	2	0-6	0-6	0-6	0-6	0-6	1-7	
	3	0-6	0-6	0-6	0-6	2-8	3-9	
	4	0-6	0-6	0-6	2-8	4-10	6-12	
	5	0-6	0-6	1-	4-10	6-12	9-15	
	6	0-6	1.	2-	6-12	9-15	12-18	
	7	0-6	2-	4-10	8-14	12-18	15-21	
	8	0-6	4-	6-12	10-16	15-21	18-24	
	9	4-10	10	8-14	12-18	18-24	21-27	
Бүс В	9	6-12	6-12	10-16	15-21	21-27	24-30	
	1	8-14	8-14	12-18	18-24	24-30	27-33	
Бүс С	12	10-16	12-18	15-21	21-27	27-33	30-37	
	13	12-18	15-21	18-24	24-30	30-37	33-41	
Бүс D	14	15-21	18-24	21-27	27-33	33-41	37-46	
	15	18-24	21-27	24-30	30-37	37-46	41-51	
	16	21-27	24-30	27-33	33-41	41-51	46-57	
	17	24-30	27-33	30-37	37-46	46-57	51-63	
	18	27-33	30-37	33-41	41-51	51-63	57-71	
	19	30-37	33-41	37-46	46-57	57-71	63-78	
	20	33-41	37-46	41-51	51-63	63-78	70-87	
	21	37-46	41-51	46-57	57-71	70-87	77-96	
	22	41-51	46-57	51-63	63-78	77-96	84-105	
	23	46-57	51-63	57-71	70-87	84-105	92-115	
	24	51-63	57-71	63-78	77-96	92-115	100-125	
	25	51-71	63-78	70-87	84-105	100-125	110-137	
	26	63-78	70-87	78-97	92-115	110-137	120-150	
	27	70-87	78-97	87-108	100-125	120-150	130-162	
	28	78-97	87-108	97-121	110-137	130-162	140-175	
	29	87-108	97-121	108-135	121-151	140-175	151-188	
	30	97-121	108-135	121-151	135-168	151-188	168-210	
	31	108-135	121-151	135-168	151-188	168-210	188-235	
	32	121-151	135-168	151-188	168-210	188-235	210-262	
	33	135-168	151-188	168-210	188-235	210-262	235-293	
	34	151-188	168-210	188-235	210-262	262-327	292-365	
	35	168-210	188-235	210-262	235-293	262-327	292-365	
	36	188-235	210-262	235-293	262-327	292-365	324-405	
	37	210-262	235-293	262-327	292-365	324-405	360-life	
	38	235-293	262-327	292-365	324-405	360-life	360-life	
	39	262-327	292-365	324-405	360-life	360-life	360-life	
	40	292-365	324-405	360-life	360-life	360-life	360-life	
	41	324-405	360-life	360-life	360-life	360-life	360-life	
	42	360-life	360-life	360-life	360-life	360-life	360-life	
	43	Бүх насаар	Бүх насаар	Бүх насаар	Бүх насаар	Бүх насаар	Бүх насаар	Бүх насаар

Дээрх хүснэгтээс үзэхэд нийгмийн аюулын хэр хэмжээ А, В, С, D гэх 4 бүсэд нийт 43 түвшинд хувааж, гэмт этгээдийн урьд ял шийтгэгдэж байсан эсэхийг б ангилалд хуваасан байна. Өөрөөр хэлбэл, гэмт этгээдийн урьд ял шийтгэгдэж

байсан эсэх болон гэмт хэргийн нийгмийн аюулын хэр хэмжээг хамтад нь авч үзэж хорих ялын хугацааг тогтооно. Тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын хэр хэмжээ өндөр байх тусам үндсэн түвшин нэмэгдэнэ.

Дээд шүүх энэхүү удирдамжийг зөвхөн зөвлөх буюу санал болгох үүднээс ашиглах ёстой гэж үзсэн бөгөөд хот, тойрог, мужийн шүүхүүд удирдамжийг хэрэглэдэг боловч заавал дагаж мөрдөх шинжгүй байдаг. Гэхдээ шүүгч бүрэн эрхийн хүрээнд удирдамжид зааснаас өөр шийдвэр гаргасан тохиолдолд ямар шалтгаанаар ялыг нэмэгдүүлэх эсвэл бууруулсан болохыг тайлбарлана.

**БНСУ.** Солонгосын ард иргэдийн дунд шүүхээс оногдуулж буй ял хэт хөнгөн байгаа талаар шүүмжлэл өрнөж эхэлсэн бөгөөд 2007 онд иргэдийн дунд явуулсан судалгаагаар 59,2%, харин шүүгч, прокурор, өмгөөлөгч, эрүүгийн эрх зүйн профессор зэрэг хууль зүйн салбарын мэргэжилтнүүд 72.5% нь ял хөнгөн байна гэсэн санал асуулга өгч байжээ. Ингээд ял оногдуулах ажиллагаа тэгш бус буюу тогтворгүй байгаа талаар дүгнэлт хийж, олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх зорилгоор эрүүгийн эрх зүйн системд реформ хийж эхэлсэн бөгөөд анх удаа Ялын комиссыг байгуулсан байна.

Энэхүү комисс нь Дээд шүүхийн дэргэд 13 гишүүнтэй, бүрэн эрхийн хугацаа 2 жил бөгөөд дахин томилж болдог. Дээд шүүхийн ерөнхий шүүгч дараах шаардлагын аль нэгийг хангасан хүнийг комиссын тэргүүнээр томилно:

- Шүүгч, прокурор, өмгөөлөгчөөр 15-аас доошгүй жил ажилласан;
- Төр, орон нутгийн засаг захиргааны байгууллага, үндэсний буюу нийтийн үйлдвэр, нийтийн ипституц болон бусад байгууллагад 15-аас доошгүй жил хуулийн чиглэлээр ажилласан;
- Магадлан итгэмжлэгдсэн их сургуульд дэд профессор эсхүл түүнээс дээд цолтойгоор хууль зүйн хичээлийг 15-аас доошгүй жил заасан.

Харин Дээд шүүхийн ерөнхий шүүгч нь дараах тооны хүмүүсийг комиссын гишүүдээр томилно. Үүнд:

- Шүүгч 4;
- Хууль зүйн сайдын санал болгосноор прокурор 2;
- Солонгосын хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн санал болгосноор өмгөөлөгч 2;
- Хуулийн профессор 2;
- Өргөн мэдлэг, туршлага бүхий мэргэжилтэн 2,

Комиссын үйл ажиллагааг дэмжих, үр дүнтэй байлгах зорилгоор хууль зүйн салбарын мэргэжилтнүүдээс бүрдсэн 14 гишүүнтэй мэргэжилтнүүдийн зөвлөл, нийгмийн олон талт төлөөллийг хангах зорилгоор өөр өөр салбарын мэргэжилтнүүдээс бүрдсэн 12 гишүүнтэй зөвлөх бүлэг ажилладаг.

Тус улсад ялын удирдамжийг шинээр батлах, батлагдсан удирдамжид засвар оруулахдаа Мэргэжилтнүүдийн зөвлөлөөс судалгаа болон хэлэлцүүлгийн үр дүнд тулгуурлан удирдамжийн төслийг боловсруулж Ялын комисст танилцуулна, Ялын комисс төслийг хянаад ялын удирдамжийн санал боловсруулна. Олон нийтээр төслийг хэлэлцүүлж санал авах, холбогдох институтуудээс саналыг цуглуулснаар комисс ялын удирдамжийн эцсийн хувилбарыг тогтоол гаргаж батална. Гэхдээ хэрэг тус бүр дээр аргачлал гаргах боломжгүй тул ойролцоо төрлийн гэмт хэргүүдийг бүлэглэн нэгтгэж удирдамж боловсруулдаг байна<sup>46</sup>.

Жишээ нь: Авлигын гэмт хэрэгт ял оногдуулах жишиг аргачлалыг 2009 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр баталж мөн оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд Эрүүгийн хуулийн 129 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 131 дүгээр зүйлийн 1, 2, 3, 133 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг ашиглаж байна. Аргачлалын онцлогоос дурдвал хохирлын хэмжээг гол шалгуур болгосон бөгөөд идэвхтэй үүрэг оролцоо, шүүгдэгч нь төрийн алба хаагч эсэх, зөвхөн амлалт өгснөөр дууссан, гэм буруугаа чин сэтгэлээсээ хүлээж гэмшиж байгаа байдал, давтан үйлдсэн гэх зэрэг шалгуур үзүүлэлтээр дүгнэх юм.

БНСУ-ын Дээд шүүхээс 2007 онд Ялын хороо байгуулж, уг хорооноос 2009 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр баталсан “Авлигын гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн удирдамж”-ийг хавсаргав.

**Англи.** Тус улсад ардчиллын зарчмыг хангах, мөн шүүгч нар сонгуулийн бус замаар томилогддог, улс төрийн хүрээнээс ангид байдаг боловч ялын бодлогод ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ял оногдуулах жишиг загварыг боловсруулах Ялын зөвлөлийг 2003 онд байгуулсан байна. Ялын зөвлөл нь нийт 14 гишүүнтэй. Их Британийн ерөнхий шүүгч зөвлөлийн тэргүүний байна. Нийт гишүүдээс шүүгч 8 гишүүнийг ерөнхий шүүгч Их Британийн Дээд канцлэртэй зөвшилцсөний үндсэн дээр; шүүгч бус 6 гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтаар Дээд канцлер болон Ерөнхий шүүгчтэй зөвшилцсөний үндсэн дээр томилно. Шүүгч гишүүнээр Давж заалдах шатны шүүхийн шүүгч, Дээд шүүхийн шүүгч, Тойргийн шүүхийн шүүгч, Дүүргийн шүүхийн шүүгч, эсхүл Тангарагтны шүүгчийг томилж болно. Зөвлөлийн шүүгч гишүүдэд дор хаяж нэг тойргийн шүүгч, нэг дүүргийн шүүгч, нэг тангарагтны

<sup>46</sup> Б.Батаа нар (2021 он) “Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээний тайлан”-гаас авав.

шүүгч байна. Харин шүүгч бус гишүүдийг Дээд канцлер дараахаас албан тушаалтан дундаас сонгоно. Үүнд:

- Өмгөөлөгч;
- Прокурор;
- Цагдаа;
- Ялын бодлого болон хууль зүйн бодлогын захиргааны ажилтан;
- Гэмт хэргийн хохирогч хамгааллын байгууллагын төлөөлөл;
- Эрүүгийн эрх зүй болон криминологийн чиглэлээр судалгааны ажил эрхэлдэг судлаач;
- Статистикч;
- Шүүгдэгчийг дахин нийгэмшүүлэх байгууллагын төлөөлөл зэрэг болно.

Шүүгч ял оногдуулахдаа холбогдох удирдамжийг дагаж мөрдөх үүрэгтэй боловч тодорхой тохиолдолд шударга ёсонд нийцэхгүй гэж үзвэл шүүгч удирдамжийг баримтлахгүй байх эрхтэй бөгөөд үндэслэлээ тайлбарлах ёстой.

## Дэд хэсгийн дүгнэлт

**- Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлд заасан эрх мэдэл, албан тушаалын байдлаар урвуулан ашиглах гэмт хэрэгтэй харьцуулбал:**

1. Дээрх гэмт хэргийг БНСУ-ын Эрүүгийн хуулийн 122 дугаар зүйл, Албаны үүргээ биелүүлэхгүй байх, 123 дугаар зүйл. Эрх мэдлээ урвуулан ашиглах, ОХУ-ын Эрүүгийн хуулийн 285 дугаар зүйл. Эрх мэдлээ урвуулан ашиглах, БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 382, 383 дугаар зүйл, ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн § 331 дугаар зүйл. Давуу байдал бий болгох гэсэн зүйл анги нь ижил агуулгатай байна.
2. Дээрх төрлийн гэмт хэрэгт БНСУ-ын Эрүүгийн хуульд хорих ялын хувьд доод хязгаарыг зааж өгөөгүй, дээд хязгаарыг 5 жил гэсэн нь манай улсын Эрүүгийн хуульд заасан хэмжээтэй ижилхэн хугацаатай байна. Харин эрх хасах ялыг ялын нэг төрөл болгож дангаар нь хэрэглэдгээрээ ялгаатай.

ОХУ-ын Эрүүгийн хуульд хорих ялын доод хязгаарыг заагаагүй, дээд хязгаар нь 4 жилийн хугацаагаар заасан нь манай улсын Эрүүгийн хуульд зааснаас богино байна.

БНХАУ-ын Эрүүгийн хуульд хорих ялын доод хязгаарыг 10 жил, улмаар бүх насаар нь хорих ял оногдуулж болохоор заасан нь бусад орнуудаас хамгийн хатуу ял шийтгэл юм.

ХБНГУ-ын Эрүүгийн хуульд хорих ялын доод хязгаарыг тогтоож өгөөгүй, хүндрүүлэх шинжгүй бол 3 хүртэл жилийн хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан нь бусад орнуудаас хамгийн бага хугацаа байна.

3. БНСУ-ын Эрүүгийн хуульд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр албаны үүргээ биелүүлэхгүй байх, биелүүлэхээс татгалзсан, эрх мэдлээ урвуулан ашиглан бусдаар хийх ёсгүй үүргийг гүйцэтгүүлсэн, эдлэх ёстой эрхээ хэрэгжүүлэхэд нь саад учруулснаар, ХБНГУ-ын Эрүүгийн хуульд амлалт өгүүлэх, амлалт хүлээн авснаар тус тус гэмт хэрэг төгсөж байна. Харин БНХАУ-ын Эрүүгийн хуульд заавал ч үгүй хохирол учирсан байхыг шаардана.

**- Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлд заасан хахууль авах гэмт хэрэгтэй харьцуулбал:**

1. Дээрх гэмт хэргийг БНСУ-ын Эрүүгийн хуулийн 129 дүгээр зүйл. Хээл хахууль авах болон авах талаар мэдэгдэх, 130 дугаар зүйл. Гуравдагч хүнд хахууль өгөх, 131-р зүйл. Хахууль авсны дараа амлалтаа зөрчих, нэмж авах, 132 дугаар зүйл. Сайн албан тушаалтан хахууль авах, ОХУ-ын Эрүүгийн хуулийн 290 дүгээр зүйл. Хээл хахууль авах, 291 дүгээр зүйл. Жижиг хээл хахууль авах, БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 385-388 дугаар зүйл, ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн § 332 Хахууль авах гэсэн зүйл анги нь ижил агуулгатай байна.

2. БНСУ-ын Эрүүгийн хуульд хорих, эрх хасах гэсэн 2 төрлийн ялын төрөлтэй, улмаар тус тусад нь оногдуулахаар, хуульчилсан ба хорих ялын доод хэмжээг заагаагүй, дээд хэмжээг 5 жил, эрх хасах ялын дээд хэмжээ нь 10 жил байгаа нь ялын бодлогын хувьд манай улсаас бага байна.

ОХУ-ын Эрүүгийн хуульд торгох ял болон тухайн ялтны ямар ажил хийж байгаа түүний цалингийн орлогоор торгох гэсэн 2 төрлийн хэлбэрээр торгох зохицуулалт, мөн албадан ажил хийлгэх, баривчлах зэрэг ялын олон төрлүүдээс сонгох боломжтой байна. Гэхдээ хорих ялыг доод хязгаарыг тогтоогоогүй бөгөөд дээд хязгаар нь манай улсаас 3 жилийн хугацаагаар богинохон байна.

БНХАУ-ын Эрүүгийн хуулийн эрх мэдлээ урвуулан ашиглах болон хахууль авах гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэл нь ижилхэн байна.

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн хорих ялын доод хязгаарыг 6 сар, дээд хязгаарыг 5 жилээр тогтоосон нь манай улсынхаас бага юм.

**- Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлд заасан эрх мэдэл, албан тушаалын байдлаар урвуулан ашиглах гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг харьцуулбал:**

1. БНСУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 249 дүгээр зүйлд хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг дуусгавар болсноос хойш тоолж эхэлдэг. Харин тус улсын Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлд шүүхийн шийдвэрийг биелүүлэх хугацааны хөөн хэлэлцэх хугацааг зохицуулсан байдаг.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлгийн 78 дугаар зүйлд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш тоолж эхэлж, хэрвээ өнгөрсөн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх зохицуулалттай. Тодруулбал, эрх мэдлээ урвуулан ашиглах гэмт хэргийг хүндрүүлэх шинжгүй үйлдсэн бол хүндэвтэр гэмт хэргийн ангилалд хамаарах бөгөөд 6 жил өнгөрсөн бол, хээл хахууль авах гэмт хэрэг хүндрүүлэх шинжгүй бол хувьд хөнгөн гэмт хэргийн ангилалд хамаарч 2 жил өнгөрсөн бол тус тус эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх боломжтой байна.

БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 87 дугаар зүйл зааснаар 23-46 сая орчим төгрөгийн хохирол учруулсан бол 20 жил, 2.3-23 сая орчим төгрөгийн хохирол учруулсан бол 5 жил, 2.3 сая орчим төгрөг хүртэл хохирол учруулсан бол 10 жил тус тус хөөн хэлэлцэх хугацааг тоолно.

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн давуу байдал бий болгох гэмт хэргийн хувьд хүндрүүлэх шинжгүй бол 5 жил, хахууль авах гэмт хэргийн хувьд мөн 5 жилийн хугацаа өнгөрсөн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх боломжтой байна.

Харин Эрүүгийн хуулийн 78б дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Бундестагийн гишүүн эсвэл мужийн хууль тогтоох байгууллагын гишүүний үйлдсэн гэмт хэргийн талаар өргөдөл гаргасан, прокурор, эрх бүхий байгууллага эсвэл цагдаагийн ажилтан тухайн гэмт хэрэг болон гэмт хэрэгтний тухай мэдсэн, анхан шатны шүүхийн шийдвэр гарсан боловч мөрдөн шалгах боломжгүй байгаа тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг зогсооно гэсэн нь бусад орнуудаас илүү нарийвчилсан сайн зохицуулалт юм.

***- Ял оногдуулах жишиг аргачлалын талаар зарим улсыг харьцуулбал:***

АНУ, БНСУ, Англи зэрэг улсыг судлан үзэхэд манай улсад зарим төрлийн гэмт хэрэгт ял оногдуулахдаа улсын яллагчийн саналын жишиг загварыг боловсруулан хэрэгжүүлж байгаа туршлагыг шүүхийн практикт нэвтрүүлэн хэрэглэж байна. Ялангуяа, БНСУ-ын хувьд "Авлигын гэмт хэрэг оногдуулах ялын жишиг загвар"-ыг боловсруулсан нь шүүх, хуулийн байгууллагад итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, шүүхээс ял оногдуулах, улсын яллагчаас ялын санал гаргахад ашиг сонирхлын зөрчилгүй байлгах, ардчилсан шударга ёсны зарчмыг хангах зэрэг олон төрлийн ач холбогдолтой байдаг нь тогтоогдлоо.

### **Иймд**

1. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн шинжээс “бусдад давуу байдал бий болгосон” гэсэн хэсгийг хасаж “нийтийн албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаар урвуулан ашигласан, зориуд хэрэгжүүлээгүй” улмаас гэмт хэрэг төгсдөг болгох;
2. Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйл болон 22.4 дүгээр зүйлд ял оногдуулах жишиг аргачлалыг боловсруулан, практикт нэвтрүүлэх;

## СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮГНЭЛТ, САНАЛ

**Нэг.** Авлига нь улс орон бүрд түүхийн аль ч үед байж түүнийг сүүдэр мэт дагах улс, нийгэмд ноцтой аюул учруулахуйц сөрөг үзэгдэл болох нь тодорхой байна.

Манай улсын түүхэнд авлигын асуудал байсан, өнөөдөр ч бодит байдал болон хувирч, хамгийн их сэтгэл түгшээж буй ноцтой асуудлын нэг хэвээр байх бөгөөд авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн бодлого, хууль эрх зүйн зохицуулалтын хувьд ч түүхэн уламжлалтай ажээ. Нийгмийн түүхэн цаг үе, хөгжлийн түвшин, түүний хувирлыг даган гэмт хэргийн мөн чанар, тэмцэх бодлого, хэрэгжилт хувьсан өөрчлөгдөх зарим зүй тогтлын дагуу ялын бодлогын хувьд уламжлалыг зарим талаар хадгалахын зэрэгцээ шинэчлэгдэж, боловсронгуй болсоор ирсэн байна.

Чингис хаан “Хамаг улсын хулгайг гэсгээн шийтгэж, худлыг мохоон дуусгаж, үхүүлэх ёстой гэмтнийг цаазлан үхүүл. Алдаж шийтгүүлэх ёстой гэмтнийг яллан шийтгэ”, “Засах засаглахуйн дээд Их засагийг ургийн урагт хүртэл хэн ч бүү өөрчилтүгэй” гэж зарлиг буулгасан, мөн засаг, зарлигуудыг багтааж байсны хувьд Их засаг хэмээх хууль бол тодорхой төрлийн үйлдлүүд, үүний дотор хахууль, албан тушаалаа урвуулах, хэтрүүлэх үйлдлийг гэмт хэрэг хэмээн тодорхойлж, зохих хатуу ял шийтгэл хүлээлгэхээр тогтоож байсан нь түүхэн эх сурвалжтай байхаас гадна Чингис хааны тогтоосон хууль цааз буюу зарлигийг Монголын нэгдсэн улсад төдийгүй түүний залгамжлагчид, үр ач нарынх нь толгойлсон улсуудад мөрдөж байсан нь бахархалт түүх, баялаг уламжлал гэж үзэхээр байна.

Мөн Их хаан, түүний залгамжлагч нарын үлдээсэн, эдүгээчлэн төрийн бодлогод тусган хуульчилбал зохих бодлого зохицуулалтын хувьд:

Албан тушаалтны сахилга, хариуцлагыг хууль цаазын хүрээнд чангатгаж, ерөнхий зарчмын хүрээнд бүх хэргийг нарийвчлан ангилж, “том хэрэг” буюу албан тушаалын хэрэг хийсэн бол хэд дахин илүү ял оноох бодлогыг тусгайлан боловсруулж хэрэгжүүлсэн байна.

“Гучин жил өнгөрсөн бол хэрэг заргыг авч хэлэлцэхгүй, хэрэгсэхгүй болгох буюу хэрэг заргын хөөн хэлэлцэх хугацааг 30 жилээр тогтоон мөрдүүлсэн нь ач холбогдлоо одоо ч алдаагүй оновчтой, уламжлалт бөгөөд шинэлэг бодлого, зохицуулалт байжээ. Тус бодлого, зохицуулалт нь эдүгээ ардчилсан олон улс орны хувьд түгээмэл хандлага болчихсон, харин манай улсад улс төржүүлэн хий үзэгдэл болгосоор ужгирч бугшуулсан “нууц биш нууц асуудал” болох авлига, албан тушаалын гэмт хэргийн эсрэг бодлого, зохицуулалтын зарим хийдэл, ялангуяа тус хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зэрэг асуудлыг шийдвэрлэхэд хамгийн оновчтой чиглэл, гарц болох нь эргэлзээгүй байна.

Хуулийн хамгийн зөв заалтыг баримтлан баримт(шийдвэр)-ыг нэг загвараар бичих, шүүгч баримтыг 1 загвараар бичихэд хуулийн бүх заалт, торгуулийг агуулсан загварууд бүхий эрдэмтдийн зохист номлолын эмхэтгэлийг харгалздаг, хэрэв шүүгч шинэ бичиг шийтгэх буюу өөрөөр шийдсэн бол заавал дахин хянуулж байхаар тогтоосон бодлого, зохицуулалт үйлчилж байсан байх ба энэ нь хууль журмын болон ял, шийтгэлийн зорилгыг алдагдуулахгүй байхад чиглэгдсэн, эдүгээчлэн төрийн бодлогод харгалзах зайлшгүй шаардлагатай уламжлалт бодлогод хамаарч байна.

**Хоёр.** Манай улсын хувьд аюулгүй байдал бүх түвшиндээ хүнд бэрх, ороо бусгаа цаг дор 1926 онд анх удаа Эрүүгийн төрөлжсөн хуулийг баталж, улмаар авлига, албан тушаалын гэж үзэх гэмт хэргүүд, түүнд оногдуулах ял шийтгэлийг хуульчилсан нь хамгийн чухал, ач холбогдолтой бодлого гэж үзэхээр байна.

Тус цаг үеэс хойш эдүгээ хүртэлх хугацаанд олон удаа Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулж баталсан, нэмэлт, өөрчлөлтүүд оруулсан, 1992 оноос өмнөх ба хойших Эрүүгийн хуульд зарчмын шинжтэй ялгаа зааг байгаа боловч уламжлал, шинэчлэлийг хослуулах замаар эдүгээ хүртэл боловсронгуй болсоор ирсэн байна. Тухайн Эрүүгийн хуулиуд нь тухайн үйлчилж байсан цаг хугацааныхаа нийгэм, улс төрийн болон эрх зүйн хөгжлийн нөхцөл байдал, онцлогт тулгуурлан албан тушаалын гэмт хэрэг, түүнд оногдуулах төрийн ял шийтгэлийн бодлогыг тодорхойлж ирсний зэрэгцээ, тэдгээрийг зөв оновчтой тодорхойлж хуульчлах гэсэн багагүй хичээл зүтгэл, үзэл санаа бүгдийг өөртөө агуулсаар ирсэн түүхэн ач холбогдлыг үгүйсгэх боломжгүй.

Зөвлөлтийн үеийн, намч, ангич, хувьсгалч шинж чанартай гэж шүүмжлэхээс илүүтэйгээр 1992 оноос өмнөх үеийн Эрүүгийн хууль дахь авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн бодлого нь тодорхой цаг хугацааны давтамжтайгаар өөрчлөгдөж улам бүр чанга хатуу болсон нь тухайн гэмт хэргийн аюул ноцтой гэсэн үзэл санаа, хандлага, цогц бодлого үйлчилж, тухайн хэргийн нийгмийн аюулын шинжийг бодитой үнэлж байсныг илэрхийлж байна. Тухайлбал, Шүүх цаазын бичгүүдэд зааснаар:

- Албан тушаалаа урвуулах эсхүл хэтрүүлсэн бол 6 сараас 5 жил, хүндрүүлэх шинжтэй бол 2 жилээс дээш хугацаагаар хорих,
- Албан хүн хахуулийг авахаар зөвлөлдсөн буюу завдсан, авсан бол 1-5 жил, хэрэв хяхах аргаар авсан бол 3-10 жил хүртэл, дээд албаны хүмүүс үйлдвэл 5-10 жил хорих, эд хөрөнгө хураах,
- Улсын ба ард түмний хөрөнгөөр байгуулсан газруудын тэргүүлэгчид, орлогчид, төлөөний хүн аж үйлдвэрийг муугаар явуулсан бол 3 сараас 3 жил хорих, хэрэв ашгийг хичээж үйлдсэн бол 3-8 жил хорих,
- “Аливаа албан тушаалтан албаны буюу тушаасан ёсоор аливаа хэрэг явдлыг гүйцэтгэж буй этгээд өөрийн эрхлэн хадгалбаас зохих мөнгө, зоос зэрэг аливаа үнэ бүхий зүйлүүд буюу хөрөнгө хогшлыг хувьд ашиглах зэргээр сүйтгэвээс 5 жил хүртэл хорих болон дээрх гэмт хэргийг үйлдсэн албан тушаалтан онц эрх бүхий этгээд болох буюу улсын онц үнэ бүхий чухал зүйлийг тийнхүү ашиглах зэргээр сүйтгэвээс 2 жилээс доош бус хорьж хөрөнгийг албан хураах, хэрэв улсын эдийн засагт хорт санаагаар ашигласан, үрэгдүүлсэн зэрэг онц хүндэтгэх учир шалтгаан буй аваас буудан алах ялтай байв.

Тухайлбал, 1942, 1961, 1986 оны Эрүүгийн хуульд зааснаар:

- Албан тушаалаа урвуулах буюу ашгийг хичээн засгийн эрх, албан тушаалын байдлыг урвуулсан бол 3-аас 10 жил хүртэл хорих,
- Засгийн буюу албан тушаалын эрхийг хэтрүүлэн хэрэглэхдээ бусдыг хүчирхэн дарлах, хохирсон хүний биеийг зовоох, нэр хүндийг доромжилбол 3 жилээс доошгүй хугацаагаар хорих, хүндэтгэх шалтгаан байвал буудан алах,
- Хахууль авсан, хүндрүүлэх шинжтэй бол 3-15 жил хорих гэх зэрэг болно.

Гэтэл Монгол Улсын 1992 оны шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлал, агуулгад нийцүүлж 2002 онд Эрүүгийн хуулийг шинэчлэн батлахдаа авлига, албан тушаалын эсрэг зарим гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн бодлогыг эрс зөөлрүүлсэн буюу хөнгөрүүлж, тогтоож байсан нь анхаарал татаж байна. Тухайлбал, 2002 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд: Албан тушаалын байдлаа урвуулах болон хэтрүүлэх гэмт хэрэгт хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-50 дахин нэмэгдүүлж торгох, эсхүл 1-3 сар хүртэл баривчлах, хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51-100 дахин нэмэгдүүлж торгох, эсхүл 5 жил хүртэл хорих буюу 2 дахин бага байна.

Харин 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн хувьд авлигын зарим гэмт хэрэг оногдуулах ял шийтгэл, төрөл, хэмжээ зэрэгт ял шийтгэлийн

бодлого зарим талаар сул, анхаарах асуудлууд цөөнгүй байжээ. Гэхдээ авлига, албан тушаалын гэмт хэргийн аюул, гаралтын түвшин, тухайн төрлийн гэмт хэрэгт оногдуулсан ял шийтгэл, олон түмний болон судлаачдын шүүмжлэл, бусад орны туршлага зэргийг харгалзан зохих нэмэлт, өөрчлөлтүүдийг хийсэн бөгөөд хамгийн сүүлчийн буюу 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн төрөл, хэмжээг зохистой гэж үзэж болох түвшинд тогтоосон гэж үзэж болохоор байна.

Авлига, албан тушаалын гэмт хэрэг бол хууль тогтоомжоор хамгаалсан нийгмийн ашиг сонирхлыг зөрчиж, хохирол, хор уршиг учруулахаас гадна төрийн албанд хууль дээдлэх, шударга ёсыг хангах, нийтийн ашиг сонирхлыг хамгаалж ажиллах зарчмыг ноцтой зөрчиж, төрд итгэх олон нийтийн итгэлийг алдагдуулж, төрийн байгууллын үнэлэмжийг сулруулах ноцтой үр дагавартай учраас түүнтэй ял шийтгэлийн оновчтой, зөв бодлого баримтлан тэмцэх, урьдчилсан сэргийлэх ажиллагаа зохих ёсоор хийгдэж байна.

Онол, практикийн ач холбогдол бүхий судалгаа, шинжилгээнд тулгуурлах замаар авлигын гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх явдлын үр өгөөжийг нэмэгдүүлэх, түүний хэрэгжилтийг хангах үндсийг ямагт боловсронгуй болгож байх нь зайлшгүй чухал билээ.

**Гурав.** Авлига, албан тушаалын гэмт хэргийн илрүүлэлт, шүүхээр хянан шийдвэрлэгдэж байгаа хэргийн тоо, хохирлын хэмжээ нь жил тутам өсөн нэмэгдсэн байх ба харин эсрэгээр авлигын гэмт хэрэгт оногдуулсан эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээ нь эрүүгийн хариуцлагын зорилго, шударга ёсны зарчим, тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээнд бүрэн нийцдэггүй гэх олон нийтийн шүүмжлэл, зарим судалгааны дүн, судлаачдын байр суурийг үгүйсгэх боломжгүй байна. Тухайлбал:

Зөвхөн 2017-2023 онд шүүхээс хянан шийдвэрлэсэн судалгаагаар: нийт хэргийн 47.9 хувь буюу 117 хэргийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.4 дүгээр зүйлд зааснаар, 31.1 хувь буюу 76 хэргийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлд заасан, харин нийлмэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хахууль авах гэмт хэргийг нэгэн зэрэг үйлдсэн бусад хэргийг тус тус эцэслэн шийдвэрлэсэн байх ба ял шийтгэлийн хувьд нийт хэргийн:

- 77 хувь буюу 188 хэрэгт анхан шатны шүүхээс торгох ял оногдуулсан байна. Улсын яллагч 62.9 хувь буюу 151 хэрэгт торгох ялыг шүүгдэгчид оногдуулахаар санал гаргасан, шүүхээс улсын яллагчийн ялын саналаас илүү гаргаж ял өгсөн тохиолдол бараг байхгүй,
- 3.7 хувь буюу 9 хэргийг хэрэгсэхгүй болгож, шүүгдэгч нарыг цагаатгаж, 0.8

хувь буюу 2 хэргийн шүүгдэгчийг ялаас чөлөөлсөн,

- 15 хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан, гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр тус тус хэрэгсэхгүй болгосон,
- 7.7 хувь буюу 7 хэрэгт шүүх хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх арга хэмжээг авсан,
- 32.4 хувь буюу 79 хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн. Үүнээс үзэхэд 3 хэрэг тутмын 1-ийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлсэн,
- Албан тушаалаа урвуулах 9 хэрэгт прокуророос хорих ялын санал гаргахад 2 хэрэгт, хахууль авах 44 хэрэгт прокуророос хорих ялын санал гаргахад 15 хэрэгт хорих ялыг тус тус шүүхээс ялын төрөл болон хэмжээг тус тус бууруулан оногдуулсан, хорих ялын хэмжээний хувьд прокуророос 4 жилээс дээш хэмжээний хорих ялыг оногдуулахаар санал гаргахад шүүх хүлээн аваагүй буюу ямагт бага хорих ял оногдуулсан зэрэг тоо баримтаас үзэхэд авлига, албан тушаалын гэмт хэрэгт ял шийтгэл оногдуулахад улсын яллагч буюу прокурор мөн шүүхийн хувьд анхаарах асуудал байгаа нь илэрхий тодорхой байна.

Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн гэмт буруутай этгээдэд эрүүгийн хариуцлагын зорилго, тус зорилгыг хангахад чиглэгдсэн үндэслэл, журам, шалгуур шаардлага буюу Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.3 дугаар зүйлийн 1, 2, 5.1 дүгээр зүйлийн 1, 6.1 дүгээр зүйлийн 1, 2-т зааснаар тухайн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэм буруугийн хэлбэр, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, нийгмийн аюулын буюу учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хэр хэмжээ, түүний хувийн байдал, эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдал зэргийг нотолж буй үйл баримтыг бүх талаас нь харьцуулан шалгаж, хууль ёсны ба үндэслэл бүхий байдлаар бүрэн дүгнэлт хийхгүйгээр хэлбэрийн төдий байдлаар буюу ихэвчлэн хялбаршуулсан журмаар шийдвэрлэх, хамгийн хөнгөн ял шийтгэлийг оногдуулахаар санал гаргах улмаар шүүхээр тухайн саналыг баталгаажуулах байдлаар авлига, албан тушаалын гэмт хэргийн ял шийтгэлийн бодлого хэрэгжиж буй нь шийдэл шаардсан тулгамдсан асуудалд хамаарч байна.

Угтаа Эрүүгийн хуульдаа ял шийтгэлийн зорилго, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял шийтгэл оногдуулахад баримтлах үндэслэл, журам, шалгуурыг тодорхой заасан тул тэдгээр үндэслэл, журам, шалгуур шаардлагыг бүрэн дүгнэх замаар ял шийтгэлийн талаар тохирсон саналыг талууд гаргах, улмаар дээрх үндэслэл, журам, талуудын саналыг бүхэлд нь харьцуулан дүгнэсний эцэст тохирсон ял шийтгэл оногдуулах нь шүүхийн үүрэгт хамаарна.

Гэтэл дээрх судалгаанд хамрагдсан шүүхийн шийдвэрийн 80 орчим хувьд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл, журам, шалгуур шаардлагын талаар үндэслэл бүхий дүгнэлт хийгдээгүй байна.

**Дөрөв.** Авлигын гэмт явдал нь аль нэг улс, үндэсний хүрээнээс хальж, бүх улс, эдийн засагт нөлөөлөхүйц үндэстэн дамнасан олон улсын үзэгдэл болж, улмаас нийгмийн тогтвортой байдал болон аюулгүй байдалд үүсэж буй бэрхшээл, аюул занал нь ардчилсан тогтолцоо, үнэт зүйлс, түүнчлэн ёс зүйн үнэт зүйлс, шударга ёсыг сулруулж, тогтвортой хөгжил, хууль дээдлэх ёсонд хохирол учруулж байгааг олон улс орнууд хүлээн зөвшөөрч, улмаар ялын бодлого, зохицуулалтаа уялдуулах, боловсронгуй болгох байдлаар тухайн гэмт хэрэгтэй тэмцэж байна.

Авлигын гэмт хэрэгт оногдуулж буй ялын төрөл, хэмжээ улс орон бүрд адилгүй байх боловч харьцангуй хатуу чанга бодлого баримталж, улмаар тухайн гэмт хэрэгт ялын төрөл, хэмжээг оногдуулахдаа Эрүүгийн хариуцлагын зорилго, эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд мөрдөх зарчим, бусад хүчин зүйлсийг зөрчиж буюу дийлэнхдээ хэт хөнгөн ял шийтгэл оногдуулах, ялгамж үүсгэх зэргээр ялын бодлогыг алдагдуулах явдал гаргуулахгүйн тулд “Ял оногдуулах жишиг аргачлал”-ыг боловсруулж, мөрдүүлж байна.

## САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Дүгнэлтийн хүрээнд дараах зарим саналыг дэвшүүлж, тодотгож байна.

**1)** Авлига, албан тушаалын гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг 30 жилээр, авлигын гэмт хэргийг улс төрийн нөлөө бүхий этгээд үйлдсэн бол хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй байх зохицуулалтыг цаг алдалгүй хуульчлах;

“30 жил өнгөрсөн бол хэрэг заргыг авч хэлэлцэхгүй, хэрэгсэхгүй болгох буюу хэрэг заргын хөөн хэлэлцэх хугацааг 30 жилээр тогтоон мөрдүүлсэн” түүхэн уламжлалт бодлого, зохицуулалт бол ач холбогдлоо одоо ч алдаагүй гэж үзэж байна. Тус бодлого, зохицуулалт нь эдүгээ ардчилсан олон улс орны хувьд түгээмэл хандлага болчихсон, харин манай улсад улс төржүүлэн хий үзэгдэл болгосоор ужгирч бугшуулсан “нууц биш нууц асуудал” болох авлига, албан тушаалын гэмт хэргийн эсрэг бодлого, зохицуулалтын зарим хийдэл, ялангуяа тус хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зэрэг асуудлыг шийдвэрлэхэд хамгийн зөв, оновчтой чиглэл, гарц болох нь эргэлзээгүй байна.

Улс төрийн хүрээний буюу өндөр түвшний авлига нь улс орны аюулгүй байдалд ноцтой аюул учруулахад хүргэдэг учраас улс төрийн нөлөө бүхий этгээдүүдийн үйлдсэн авлигын гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тоолохгүй байх нь хууль, зарчим, үндэсний эрх ашиг, олон түмний хүсэл зоригт зүй ёсоор нийцнэ.

**2)** Авлига, албан тушаалын зарим хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй гэмт хэрэгт оногдуулах хорих ялын интервалын доод хэмжээг нэмэгдүүлж, энгийн болон хүндрүүлэх бүрэлдэхүүн бүхий гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээ өөр хоорондоо ялгамжтай байхуйцаар өөрчлөх;

Тухайлбал, 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт оногдуулах хорих ял 1 жилээс 5 жил, 22.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт оногдуулах хорих ял 2 жилээс 8 жил, 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт оногдуулах хорих ял 5 жилээс 12 жил хүртэл хугацаагаар хорих ял байхаар зохицуулсныг:

22.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт оногдуулах хорих ял 3 жилээс 8 жил, 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт оногдуулах хорих ял 6 жилээс 12 жил хүртэл хугацаагаар хорих болгон өөрчлөх нь ялын бодлого алдагдуулахгүй байхад тодорхой хэмжээгээр нөлөөлнө.

**3)** Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхийг хориглохдоо “Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг” гэж явцуу хүрээнд заасан байх тул авлигын ихэнх гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхийг аль болох хориглох;

Энэ хүрээнд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 2, 22.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхийг хориглохоор нэмж хуульчлах шаардлагатай.

**4)** Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.4 дүгээр зүйл дэх “Энэ бүлэгт заасан “их хэмжээний хахууль” гэдэгт нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгоно” гэсэн хуульчилсан тайлбарыг хүчингүй болгох;

Учир нь тус хуульчилсан тайлбар нь:

- “Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 4.1-“их хэмжээний хохирол” гэж тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг” ойлгох заалтыг зөрчсөн буюу нийцэхгүй, мөн
- хууль, шүүхийн өмнө тэгш байх зарчмыг ноцтой зөрчсөн, тухайлбал, бусдын орон байранд нэвтэрч 1000 төгрөг хулгайлсан иргэн, 100.000.000 төгрөгийн хахууль авсан албан тушаалтан хоёрын үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулыг “адилтгах” нь хууль, зарчимд нийцэхгүйгээс гадна,
- нийтийн албан тушаалтны авсан хахуулийн хэмжээ 100 сая төгрөгөөс доош, эсхүл дээш байгаагаар мөн ялган заагласан нь авлигын гэмт хэргийн ялын бодлогод сөрөг нөлөөлтэй гэж үзэх үндэслэл бүрдсэн байна.

**5)** Авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулж буй ял шийтгэлийн бодлогыг алдагдуулахгүй байх эхний арга зам бол Улсын Дээд шүүхээс хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, тайлбар, зөвлөмж гаргах;

Анхан болон давж заалдах шатны зарим шүүхээс “авлига, албан тушаалын гэмт хэрэгт ял шийтгэл оногдуулахдаа ихэвчлэн хөнгөн төрлийн ял шийтгэх, төсөөтэй нөхцөл байдал үйлдсэн ижил гэмт хэрэгт өөр өөр ял оногдуулах, ялгаатай нөхцөл байдалд үйлдсэн өөр гэмт хэргүүдэд ижил ял шийтгэх зэргээр зөрүүтэй байдлаар шийдвэрлэдэг бөгөөд тийнхүү шийдвэрлэхдээ Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлагын зорилго, эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд

баримтлах зарчим, үндэслэл, журам, шалгуур шаардлагын талаар хууль ёсны ба үндэслэл бүхий байдлаар бүрэн гүйцэд дүгнэлт хийдэггүй алдаа, зөрчлүүд нийтлэг байна.

Тийм учраас, Улсын Дээд шүүх хамгийн их үйлдэгддэг гэмт хэрэг, ялангуяа улс, нийгэмд ноцтой аюул учруулдаг хор уршигтай авлига, албан тушаалын болон бусад зарим гэмт хэрэгт ял шийтгэл оногдуулахад Эрүүгийн хуулийг зөв хэрэглэх буюу хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах хүрээнд тайлбар, зөвлөмж гаргах боломжтой гэж үзэж байна. Тодруулбал, тухайн гэмт хэрэгт ял шийтгэл оногдуулахад баримтлах зарчим, үндэслэл, шалгуур шаардлага бүхий аливаа асуудлыг нэг бүрийг хамаарах эрх зүйн онолынх нь суурь зорилго, утга агуулга, үзэл санааных нь үүднээс тайлбарлах, шүүхүүд хэрэгт авагдсан үйл баримтын хүрээнд тухайн нэг гэмт хэрэгт ямар шийтгэл оногдуулах талаарх үндэслэл, шалгуур шаардлагыг нэг бүрчлэн дүгнэх, улмаар ялыг зөв, зохистойгоор тохируулж оногдуулаагүй нь хуулийн нэгдмэл хэрэглээний алдаа, зөрчилд хамаарах болохыг заах зэргээр тайлбар, зөвлөмж гаргах нь чухал алхам болно гэж үзэж байна.

Мөн Улсын Дээд шүүх хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах, хуулийг Улсын Дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн, шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой гэж үзсэн тохиолдолд зөвхөн давж заалдах шатны шүүхийн магадлалыг хянан хэлэлцэж, эцсийн шийдвэр гаргадаг. Энэ хүрээнд “ял шийтгэл оногдуулахад хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах” боломжтой.

Өөрөөр хэлбэл, “авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулсан ял шийтгэл нь тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, ял шийтгэл оногдуулах зарчим, шалгуур шаардлага зэрэгт нийцээгүй үндэслэлийг бүхэлд нь дүгнэж, улмаар анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож буюу хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад чиглэгдсэн шийдвэр гаргасан тухайн тохиолдолд доод шатны шүүхүүдийн гаргаж буй ял шийтгэлийн бодлогыг алдагдуулсан аливаа алдаа, зөрчлийг багасгах, тогтоон барихад нөлөөлнө гэж үзэж байна.

**6)** Улсын Дээд шүүхээс “Эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээний дотор ял оногдуулах жишиг аргачлал”-ыг баталж хэрэгжүүлэх хүрээнд хамгийн түрээнд авлигын гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн жишиг аргачлалыг баталж хэрэгжүүлэхэд онцгойлон анхаарах.

Их хааны хууль, зарлигийг уламжилж, мөрдсөн Хасан хааны зарлигийн дагуу эрдэмтэн, судлаач, шүүгч нар хамтран зөвхөн торгууль агуулсан хуулийн

бүх заалт, оногдуулж болох интервалийн хүрээнд торгуулийн олон хувилбар бүхий баримтын (шийдвэрийн) загварууд, түүнд хамаарах зохист номлолыг туурвиж, улмаар эмхэтгэн шүүгч нарт гарын авлага болгож байсан нь анхаарал татахуйц байна.

Монгол Улсын Их хурлын 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 34 дугаар тогтоолоор “2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга)-тай холбогдуулан эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээний дотор ял оногдуулах жишиг аргачлалыг баталж хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Улсын Дээд шүүхэд зөвлөсөн” байдаг. Гэхдээ тухайн эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээний дотор ял оногдуулах жишиг аргачлалыг баталж, мөрдүүлэх нь олон талын цогц судалгаа, зарим гадаад улсын сайн туршлагууд, хамаарах эрх зүйн бүлийн онцлогийг харгалзах, зарим талаар математик загварчлал боловсруулж, турших зэрэг эцэслэн шийдвэрлэхэд олон талын хүндрэл бэрхшээлтэй, маргаан дагуулах асуудлуудтай тулгарах нь тухайн төрлийн аргачлалыг боловсруулж хэрэгжүүлсэн болон тус аргачлалыг үл хүлээн зөвшөөрдөг улс орны зарим туршлага, түүхүүд илэрхийлж буйг тэмдэглэж байна.

Тухайлбал, АНУ-ын Конгресс “Ялын зохих төлөөлөл бүхий комисс”-ыг байгуулж, ялын жишиг аргачлал боловсруулах үүрэг хүлээлгэсэн, улмаар “Холбооны ял шийтгэлийн жишиг аргачлал”-ыг баталсан байх бөгөөд гэм буруу, хамтран оролцогчийн үүрэг оролцоо, гэмт үйлдлийн арга, учруулсан хохирлын хэмжээ, нийгмийн аюулын шинж чанар, урьд ял шийтгүүлсэн байдал зэргийг харгалзан 4 бүсчлэл (бүлэг) бүхий 43 түвшинд гэмт хэргүүдийг байршуулан оногдуулах ялын зохист хэмжээг тогтоосон бол, харин БНСУ улсын хувьд Дээд шүүхийн дэргэдэх “Ялын зохих төлөөлөл бүхий комисс”-оос эрүүгийн хариуцлагын зорилго, холбогдох зарим зарчмуудын хүрээнд төсөөтэй гэмт хэргүүдийг бүлэглэж, дотор нь нийгмийн аюул, сэдэлт, зорилго, хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдал болон бусад хүчин зүйлсээр зэрэглэлд оруулах байдлаар зарим төрлийн гэмт хэрэгт оногдуулах хорих ба торгох ял шийтгэлийн жишиг аргачлалыг тогтоосон, түүнчлэн тэдгээр аргачлалыг боловсруулахад өргөн бүрэлдэхүүн, олон талт судалгаа, шинжилгээ хийгддэг, хуульчдын дунд хуулиуд ба хууль хэрэглэх онол, зарчимд нийцэх эсэхээр ихээхэн маргаан дагуулдаг байхаас гадна хууль зүйн хүчин чадлын хувьд заавал мөрдөх шинжгүй боловч өөрөөр ял оногдуулсан тохиолдол бүрд үндэслэл, шалтгаанаа заавал дүгнэсэн байхыг шаарддаг байна.

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

### А. Хууль тогтоомж

1. Шүүх цаазын бичиг (1926, 1929, 1934 он)
2. Эрүүгийн хууль (1942, 1961, 1986, 2002, 2015 он)
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

### Б. Ном, сэтгүүл, судалгааны тайлан

1. Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх. УБ., 1996 он
2. Д.Лүндээжанцан. Монголын төр эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 1997 он
3. Д.Адъяабазар. Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. УБ., 1998 он
4. С.Бадарч. Их Монгол улсын шүүхийн уламжлал. УБ., 1998 он
5. Герхард Даннекер. ХБНГУ дахь эрүүгийн ба эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн сургалт-эрүүгийн эрх зүй (эргэцүүлэл). УБ., 1998 он
6. Н.Жанцан. Криминологи. УБ., 2000 он
7. С.Нарангэрэл. Монгол Улс дахь олон улсын шинжтэй гэмт хэрэг түүний цаашдын чиг хандлага. УБ., 2000 он
8. И.Дашням. Монгол Улсын төр, эрх зүйн түүх. УБ., 2005 он
9. Ц.Нацагдорж. Чингис хааны зарлигийн товчоон. УБ., 2006 он
10. Б.Баярсайхан. Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. УБ., 2011 он
11. П.Амаржаргал. Парламентын бүрэн эрх: төлөвшил, хөгжлийн чиг хандлага. УБ., 2016 он
12. Майкл Жонстон. Авлигын синдром. УБ., 2021 он
13. Г.Аким. Шашдирын чуулган (гутгаар дэвтэр). УБ., 2020 он
14. Томас Т.Алсен. Монгол империализм (орч). УБ., 2020 он
15. Ж.Болдбаатар. Монголын нууц товчоо (дэлгэрэнгүй тайлбартай). УБ., 2024 он
16. Х.Хади, Баратов. Коррупцийн гэмт үйлдлийг нууцаар мөрдөж мөшгих албаны үүрэг.

17. Фан Чонги. Коррупцийн хэргийг нууцаар мөрдөн шалгах ба илрүүлэх ажиллагаа, нотолгоо болох үр дүн.
18. Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн бодлогын баримт бичиг
19. Lack's law dictionary. Sixth ed. 1990
20. Economic perspective электрон сэтгүүл. 1998 он
21. Доктор Ж.Эрдэнэбулган, Т.Золбоо, М.Уянга, Б.Тамир, Б. Батбаяр нар (2021 он) “Монгол, Орос, Хятад, Германы Улсын Эрүүгийн хууль” орчуулгын бүтээлийн 236-241, 236-241, 391-393 тал
22. Б.Батаа нар (2021 он) “Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээний тайлан”-гаас авав.
23. Г.Ганбаатар. Хуулийн засаглал, шударга ёсны эрэлд (нийтлэлийн эмхэтгэл) 2016 он
24. Г.Ганбаатар. Авлигалтай тэмцэх эрүүгийн эрх зүйн асуудал: хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан судалгааны ажил, УБ., 2002 он
25. Г.Ганбаатар. “Хасан хааны зарлиг ил болгон иргэн дор хүрвээс бишрэхтүн, мэдэхтүн” нийтлэл. Монголын төр, эрх зүй, 2021, № 1

## **В. Цахим эх сурвалж:**

1. Legalinfo.mn
2. БНСУ-ын Эрүүгийн хууль (1998 он) цахим эх сурвалж: <https://www.refworld.org/legal/legislation/natlegbod/1953/en/37944>
3. БНСУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2009 он) цахим эх сурвалж: [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?lang=ENG&hseq=22535](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?lang=ENG&hseq=22535)
4. “Тодорхой төрлийн гэмт хэрэгт илүү хүнд ял шийтгэл оногдуулах тухай хууль (1966 он) цахим эх сурвалж: [https://elaw.klri.re.kr/eng\\_mobile/viewer.do?hseq=45379&type=part&key=9](https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=45379&type=part&key=9)
5. АНУ-ын Ялын Комисс (2023 он) Хорих ял оногдуулах аргачлал. Цахим эх сурвалж: <https://www.uscc.gov/guidelines/2023-guidelines-manual/annotated-2023-chapter-5>

## ХАВСРАЛТ

БНСУ-ын Дээд шүүхээс 2007 онд Ялын хороо байгуулж, уг хорооноос 2009 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр баталсан “Авлигын гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн удирдамж”-ийг хавсаргав.

### АВЛИГЫН ГЭМТ ХЭРЭГ

Авлигын гэмт хэрэгт ял оноох хэм хэмжээ нь авлига (Эрүүгийн хуулийн 129 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг), урьдчилан авсан авлига (Эрүүгийн хуулийн 129 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг), авлига авсны дараа хууль бус үйлдэл гаргасан (Эрүүгийн хуулийн 131 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг), хууль бус үйлдлийн дараа авлига авсан (Эрүүгийн хуулийн 131 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг), Хүндрүүлсэн байдлын авлига (тусгай үнийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг), хээл хахууль өгөх (Эрүүгийн хуулийн 133 дугаар зүйлийн 1 дэх хэсэг), гуравдагч этгээдэд хээл хахууль өгөх (Эрүүгийн хууль) гэх мэт эдгээр гэм буруу үйлдсэн насанд хүрсэн этгээдэд (19 наснаас дээш) үйлчилнэ.

#### 1. ГЭМТ ХЭРГИЙН АНГИЛАЛ БОЛОН ЯЛЫН ХЭМЖЭЭ

Авлига авсан тохиолдол

Төрөл	Ангилал	Хөнгөрүүлсэн байдал	Ялын хэмжээ	Хүндрүүлсэн байдал
1	10 саяас доош	- 6 сар	4сар – 1жил	8 сар – 2 жил
2	10 саяас дээш, 30 саяас доош	8 сар – 2 жил	1 жил – 3 жил	2 жил – 4 жил
3	30 саяас дээш, 50 саяас доош	2 жил 6 сар – 4 жил	3 жил – 5 жил	4 жил – 6 жил
4	50 саяас дээш 100 саяас доош	3 жил 6 сар – 6 жил	5 жил – 7 жил	6 жил – 8 жил
5	100 саяас дээш 500 саяас доош	5 жил – 8 жил	7 жил – 10 жил	9 жил – 12 жил
6	500 саяас дээш	7 жил – 10 жил	9 жил – 12 жил	11 жилээс дээш, бүх насаар

Ангилал		Хөнгөрүүлэх нөхцөл байдал	Хүндрүүлэх нөхцөл байдал
Тусгай ял оноох хүчин зүйлс	Үйлдэл	- Оролцсон байдал бага, ашиг бага байсан тохиолдолд - Төрийн албан хаагч болон арбитрч бол - Зөвхөн амлалтаар дууссан үед	- Холбогдох хууль бус харилцаа үүсгэсэн - Авлига авахыг шаардсан - Авлига авахыг зөвшөөрсөн
	Үйлдэл хийсэн этгээд	- Сонсголгүй хүн - Авсан авлигыг буцаан өгсөн хүн - Оюун санаа, бие махбод сул дорой байх үед	- Давтан гэмт хэрэг
Нийтлэг үйлчлэх хүчин зүйлс	Үйлдэл	- Оролцсон байдал бага, ашиг бага байсан тохиолдолд - Тусгай хуулийн 4-т хамаарах төрийн албан тушаалтан	- 2 жилээс дээш хугацаагаар авсан зүйл - Ажилтай холбоотой байсан бол,
	Үйлдэл хийсэн этгээд	- Чин сэтгэлээсээ харамсаж байгаа тохиолдолд - Өмнө эрүүгийн ял шийтгэл эдэлж байгаагүй	- 3 зэргээс дээш албан тушаалтан - Өмнө авлигатай төстэй үйлдэл хийж байсан

## 2. Авлига өгсөн тохиолдол

Төрөл	Ангилал	Хөнгөрүүлсэн байдал	Ялын хэмжээ	Хүндрүүлсэн байдал
1	30 саяас доош	- 6 сар	10 сар – 1 жил 6 сар	1 жил – 3 жил
2	30 саяас дээш, 50 саяас доош	1 жил – 2 жил	10 сар – 1 жил 6 сар	1 жил – 3 жил
3	50 саяас дээш, 100 саяас доош	1 жил – 2 жил	1 жил 6 сар – 2 жил 6 сар	2 жил – 4 жил
4	100 саяас дээш	2 жил – 3 жил	5 жил – 7 жил	3 жил – 5 жил

Ангилал		Хөнгөрүүлэх нөхцөл байдал	Хүндрүүлэх нөхцөл байдал
Тусгай ял оноох хүчин зүйлс	Үйлдэл	- Төрийн албан хаагч болон арбитрч бол - Идэвхтэй үйлдэл - Зөвхөн амлалтаар дууссан үед	- Холбогдох хууль бус харилцаа үүсгэсэн - Авлига авахыг шаардсан - Авлига авахыг зөвшөөрсөн
	Үйлдэл хийсэн этгээд	- Сонсголгүй хүн - Авсан авлигыг буцаан өгсөн хүн - Дотоод нууцыг задруулсан эсвэл мэдээлсэн	- Давтан гэмт хэрэг

Нийтлэг үйлчлэх хүчин зүйлс	Үйлдэл	- Оролцоо бага - Дамжуулсан - Тусгай хуулийн 4-т хамаарах төрийн албан тушаалтан	- Ажилтай холбоотой
	Үйлдэл хийсэн этгээд	- Чин сэтгэлээсээ харамсаж байгаа тохиолдолд - Өмнө эрүүгийн ял шийтгэл эдэлж байгаагүй	- Өмнө авлигатай төстэй үйлдэл хийж байсан

### **(Нэр томъёоны тодорхойлолт)**

#### **1. Авлига авсан тохиолдолд**

##### А. Төрөл 1

- Хээл хахуулийн хэмжээ 10 сая вон хүрэхгүй тохиолдолд хамаарна.
- Дээрх хэмжээ нь авсан, шаардсан, амласан тохиолдлыг хэлнэ.(цаашид адил)

##### В. Төрөл 2

- Хээл хахуулийн хэмжээ 10 сая воноос дээш, 30 сая воноос доош тохиолдолд хамаарна.

##### Г. Төрөл 3

- Хээл хахуулийн хэмжээ 30 сая воноос дээш, 50 сая воноос доош тохиолдолд хамаарна.

##### Д. Төрөл 4

- Хээл хахуулийн хэмжээ 50 сая воноос дээш, 100 сая воноос доош тохиолдолд хамаарна.

##### Е. Төрөл 5

- Хээл хахуулийн хэмжээ 100 сая воноос дээш, 500 сая воноос доош тохиолдолд хамаарна.

##### Ё. Төрөл 6

- Хээл хахуулийн хэмжээ 500 сая воноос дээш тохиолдолд хамаарна.

#### **2. Авлига өгсөн тохиолдол**

##### А. Төрөл 1

- Хээл хахуулийн хэмжээ 30 сая вон хүрэхгүй тохиолдолд хамаарна.
- Дээрх хэмжээ нь өгсөн, өгөхөөр амласан, өгөх тухай хүсэл эрмэлзлээ илэрхийлсэн (цаашид адил)

## Б. Төрөл 2

- Хээл хахуулийн хэмжээ 30 сая воноос дээш, 50 сая воноос доош тохиолдолд хамаарна.

## В. Төрөл 3

- Хээл хахуулийн хэмжээ 50 сая воноос дээш, 100 сая воноос доош тохиолдолд хамаарна.

## Г. Төрөл 4

- Хээл хахуулийн хэмжээ 100 сая воноос доош тохиолдолд хамаарна.

**Шийдвэр гаргах хүчин зүйлсийн тодорхойлолт**

## 1. Авлига авсан тохиолдолд

## А. Хээл хахуультай авсны дараа хууль бус үйлдэл гаргах

- Хээл хахууль авсны дараа хууль бус үйлдэл болон хууль бусад хамаарах зүйл хийсэн тохиолдолд хамаарна.

## Б. Шаардсан тохиолдолд

- Дараах зүйлийн аль нэг зүйлд хамаарсан ойлголтыг хэлнэ.
- Тухайн хээл хахууль авахыг илт шаардсан тохиолдолд
- Хээл хахууль өгөөгүй тохиолдолд тус этгээдийн ажлын болон гэр бүлд дарамт учруулах, эрх мэдлийг ашиглаж хохирол учруулах тухай хандлага үзүүлсэн тохиолдолд
- Бусад ижил төсөөтэй тохиолдол

## В. Мөрдөн шалгах ажиллагаа эхлэхээс өмнө буцаан өгөх

- Мөрдөн шалгах байгууллага шалгахаас өмнө өөрийн санаачилгаар буцаан өгсөн тохиолдлыг хэлнэ.
- Гэвч, буцаан өгсний дараа нуун дарагдуулахаар завдсан тохиолдлыг авч үзэхгүй.

## Г. Дотоод мэдэгдэл

- Тус гэмт хэрэгт хамт оролцож байсан этгээд гэмт хэргийг таслан зогсоох зорилготой, өөрийн санаачилгаар, мэдээллэснээр мөрдөн шалгах ажиллагаа эхэлсэн тохиолдолд хэлнэ.

## Д. Ажлын хамаарал өндөр байх тохиолдолд

- Албан тушаалтай хамааралгүйгээр тухайн ажилд шийдвэр гаргах бүрэн эрхтэй байхыг ойлгоно.

## 2. Авлига өгсөн тохиолдол

### А. Хүлээн авагчийн хүсэлтийн дагуу хүлээн зөвшөөрсөн тохиолдол

- Хүлээн авагчийн шаардсан хүсэлтийн дагуу өгсөн тохиолдлыг хамааруулна.

### Б. Идэвхтэй хүсэлт

- Хүлээн авагчид авлига өгч албан тушаалын талаарх идэвхтэй байдлаар хүсэлт болон шаардсан тохиолдлыг хамааруулна.
- Авлига өгөөгүй тохиолдолд тухайн этгээдийн ажлын эрх мэдэл болон түүнээс хамааран гэр бүлийн хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх талаар мэдэгдсэн тохиолдолд
- Бусад

### В. Мөрдөн шалгах ажиллагааны өмнөх буцаан өгсөн тохиолдол

- Мөрдөн шалгах байгууллага, мөрдөн шалгах ажиллагааны өмнөх шатанд өөрийн хүслээр буцаан өгсөн тохиолдол
- Гэвч авлига буцаан өгсөний дараа нуун далдлах зорилготой байсан бол хамаарахгүй

### Г. Дотоод мэдэгдэл

- Тус гэмт хэрэгт хамт оролцож байсан этгээд гэмт хэргийг таслан зогсоох зорилготой, өөрийн санаачлагаар, мэдээллэснээр мөрдөн шалгах ажиллагаа эхэлсэн тохиолдолд хэлнэ.

### Д. Ажлын хамаарал өндөр байх тохиолдолд

- Албан тушаалын байр суурьтай холбоогүйгээр тухайн ажилд шийдвэр гаргах бүрэн эрхтэй хүнд авлига өгөх тохиолдлыг хэлнэ.

### Е. Чин сэтгэлээсээ харамсаж байгаа тохиолдол

- Гэм бурууг хүлээн зөвшөөрсний дараа дэлгэрэнгүй байдал, хохирлыг сэргээх, сэргээхийн тулд өөрийн хүслээр хичээж байгаа байдлыг шалгаж, дүгнэсэний эцэгт өөрийн гэм бурууг хүлээн зөвшөөрсөн тохиолдлыг хэлнэ.

### Ё. Эрүүгийн ял шийтгэл шийтгүүлж байгаагүй

- Гэмт этгээд тухайн гэмт хэрэг үйлдэхээс өмнө нэг ч удаа байхгүй байгаа тохиолдлыг хэлнэ. Гэхдээ удаан хугацааны турш, давтамжтайгаар үйлдсэн тохиолдолд үйлчлэхгүй.

**Шийдвэр гаргах зарчим**

1. Ялын хэмжээг тодорхойлох арга
  - Шийтгэлийн ялын тусгай хүчин зүйлийг харгалзан тогтооно.
  - Гэхдээ ялын олон онцгой хүчин зүйл байгаа тохиолдолд дараах зарчмуудыг баримтална.
    - (I) Ижил тооны үйл ажиллагааны хүчин зүйлүүд нь ижил тооны оролцогч (бусад хүчин зүйлсээс илүү чухалчилдаг
    - (II) Ижил тооны үйл ажиллагааны хүчин зүйлсийн хооронд эсвэл оролцогчид/бусад хүчин зүйлсийн хооронд тэнцүү гэж үздэг.
    - (III) Дээрх 1 ба 2-р зарчмын дагуу шийтгэлийн хүрээг тогтоогоогүй тохиолдолд, шүүгч дээрх 1, 2-р зарчмуудыг үндэслэн ялын тусгай хүчин зүйлүүдийг хэрэглэж харьцуулсан үнэлгээгээр ялын хэмжээнд өөрчлөлт орох эсэхийг тогтоодог.
  - Ял хүндрүүлэх хүчин зүйл их байвал хүндрүүлэх, бусад тохиолдолд хүндрүүлэх ялын хязгаар тогтоох гэх зэргээр хөнгөрүүлэх хүчин зүйлс их байх тохиолдолд ялын хэмжээг бусад тохиолдолд ерөнхий байдлаар ялын хүрээг тогтоодог.
2. Ял шийтгэлийг шийдвэр гаргах арга
  - Дээрх 1-р зүйлд заасан ялын хүрээн дэх ялын ерөнхий хүчин зүйлийн хамааралтайгаар тус зүйлийг цогц байдлаар үзэж шийдвэр гаргана.
  - Шийтгэх зааврын дагуу ялын дээд хязгаар 25 жилээс хэтэрсэн тохиолдолд бүх насаар нь хорих ял оногдуулж болдог.

**Ерөнхий зарчим**

1. Шийтгэх удирдамжийн дагуу санал болгож буй өгүүлбэрийн хязгаарыг тусгайлан тохируулах,
  - (I) Ял оногдуулах тусгай хүчин зүйлийг үнэлсний үр дүнд хүндрүүлэх хэсэгт орсон тохиолдолд, Хэрэв хоёр ба түүнээс дээш онцгой хүндрүүлэх хүчин зүйл байгаа, эсхүл хоёр ба түүнээс дээш онцгой хүндрүүлэх хүчин зүйл байвал ял оногдуулах зааварт заасан ялын дээд хязгаарыг 1/2 хүртэл нэмэгдүүлнэ.
  - (II) Ял шийтгэх тусгай хүчин зүйлүүдийг үнэлсний дүнд хөнгөрүүлэх хэсэгт хамаарах хэрэгт хоёр ба түүнээс дээш онцгой хүчин зүйл байгаа, эсхүл хүндрүүлэх гэмт хэрэг үйлдсэнээс хоёр ба түүнээс дээш онцгой хүчин зүйл байвал ялын доод хязгаарыг тогтооно. шийтгэлийн удирдамжид санал болгосон ялын хязгаарыг 1/2-оор багасгана.

2. Шийтгэх зааварт санал болгож буй ялын хүрээ болон хуулийн шийтгэлийн хүрээ хоорондын хамаарал
  - Хэрэв шийтгэлийн зааварт санал болгож буй ялын хэмжээ нь хүндрүүлэх/хөнгөрүүлэх хуулийн заалттай зөрчилдөж байвал хуулийн шийтгэлийн дээд буюу доод хязгаарыг хэрэглэнэ.
3. Хууль дэх түр зуурын буюу хөнгөрүүлэх шалтгааныг шийдвэрлэх арга
  - Шүүгч ял оногдуулах удирдамжийн ялын хүчин зүйлийн хүснэгтэд тусгагдсан үндэслэлээр дур мэдэн бууруулсан хууль зүйн үндэслэлээр ялыг бууруулахгүй гэж хуульд заасан үндэслэлээр шийдвэрлэсэн бол түүнийг өөрийн үзэмжээр бууруулах үндэслэлд тооцно.

### **Олон хүнтэй гэмт хэргийг шийдвэрлэх стандарт**

1. Хэрэглэх хүрээ
  - Эрүүгийн хуулийн 37 дугаар зүйл нь ял оногдуулах хэм хэмжээ тогтоосон гэмт хэргүүдийн хооронд хавсарсан гэмт хэрэгт хамаарна. Харин Эрүүгийн хуулийн 37 дугаар зүйлийн эхний хагаст заасан ялын хэмжээ тогтоогдсон гэмт хэрэг болон ялын хэмжээ тогтоогдоогүй гэмт хэргийн хооронд гэмт хэрэг үйлдэгдсэн тохиолдолд доод хязгаарыг ялын доод хязгаартай тохирно. ял оногдуулах стандартыг тогтоосон гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээний дагуу байна.
2. Үндсэн гэмт хэргийг тогтоох
  - Суурь гэмт хэрэг гэдэгт ялын төрлийг сонгон хуулийн дагуу хүндрүүлэх/хөнгөрүүлэх арга хэмжээ авсан гэмт хэргийг хэлнэ. Харин дээрх гэмт хэрэгт ял оногдуулах зааврын дээд хязгаар нь хавсарч үйлдсэн гэмт хэрэгт ял оногдуулах зааврын дээд хязгаараас доогуур байвал хоорондоо өрсөлдөж байгаа гэмт хэргийг үндсэн гэмт хэрэгт тооцно.
3. Ижил төрлийн гэмт хэргийг шийдвэрлэх
  - Дараах шийдвэрлэх арга зүйг хамааруулна.
    - (I) Авсан, шаардсан, амласан авлига болон амлалт хийсэн, өгсөн, өгөхөөр хариу үйлдэл үзүүлсэн тэмдэглэгээ хийсэн авлигыг нэмсэн үнээр тодорхойлогддог ба эдгээр төрлүүдийн дотроос бүх нөхцөл байдлыг харгалзан зохих гэж үзсэн төрлийг тодорхойлно.

(II) Харин нийлбэр дүнгээр тухайн төрөл нь хүнд гэмт хэргээс нэг шатаар ахисан тохиолдолд ялагдвал ялын доод хязгаарын  $1/3$ -аар, төрөл нь онц хүнд дан гэмт хэргээс хоёр ба түүнээс дээш шатлалтай бол ялын доод шатны  $1/2$ -оор хөнгөлнө. ялын хязгаар, харин онц хүнд гэмт хэрэгт хэрэглэх ялыг ялын доод хязгаараас  $1/2$ -оор бууруулах бөгөөд, хамгийн чухал ганцхан хуулийн хүрээнд байна.

#### 4. Нэг төрлийн гэмт хэргийг хэрхэн шийдвэрлэх

- Нэг төрлийн гэмт хэргийн хувьд ял оногдуулах удирдамжийн дагуу нэг гэмт хэрэг гэж үзэхээс бусад тохиолдолд дор дурдсан олон гэмт хэргийг хүндрүүлэх аргыг хэрэглэнэ.

(I) Олон төрлийн хоёр гэмт хэргийн хувьд үндсэн гэмт хэрэгт оногдуулах ялын дээд хязгаар өөр байхаас гадна гэмт хэрэгт оногдуулах ялын дээд хязгаарын  $1/2$ -ыг нэмснээр ялын хэмжээг тогтооно.

(II) Гурав ба түүнээс дээш олон төрлийн гэмт хэргийн хувьд үндсэн гэмт хэрэгт оногдуулах ялын дээд хязгаарыг бусад гэмт хэргээс хамгийн өндөр ялтай гэмт хэргийн дээд хязгаарын  $1/2$ , бусад гэмт хэргээс  $1/3$ -аар нэмэгдүүлнэ. хоёр дахь хамгийн өндөр гэмт хэрэгт оногдуулах ялын дээд хязгаарыг тогтоодог.

(III) Бусад гэмт хэрэгт оногдуулах ялын доод хязгаар нь үндсэн гэмт хэрэгт оногдуулах ялын доод хязгаараас өндөр байна. Энэхүү тохиолдолд олон гэмт хэрэг үйлдсэний үр дүнд ялын доод хязгаар нь байна.

- Харин үүнтэй төстэй хээл хахуулийн гэмт хэрэгт холбогдсон бол авлигатай холбоотой гэмт хэрэг болон түүнтэй адилтгах гэмт хэрэгт эмчлэх аргыг хэрэглэж тооцсон ялын хязгаарт үндэслэн дээрх олон төрлийн гэмт хэрэгт хүндрүүлэх аргыг хэрэглэнэ.

## 2. ТЭНСЭН ҮЗЭХ ШАЛГУУР

### 1. Авлига авсан тохиолдолд

Ангилал	Сөрөг	Эерэг
Гол шалгуур шалтгаан	<ul style="list-style-type: none"> <li>- Идэвхтэй шаардсан</li> <li>- Шаардсан агуулга нь хууль бус буюу хууль бус ажилтай холбоотой байх тохиолдолд</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хахуулийн хэмжээ 10 саяас доош</li> <li>- Өөрөө мэдэгдсэн тохиолдолд</li> </ul>
Ердийн шалгуур шалтгаан	<ul style="list-style-type: none"> <li>- 2 жилээс дээш урт хугацааны хээл хахууль</li> <li>- 3-р зэргээс дээш албан тушаалтан</li> <li>- Өмнө ижил хэрэгт холбогдож байсан буюу төстэй үйлдэл хийж байсан тохиолдолд</li> <li>- Гэмт хэргийг нуун дарагдуулах оролдлого хийсэн</li> <li>- Хууль бус үйлдэл хийсэн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хамтран оролцсон</li> <li>- Мөрдөн шалгах ажиллагааны өмнө буцаан өгсөн</li> <li>- Удаан хугацаанд хичээнгүй ажил хийсэн</li> <li>- Эрүүл мэнд муу</li> <li>- Эдийн засгийн эх үүсвэрт өөрт нь байх</li> <li>- Өндөр настай</li> <li>- Эрүүгийн ял шийтгэл авч байгаагүй</li> </ul>

Харгалзан үзэх ёсгүй хүчин зүйлүүд

1. Нийгэмд нэр хүндээ алдах, нэр хүндээ алдах
2. Хууль бусаар олсон ашгийг хураах
3. Энэ хэрэгтэй холбоотой сахилгын арга хэмжээ

### 3. АВЛИГА ӨГСӨН ТОХИОЛДОЛД

Ангилал	Сөрөг	Эерэг
Гол шалгуур шалтгаан	<ul style="list-style-type: none"> <li>- 50 сая воноос дээш байсан тохиолдолд</li> <li>- Өмнө адил гэмт хэрэгт холбогдож байсан</li> <li>- Идэвхтэй шаардсан</li> <li>- Шаардсан агуулга нь хууль бус буюу хууль бус ажилтай холбоотой байх тохиолдолд</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хахуулийн хэмжээ 10 саяас доош</li> <li>- Дээд албан тушаалтан шаардсан</li> <li>- Идэвхтэй шаардсаны улмаас хүсэл зоригийн эсрэг хийсэн</li> <li>- Өөрөө мэдэгдсэн тохиолдолд</li> </ul>
Ердийн шалгуур шалтгаан	<ul style="list-style-type: none"> <li>- 2 жилээс дээш урт хугацааны хээл хахууль</li> <li>- 3-р зэргээс дээш албан тушаалтан</li> <li>- Их хэмжээний ашиг олсон</li> <li>- Нийгмийн хүрээнд харилцан холбоо тогтоох</li> <li>- Урт хугацааны</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Тэнсэн харгалзахаас өөр ял шийтгэл авч байгаагүй</li> <li>- Эрүүл мэнд муу</li> <li>- Эдийн засгийн эх үүсвэрт өөрт нь байх</li> <li>- Өндөр настай</li> <li>-</li> </ul>

**Шинэ тэнсэн харгалзах хөнгөвчлөх нөхцөл байдлын тодорхойлолт**

- Ялын хэмжээтэй ижил тэнсэн үзэх шалтгаан
- Энэ нь ял оноох хүчин зүйлийн тодорхойлолтын хэсэгтэй адил.
- Гэмт хэргийн ял эдэлсэн хугацааг тоолох
- Гэмт хэргийн ялын хэмжээ нь тэнсэн харгалзах шийдвэрийн хувьд шийдвэр гаргасан өдөр, биет ял нь гүйцэтгэсэн өдрөөс эхлэн гэмт хэрэг үйлдсэн үе хүртэлх тооцно.
- Урт хугацаанд хичээнгүй ажилласан тохиолдолд
- 20-оос дээш жил ажилласан төрийн албан хаагч буюу зуучлагч болохын хувьд эрүүгийн ял шийтгэл байхгүй идэвхтэй ажилласан тохиолдлыг хэлнэ.

**Шинжилгээнд хамрагдах хөнгөвчлөх нөхцөл байдлыг үнэлэх зарчим**

1. Ялын хувьд хорих ял байх тохиолдолд тухайн ялыг гүйцэтгэх эсэхийг тодорхойлохдоо ерөнхий нөхцөл байдлаас илүүтэй чухалчилж үзэхийг зарчим болгох бөгөөд дараах зүйлийг шалгуур болгодог.
2. Хоёр ба түүнээс дээш гол эерэг шалтгаантай эсвэл гол эерэг шалтгаан нь сөрөл шалтгаанаас 2 шалгуураас дээш байх тохиолдолд тэнсэн харгалзаж үзэхийг зөвлөдөг.
3. Сөрөг шалтгаан 2 ба түүнээс дээш буюу сөрөг шалтгаан нь эерэг шалтгаанаас 2 шалгуураас дээш байх үед биет ял өгөхийг зөвлөдөг.
4. 1 ба 2-т хамаарах боловч сөрөг (эерэг) шалтгаан ба ерөнхий эерэг (сөрөг) шалтгаануудын тооны зөрүү нь гол эерэг (сөрөг) шалтгаан ба гол сөрөг (эерэг) шалтгаануудын тооноос их, дээрх 1 эсвэл 2-т хамаарахгүй бол тэнсэн харгалзах шалтгааныг цогцоор нь харьцуулж, шийдвэрлэдэг.





ISBN 991952908-7



9 789919 529086